

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

2014 ОНЫ 10 САР. №16 (074)

ЭДИЙН ЗАСАГ

Д.ЭНХБАТ: МОНГОЛ ДЭЛХИЙН
НЭЭЛТТЭЙ МЭДЛЭГ МЭДЭЭЛЛИЙН
ДАВАЛГААНД НЭГДЭХ ЁСТОЙ

ИЛТГЭЛ

УУЛ УУРХАЙ-ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
-ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

ҮҮЛЭН ЧӨЛӨӨНИЙ
НАРЫГ ҮҮРДИЙН
БОЛОМЖ БОЛГООСОЙ





ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ БАРЬЦААЛСАН

ХЯЛБАР ЗЭЭЛ

**ХЭРЭГЛЭЭНД ТАНЬ
НИЙЦҮҮЛСЭН ЗЭЭЛҮҮД**



MONGOLIAN MINING DIRECTORY 2015



МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН НЭГДСЭН ЛАВЛАХ

Монголын уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй бүх уул уурхайн компани, хөрөнгө оруулагч компани, ханган нийлүүлэлтийн болон уул уурхайн салбарт үйлчилгээ үзүүлэгч аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус бүх байгууллагын нэгдсэн мэдээллийг хүргэдэг “МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН НЭГДСЭН ЛАВЛАХ” номыг тав дахь жилдээ эрхлэн гаргах гэж байна. Тус ном нь гадаад, дотоодын уул уурхайн компани, Олон улсын хурал үзэсгэлэн болон Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, гадаад улсад суугаа Монголын Элчин сайдын яамдаар дамжуулан хөрөнгө оруулагч нарт үнэ төлбөргүй хүргэгддэг онцлогтой.

Монголын уул уурхайн салбарынханд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хамгийн хүртээмжтэй хүргэхийг хүсч буй та бүхнийг “МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН НЭГДСЭН ЛАВЛАХ -2015” номтой хамтарч ажиллахыг урьж байна.

**МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА
БАЙРШУУЛАХ ЗАХИАЛГА
ЯВАГДАЖ БАЙНА**

70115590



Дэлгэрэнгүй мэдээллийг

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, МҮЭСТО-300 тоот

Утас: +976-70115590, Факс: +976-70125590

И-мэйл: marketing@mining.mn, book@mining.mn, Веб: www.mining.mn



ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС

Намар оройн сэрүүнд анхны цасны хүйтэн амьсгалтай золгон байгаа Монголчууддаа “Mongolian Economy” сэтгүүл ургацын ундратай шинэхэн дугаараа хүргэж байна. Монгол Улс хөдөө аж ахуйн орон гэгддэг үе уул уурхай хүч түрэн орж ирсэн он жилүүдэд бүдгэрсэн. Тэгвэл уул уурхайн хөгжлийн цикл урууддаг үе дээрээ ирчихээд байгаа энэ үед Монголын эдийн засгийг авч явах дараагийн тулгуур салбар юу байх вэ гэдгийг бодох цаг ирсэн. Энэ талаар төр, засгийн түвшинд дорвитой зүйл яриагүй байгаа ч эдийн засагч, судлаачид, улсынхаа хөгжлийн төлөө ухаан бодлоо уралдуулах дуртай залуус хэдийнэ хөдөө аж ахуй бол тэргүүлэх салбар байж болох юм гэдгийг тойрон ярилцаж, тодорхойлоод эхэлжээ. Манай сэтгүүлийн зүгээс ч гэсэн монголчуудыг эрт дээр үеэс хоолтой ундтай байлгаж ирсэн хөдөө аж ахуйн салбарт дахин хөгжлийг түүчээлэн хөгжих боломж гарч ирж байна гэдэгтэй санал нэг байна. Тийм учраас энэ удаа тус салбарын нэг багана болсон газар тариалангийн салбарын боломжийн талаар дугаарынхаа онцлох нийтлэлүүдээр хөндлөө.

Манай энэ удаагийн дугаараас талх тарианы үнэ ямар байхаас авахуулаад газар тариалангийн өсөлтийг харж болох бөгөөд энэ салбарт тулгамдаж буй асуудал, боломж, цаашид ямар бодлогоор дэмжин хөгжүүлэх ёстой вэ гэдэгт эрхэм уншигч таны анхаарлыг хандууллаа.


Мөн эрдсийн бүтээгдэхүүний жишиг үнийн талаар уул уурхайнхан төр засгийн анхааралд хүргэх чухал асуудал хэлэлцсэнийг хүргэж байна.

Монголын даатгалын зах зээлд эрүүл мэндийн даатгалын чиглэлээр олон улсын туршлагыг нэвтрүүлэхээр орж ирж буй АХА компанийн Ази, Номхон далайн бүсийн давхар даатгалын зах зээлийг хариуцсан захирал Лорен Пушет Котиллутай манай сэтгүүлч сонихролтой ярилцлага хийжээ.

Манай сэтгүүлч Монголбанкны баг, сэтгүүлч нөхдийн хамт БНСУ-д томилолтоор ажилласан аяны богцоо задалж байна.

Тариатай, үнэ ханштай, даатгалтай, томилолттой бас бус сонирхолтой мэдээлэлтэй манай шинэхэн дугаарыг амтархан уншихад таатай байна гэдэгт итгэлтэй байна.

Орлогч эрхлэгч И.ОТГОНЖАРГАЛ



МОНГОЛД

Уул уурхай



Оюутолгойн төлөхөөр байсан 130 сая ам.долларын татварыг хоёр тал ярилцсаны үндсэн дээр 30 сая ам.доллар болгож буурууллаа. “Оюу Толгой”-н далд уурхайн шинэчилсэн ТЭЗҮ-ийг боловсруулж дууссан болохоо “Turquoise Hill Resources” мэдээлээд байна. Энэ тодотголоор далд уурхайн санхүүжилт 4.9 тэрбум ам.доллар болж өмнөхөөсөө өссөн. Хэрэв тус компанийн Төлөөлөн Удирдах зөвлөл шинэчилсэн ТЭЗҮ-ийг баталсан тохиолдолд Эрдэс Баялгийн Зөвлөлд хүлээлгэн өгөх юм. Ингэснээр далд уурхайн санхүүжилт шийдэгдэх боломж бүрдэнэ.

Аялал жуулчлал



Улаанбаатар хотод ирэх жуулчдын тоог 2030 он гэхэд таван саяд хүргэх зорилттой “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал хэлэлцэн баталсан. Энэхүү хөтөлбөр нь нийслэлийн эдийн засагт аялал жуулчлалын салбарын эзлэх хэмжээг 20 хувьд, аялал жуулчлал, зочлох үйлчилгээний

салбарт ажиллагсдын тоог 35 мянгад хүргэхээр зорьж буй. Мөн энэ жилээс эхлэн Нийслэлээс тус салбарын хөгжилд 35 тэрбум төгрөг жил бүр төсөвлөхөөр зорьж байна. Ингэснээр манай улсын эдийн засаг 2.5 дахин нэмэгдэнэ гэсэн тооцоо бий.

Дэд бүтэц

Шинэчлэлийн Засгийн газар авто замын салбарт бүтээн байгуулалт хийснээр нийтдээ 2300 км зам хүлээж авсны 1800 гаруйг нь өнгөрсөн жил ашиглалтад оруулжээ. Тэгвэл энэ жил өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад доогуур үзүүлэлттэй гарч буй. Нийт 37 чиглэлд 1886.4 км зам, барилгын ажил хийнэ. Одоогийн байдлаар 900 орчим км зам хүлээж аваад байгаа аж. Төсөв санхүүгийн хүрэлцээгүй байдлаас болоод энэ онд төлөвлөсөн замын ажлаа гүйцээх боломжгүй байгаа аж.

Эдийн засаг

Нийслэлийн Статистикийн газраас гаргасан тоон мэдээллээр нийслэл хотод бүртгэлтэй автомашины өсөлтийн сүүлийн гурван жилийн үзүүлэлтийг авч үзэхэд жилд дунджаар 16.5 хувийн өсөлттэй гарчээ.

Өнгөрсөн оны техникийн хяналтын үзлэгийн дүнгээс харахад нийт тээврийн хэрэгслийн 71.6 хувийг зөвхөн суудлын автомашин эзэлж буй. Энэ тооноос харахад нийслэлд замын хөдөлгөөнд оролцож байгаа арван автомашин тутмын долоо нь суудлын автомашин байна. Түүнчлэн нийт суудлын автомашины 85 хувь нь иргэд, хувь хүмүүсийн эзэмшилд бүртгэлтэй байдаг байна. Хувийн эзэмшлийн автомашины

тоо хурдацтай нэмэгдэж байгаа нь замын хөдөлгөөний ачааллыг нэмэгдүүлэх үндсэн шалтгаан болж буйг тоон үзүүлэлт харуулж байна.

Эрчим хүч

“Амгалангийн дулааны станц”-ын бүтээн байгуулалтын ажил өнгөрсөн оны наймдугаар сарын 23-нд эхэлсэн ч газар чөлөөлөлтөөс шалтгаалан хугацаа алдсаар байна. Тус станцын эхний хэсгийг энэ ондоо багтаан хүлээлгэн өгөхөөр ажиллаж байгаа ч одоогийн байдлаар ажлын явц 75 хувьтай байгаа юм. “Амгалангийн дулааны станц” ашиглалтад орсноор УБ хотын Баянзүрх дүүргийн 20 гаруй мянган айл өрхийн дулаан цахилгааны хангамжийг шийдэх боломж бүрдэх бөгөөд ирэх арваннэгдүгээр сард ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа аж.

ДЭЛХИЙ ДАХИНД

Алибаба IPO



Хятадын цахим худалдааны “акул” Алибаба хөрөнгийн зах зээл дээрээс дэлхийн түүхэн дэх хамгийн өндөр дүн бүхий мөнгийг босгожээ. Тус компанийн хувьцаа нь асар богино хугацаанд зарагдсан бөгөөд ихээхэн өндөр үнэ хүрч чадсан байна. Ийнхүү Хятадын Ханжоу мужид

төв оффис нь байдаг Алибаба группын хувьцаа Нью-Йоркийн хөрөнгийн биржид ВАВА хэмээх нэрээр арилжаалагдах боллоо. Хэдийгээр тус компанийн хувьцааг худалдан авч, зарж болох ч тус компанийн хэсгийг эзэмших эрх гэсэн үг биш аж. Хятадын хуулийн дагуу тус улсын компанид гаднын эзэмшлийн хувь хэмжээг хориглодог.

Билл Клинтонь жагсаалтад Монгол

Туршлагатай улстөрч, АНУ-ын Ерөнхийлөгч асан Билл Клинтонь энэ хорвоог орхихоос өмнө хийж үзэхийг хүсдэг зүйл юу вэ хэмээх асуужээ. Тэрбээр үүнд “Би одоо болтол Монголд очиж үзээгүй. Би Монголын уудам тал дээгүүр морь унан давхиж, Чингис хааны морьтон баатруудын нэг байх ямар байсныг төсөөлж үзэхийг хүсдэг” хэмээн хариулжээ.

Энэтхэг-Хятадын харилцааны ээдрээ эргэн зангирлаа

Хятадын Ерөнхийлөгч Си Зиньпин өнгөрсөн долоо хоногуудад хөрш 14 улсуудаар албан ёсны айлчлал хийсний дотор Монгол Улс мөн багтсан. Тэрбээр энэхүү айлчлалаа АПЕК-ийн уулзалт Бээжинд болохоос өмнө амжиж хийлээ. Мөн Хятад болон Энэтхэгийн дипломат болон эдийн засгийн гэрээ хэлцэлүүдийг Хятадын Чөлөөлөх армийн 1000 цэрэг тус хоёр улсын маргаантай газар нутагт орсноор бүтэлгүйтсэнд тооцогдож эхэллээ. Хэдийгээр тус айлчлалыг хэвлэл мэдээллээр найрамдалт харилцааг сэргээх том алхам гэж үзэж байсан ч тохиолдлын чанартай цагаа олоогүй

үйл явдал нь хоёр орны тэргүүнүүдийн асаасан галыг унтрахад хүргэлээ.

Туркийн хэвлэл мэдээлэлд “эрх чөлөө үгүй”



Турк улс Хятад болон Ираны дараа орох дэлхийн тэргүүлэх хэвлэл мэдээллийн шоронд тооцогдож байна. “Freedom House” Турк улсыг хэвлэлийн эрх чөлөөний хувьд “Хагас нээлттэй” гэж үнэлж байсан ч энэ оны хэвлэл эрх чөлөөний үзүүлэлтээр үүнийгээ өөрчлөн бууруулж, “эрх чөлөөгүй” хэмээх ангилалд оруулжээ. Турк улсад 2002 онд Ерөнхийлөгч Эрдоганы Шударга ёс, Хөгжлийн нам төрийн эрх авснаас хойш тус намын эсрэг үзэл санаатай гадаад дотоодын хэвлэл мэдээллийн ямар ч бүтээлийг шахан хавчиж, сэтгүүлчдийг нь улсаасаа гаргах, баривчлах, мэргэжлээрээ ажиллахгүй болгох зэрэг нугачин дарах үйл ажиллагааг хүчтэй явуулж эхэлсэн юм. Турк нь одоогоор 11 сэтгүүлчийг шоронд хориод байгаа улс. Өнөөдрийн байдлаар тус улсын томоохон хэвлэл, телевизүүдийг 10 том бизнес эрхлэгч эзэмшдэг бөгөөд тэдгээр нь Засгийн газрын эсрэг мэдээ, мэдээлэл явуулдаггүй. Учир нь лээрх бизнесмэнүүд төрийн тусламжийг хэвлэл мэдээллийн бус салбарт явуулдаг үйл ажиллагаанууддаа ихээхэн хүртдэг байна. Хэвлэл мэдээлийн дийлэнх нь төрийн үйл ажиллагааг сурталчилсан өнгө аястай байдаг. ■



МОНГОЛ

ЖИРГЭЭНИЙ ЕРТӨНЦӨД

Викиликс @wikileaks 14/09 **#Монгол улс** Германы иргэдээ хянах аргачлалыг ашигладаг <https://wikileaks.org/spyfiles4/customers.html> ...

Монголын хууль сахиулагч, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд иргэдээ мөрдөхөөр “Weaponised surveillance software” худалдан авсан уу? Дотоодоо хянах зорилготой үйл ажиллагаанд Засгийн газар нэг сая орчим евро зарцуулдаг.

Freedom Online @EO_Coalition 25/08 Могнолд зохион байгуулагдах **#FOC** хурлын бэлтгэл ажил эхэлж байна **#FOC15 @Badrals @SimoneHalink @leakaspar**

Цахим ертөнцөд хүний эрх зөрчигдөж буйтай Монголын Засгийн газар тэмцэж эхэлсэн үү? Монгол Улс цахим ертөнц дахь хүний эрхийг хамгаалах зорилго бүхий Freedom Online холбоог даргалж байна. FO-ийн удаах хурал 2015 онд Улаанбаатар хотноо болно.

OFID @OFID_Opec_Fund 11/09

OFID **#Монгол Улсын @Хасбанкинд** жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 20 сая ам.долларын туслалцаа үзүүлэхээр болжээ. <http://bit.ly/1qMUBcD>

Хасбанкны зээлийн багцны 50 гаруй хувь нь жижиг, дунд үйлдвэрлэлд чиглэсэн зээл байдаг.

Лиса Гарднер @leesebkk 24/09

#Монголын хэвлэлийн эрх чөлөөний үнэлгээ муу хэвээр байгаа нь өөрчлөлт, шинэчлэлийн явц удаан байгаатай холбоотой **#медиа** <http://www.media-update.org/countries/mongolia/>

Ази-Номхон далайн бүсийн орнуудын хэвлэлийн эрх чөлөөний тухай судалгаанд Монгол Улсын ерөнхий үнэлгээ 2014 оны эхний хагаст муудсан үзүүлэлттэй гарсан нь сэтгүүлчдийг хамгаалах асуудал сул, эрх баригчдыг хамгаалах хууль эрх зүйн орчин чанга байгаатай холбоотой.

D.Naranzul @naranzuld

#1930 онд Улсын хэмжээнд нэг цэцэрлэгт 15 хүүхэд хүмүүжиж байсан бол өнөөдөр 1067 цэцэрлэгт 193672 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна.

Товч мэдээ, мэдээлэл @hiubmn

ҮСХ 2015 оны II улирлын эхээр **#3.0 сая дахь иргэн** төрнө гэж тооцоолсон ч төрөлтийн эрчимтэй өсөлтөөс шалтгаалж үүнээс өмнө төрөхөөр байна.

Н.Ганбямба @nganbyamba

Энэ жил **#Татвар төлөгчдөөс** 6 триллионы орлого олно. Үүнээс 5.3 триллион төгрөг нь урсгал,захиргааны зардал болон **#ДАРГА НАРЫН** зарлага.



ГАРЦ

ҮҮЛЭН ЧӨЛӨӨНИЙ НАРЫГ ҮҮРДИЙН БОЛОМЖ БОЛГООСОЙ

Улсын хэмжээнд 293 мянган га-гаас 439 мянган тонн улаан буудай хураан авна

И.ОТГОНЖАРГАЛ

Монголын эдийн засгийг нэг хэсэг түүчээлсэн уул уурхайн хурд саарсан нь эдийн засгийг авч явах дараагийн салбар юу байж болохыг бодож, тодорхойлох боломжийг олгож буй үүлэн чөлөөний нар гэлтэй. Үүнтэй холбоотой дараах ишлэлийг зориуд цохон тэмдэглэмээр санагдлаа.

“... Монголын эдийн засагт ямар салбар өсөлтийг, ямар салбар тэнцвэрийг бий болгож буйг ажиглах хэрэгтэй. Ялангуяа эдийн засаг ийм саармаг байгаа үед дараагийн ажлын байрыг хадгалах салбараа дэмжих ёстой. Жишээлбэл, хөдөө аж ахуй. Ямар ч хямралын үед эдийн засгийг тогтоон барьж чаддаг, хүн амыг хоол хүнсний дутагдалд орохоос хамгаалах хамгийн гол тулгуур

салбар. Иргэдийн эн тэргүүний хэрэгцээ болсон хүнсний хангамжийг нийлүүлдэг энэ салбар уналтад орвол юу болох вэ...” хэмээн Дэлхийн банкны төвд ажилладаг Н.Энхбаяр манай сэтгүүлчид өгсөн ярилцлагадаа ийн өгүүлсэнийг нийтлэлийнхээ өмнө ишлэхэд илүүдэхгүй гэж бодлоо. Тийм ээ, уул уурхай, дэд бүтэц гэж хошуурсан сүүлийн жилүүдэд төр засгийн зүгээс хөдөө аж ахуйг бараг мартсантай адил болсон. Манай сэтгүүл уул уурхайн салбар уруудсан энэ үед хөдөө аж ахуйн салбар дахь боломжийг харуулах зорилгоор энэ чиглэлээр байнга бичих болно. Энэ удаа орон даяар ургац хураалтын их ажил эхэлсэнтэй уялдуулаад тариа будаа хэр хурааж, ирэх жил талх тарианы үнэ ямар байх, газар тариалан үүлэн чөлөөний нарыг

ашиглаж дэмжлэг авч дээшээ гарч ирэх салбар мөн үү гэдгийг танадахыг оролдъё. Газар тариалангийн бодлого барьж буй яамны удирдлагууд энэ чиглэлээр юу бодож санаж явдаг бол. Шинэчлэлийн Засгийн газарт Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын албыг хоёр жил гаруйн хугацаанд хашсан Х.Баттулгын хувьд мах, гурилын үйлдвэрлэлийн үр өгөөжийг сайн мэдэх төдийгүй өөрийнх нь бизнесийн нэг хэсэг нь хүн ардыг хоол хүнсээр хангах үйлсэд чиглэгддэг. Гэсэн хэдий ч тэрбээр сайд байх хугацаандаа хөдөө аж ахуйг ярихаасаа илүүтэй хүнд үйлдвэр, төмөр зам, дэд бүтэц гэж түлхүү ярьдаг байсныг бид мэднэ. Тус салбарын шинэхэн сайд Ш.Түвдэндоржийн хувьд томилогдоод төдийлэн удаагүй ч намрын ургац хураалт, өвлийн бэлтгэлийн асуудлаар»

хоёроор тогтохгүй бий. Дэд сайд Ц.Туваан нь эмч мэргэжилтэй ч энэ албанд очсоноосоо хойш яамныхаа газар тариалангийн чиглэлийн асуудлыг түлхүү хариуцдаг учраас төрийн хүмүүст болон дотоод, гадаадын ямар ч хүнд салбараа ойлгуулаад байх дайны болсон байх талтай. Төрийн нарийн бичгийн дарга Х.Золжаргалын хувьд энэ чиглэлийн бодлогыг гайгүй сайн ярьчих туршлагатай нэгэн.

Газар тариалан руу гар мухар орж байсан тариаланчид гарамгай шинэчлэл хийж чадлаа

Шинэ засгийн газар гараад эхдээ гологдсон хурга шиг орхигдсон газар тариалангийн салбар сүүлийн 4-5 жилд өсөлттэй яваа. Өсөлтийн гол үндэс нь 2008 онд эхлүүлсэн “Атрын III

хүнсний бус буцалтгүй тусламжийн хүрээнд газар тариалангийн техникийн шинэчлэлийг эхлүүлэх, дэмжих бодлого барьж 1994 оноос 100, 200 морины хүчин чадалтай трактор, үр тарианы комбайн тасралтгүй нийлүүлж эхэлснээр тариаланчид газар тариалангийн орчин үеийн техниктэй танилцсан. KR 2 хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэх техникийн хүчин чадал, тоо хэмжээ, нэр төрөл жилээс жилд нэмэгдсээр байв. Үүнээс гадна 2008 онд С.Баярын Засгийн газар “Атрын III аян”-ыг зарлаж, стратегийн хүнсний бүтээгдэхүүн улаан буудайн үйлдвэрлэлийг сэргээх зорилго өвөртлөхдөө ч нэн тэргүүнд технологийн шинэчлэлийг авч үзсэн. Ингэхдээ техникийн шинэчлэл, үрийн шинэчлэлийг чухалчилсан. Тиймээс аяны хүрээнд зөвхөн техник технологийн шинэчлэлд улсын төсвөөс 54 тэрбум төгрөг гаргасан байдаг. Өнөөдөр манайхан зурагтаар

“Энэ жилийн хувьд дотоодын ургацаар гурилын хэрэгцээг бүрэн хангах нөхцөл бүрдсэн учраас гаднаас улаан буудай, гурилын импорт байж болохгүй, нөгөө талаас тариаланчдаа дэмжих ёстой” хэмээн Ерөнхийлөгч Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны удирдлагуудад хатуу анхааруулсан юм.

Гэрэл зургийг Г.Эрдэнэтуяа

▶ хэвлэлд дорвитой мэдээлэл өгсөн зүйл одоогоор алга. Түүнийг энэ салбарын бодлогыг сайн авч явах уу, саар удирдах уу гэдгийг одоогоор хэн ч хэлж мэдэхгүй. Тэрбээр яаманд очсоноосоо хойш их л чимээ аниргүй суугаа. Харин очсон даруйдаа яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргыг мэргэжлийн бус хуульч эрх зүйч мэргэжилтэй Б.Оргил гэдэг залуугаар солиод амжсан. Харин өөрөө бол намрын ургацын үеэр тариан талбайд хэд хэд очих шиг боллоо. Хамгийн сүүлд Ерөнхийлөгчтэй Сэлэнгэ аймагт ажилласан. Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт одоогоор олон жил ажилласан, газар тариалангийн мэргэшсэн, туршлагатай мэргэжилтнүүд нэг

аян”-ы үр дүн гэдэгтэй хэн ч маргахгүй. Үүний үрээр улаан буудай, төмснийхөө хэрэгцээг дотоодын ургацаараа хангадаг болсон.

Тэртээх он жилүүдэд Сангийн аж ахуйнууд тарж, Монголын газар тариалан элгээрээ хэвтсэн ч ерээд оны дундаас хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд чадах чинээгээрээ авч явж эхэлсэн боловч тухайн үед тариан талбайд хуучин ЗХУ-ын ганц нэг трактор, комбайны үлдэгдлээс өөр зүйл байгаагүй. Үндсэндээ Монголын шинэ үеийн тариаланчид хувийн аж ахуйтай болох сайхан мөрөөдөлдөө хөтлөгдөн гар мухар газар тариалан руу орж байв. Техникгүй нэг хэсэгтээ л зовсон, тэд. Ийм байдалтай бараг 2000 онтой залгасан санагдана. Харин Японы Засгийн газрын KR 2

гайхан хардаг байх үр тарианы томоохон аж ахуйн нэгжийн талбайд өндөр хүчин чадлын, нэг явалтаар олон үйлдэл зэрэг гүйцэтгэх хүчин чадалтай үр тарианы комбайн, хөрс боловсруулах чиргүүл дүүжин машин, тракторууд хөнгөнөн буйг. Монголын газар тариалан сүүлийн арав хүрэхгүй жилийн дотор техникийн шинэчлэлийн хувьд төрөл арилжсан мэт шинэчлэгдэж чадсан. Ялангуяа үр тарианы аж ахуйн нэгжүүдийн техникийн шинэчлэл үнэхээр гайхалтай. Өдгөө манайд ОХУ, Герман, Канад, Хятад, Украин, Беларус зэрэг орны хөдөө аж ахуйн орчин үеийн техникүүд ажиллаж байна. Эдгээр орны хөдөө аж ахуйн үйлдвэрийн брэнд техникүүдийг худалдан борлуулах Төлөөлөгчийн газрууд ч Монголд хэдийнэ төвхнөсөн. Газар ▶

▶ тариалан “Атрын III аян”-ы хүрээнд дэвшүүлсэн зорилтоо биелүүлж ийнхүү сэргэн хөгжиж чаджээ. Мэдээж өнөөдрийн үр дүнг дан ганц аян зарласны нөлөө гэвэл өрөөсгөл. Өнгөрсөн долоон жилийн хугацаанд байгаль цаг уур газар тариаланд ээлээ өглөө. Хэрвээ цаг уурын байдал 2000 оны эхэн үе шиг жил дараалан ган, зуд болоод байвал хэчнээн аян зарлаад үр дүн гарахгүй.

Монгол Улсын Ерөнхийлөгч өнгөрсөн сарын дундуур Сэлэнгэ аймагт ажиллахдаа газар тариалангийн дээрх үр дүнг хараад “Монголд газар тариалангийн шинэ эринийг эхлүүлэх цаг ирлээ. Өнөөдрийн хүрсэн түвшингээ алдахгүй. Улам ахиулахын төлөө явах хэрэгтэй” хэмээн тариан талбайд тариаланчдын төлөөлөл болоод Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны удирдлагуудад анхааруулсан.

Энэ намар л гэхэд ургац өмнөхөөс ч арвин байна. Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамнаас гаргасан ургац хураалтын урьдчилсан тооцоогоор 293 мянган га-гаас 439 мянган тонн улаан буудай хураан авах нь. Энэ нь дотоодын хэрэгцээнд элбэгдээд илүү гарна. Цаг агаар сайхан байгаад ургацаа хугацаанд нь бүрэн хурааж чадвал шүү дээ. Баярлахад арай л эрт байгаа юм. Ургац хураалт улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар /2014.08.25/ тавин хувьтай байна. Улаан буудайн га-гаас авах ургацын хэмжээ улсын тогтоосон балансаас 1-2 центнерээр илүү байгаа аж. “Бороо, цас орж байгаа нь ургац хураалтын ажилд саад болж байгаа бөгөөд энэ байдлаараа аравдугаар сарын 10 гэхэд хураалт дуусах байх” хэмээн тариаланчдын төлөөлөл ярьсан. Тариа өтгөн, өндөр ургасан учраас нийт талбайн 80 гаруй хувьд нь ангилан хадалт хийж буй. Ангилан хадалт хийж нэг га-д хоёр дахин явж байгаа нь шатахууны зарцуулалтыг нэмэгдүүлж, га-гийн ургацын өртөг нэмэгдэх шалтгаан болж байгаа аж. Сүүлийн хоёр жилд улаан буудайн дотоодын хэрэгцээгээ зуун хувь хангах хэмжээнд хүрч том дэвшил гарсан ч жил бүрийн намар босож ирдэг нэг асуудал бол улаан буудайн худалдан борлуулах зах зээлийн үнэ хэд байх вэ гэдэг.

Нэг тонн улаан буудайн бодит үнийг тооцож гаргаж болохгүй юү?

Төрөөс жил бүрийн хаврын тариалалт, намрын ургац хураалтын үеэр дэмжлэг болгож үр, шатахуун, ургамал хамгааллын бодис зэргийг тариаланчдад 30 хувийн урьдчилгаатай зээлээр олгодог уламжлалтай. Төрийн дэмжлэгийн үлдэгдэл мөнгөнд нь намрын ургацаас улаан буудай авахаар зохицуулдаг. Энэ ажлыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны дэргэдэх Тариалан эрхлэлтийг дэмжих сан хариуцдаг. Тариаланчдаас намар өрөнд буудай авахаас гадна стратегийн хүнс болох улаан буудайн үр нөөцлөх ажлын нэг хэсгийг мөн Тариалан эрхлэлтийг дэмжих сан үүрдэг. Тиймээс тус сангаас намар ургац хураалт эхлэх үеэр нэг тонн улаан буудайг улсад худалдан авах үнийг зарладаг. Уг үнийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын тушаалаар баталдаг. Энэ жил тус сан нэг тонн улаан буудайг үтрэм нөхцөлөөр 460,000 төгрөгөөр авна гэж зарласан нь тариаланчдын хөдөлмөрийг бага үнэлсэн, ам.долларын ханшийн өсөлтийг умартсан маш чамлалттай үнэ гэж тариаланчдын төлөөлөл үзсэн. Тиймээс тэд Ерөнхийлөгчийг Сэлэнгэ аймагт ажиллах үеэр буудайн үнийг улс хямд зарласан гэдгийг хэлж, “шийдүүлсэн”. Ерөнхийлөгч тариан талбайд тариаланчдын болоод салбарын бодлого тодорхойлогчдын аль алиных нь байр суурийг сонсож, гурил үйлдвэрлэгчид, тариаланчид, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам гурав нэг ширээнд сууж, ойлголцохыг зөвлөсөн. Үүний дагуу холбогдох байгууллагууд өнгөрсөн сарын 18-нд гурван талт хэлэлцээрт сууж нэг тонн улаан буудайн худалдан борлуулах үнийг 550 мянган төгрөгөөр агуулах нөхцөлөөр авахаар тохиролцсон юм. Ингэснээр гурилын үнэ тодорхой хэмжээнд нэмэгдэх нөхцөл үүсэх магадлалтай. Уг нь Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны зүгээс гурилын үнийг барих бодлогоор улсад тушаах улаан буудайн үнийг хэт өндөр зарлахгүй гэсэн бодлого барьдаг.

2012 оноос Монголбанк, Засгийн газартай хамтран “Тол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн ч гурилын

үнэ бага багаар нэмэгдсээр энэ оны эхний найман сарын байдлаар 30 хувиар өссөн статистик гарсан. Нөгөө талаас Монголд том, жижиг нийлсэн 80-аад гурилын үйлдвэр үйл ажиллагаа явуулж буй бөгөөд тэдний зүгээс дотоодын улаан буудайг аль болох хямд авахыг хичээдэг. Тэд тариаланчид буудайгаа өндөр үнээр зарна гэхээр ОХУ-аас хямд үнэтэй улаан буудай импортлоно гэж сүрдүүлэх нь ч бий. Гурил үйлдвэрлэгчдийн хувьд бүтэн жил үйлдвэрлэл явуулах түүхий эдээ нэг дор базаана гэдэг амаргүй маш их мөнгө шаардлагатай.

“Энэ жилийн хувьд дотоодын ургацаар гурилын хэрэгцээг бүрэн хангах нөхцөл бүрдсэн учраас гаднаас улаан буудай, гурилын импорт байж болохгүй, нөгөө талаас тариаланчдаа дэмжих ёстой” хэмээн Ерөнхийлөгч Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны удирдлагуудад хатуу анхааруулсан юм.

Манай гурилын жилийн нийт хэрэгцээг аваад үзэхэд Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны судалгаагаар жилдээ 290 мянган тонн гэсэн тоо байдаг. Харин гурил үйлдвэрлэгчдийн зүгээс сүүлийн жилүүдэд монголчуудын ▶





Үр тарианы аж ахуйн техникийн шинэчлэлийн өнөөдрийн түвшинг улам сайжруулах шаардлагатай байна.

Гэрэл зургийг Г.Эрдэнэтүяа

► хоол хүнсний хэрэглээний нэр төрөл эрс нэмэгдэж байгаа учраас гурилын жилийн хэрэглээ багасаж 200-гаад мянган тонн болсон гэж мэдээлж буй. Ямартай ч Монголд өндөр хүчин чадалтай орчин үеийн гурилын үйлдвэр олон болсон. Тиймээс монголчууд гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр дутагдах гачигдахын зовлонгүй, зуун хувь дотоодын чанартай, шинэ хүнсээр хангагдах нөхцөл бүрдэж байгаа нь тун сайн зүйл юм.

Намрын намарт босож ирдэг асуудал болох нэг тонн улаан буудайн үнийг энэ удаа гурван тал тохиролцож чадлаа. Гэхдээ энэ нь бүрэн дүүрэн шийдвэрлэгдчихлээ гэсэн үг биш. Дараа жил дахиад л босож ирнэ. Уг нь бол хувийн хэвшил хувийн хэвшилтэйгээ тохиролцоод явах зүйлд заавал төрийг татан оролцуулах хэрэг байна уу. Тэгэхээр Засгийн газар гурилын үнийг ч зах зээлд нь даатгах хэрэгтэй болно. Харин энэ асуудлыг аль аль талд нь ашигтай байх бодит үнэлгээ тогтоох асуудал үгүйлэгдэж байгаа юм. ХААИС-ийн эдийн засаг, бизнесийн сургуулийн багш нар болон

судлаач, эдийн засагч нар нэг тонн улаан буудайн бодит үнийг тооцож гаргаж болохгүй гэж үү. Хэрвээ бодит үнийг гаргаад ирэх юм бол он удаан жил явсан маргаан шийдэгдэж хэн хэндээ хардаж сэрдэх зүйлгүй амар болох юм.

Сааль хадгалах саваар айлтгүй

Ургац ахиу хураасан жил агуулах сав байхгүй тариа будаагаа үтрэм дээр гахай шувууны хоол болгож байсан гашуун сургамж бидэнд бий. Үр тариан дээр ч, төмсний үйлдвэрлэл дээр ч ийм таагүй зүйл болж байсан. Тэгвэл энэ жилийн хувьд улаан буудай хадгалах агуулах сав хангалттай бий гэнэ. Тариалан эрхлэлтийг дэмжих сан, гурилын үйлдвэрүүд, тариаланчдын өөрсдийнх нь агуулах нийлэхээр ямар ч гэсэн саалиа хадгалах саваар айлтгүй болжээ. Үр тариа хадгалах элеваторын багтаамж 2008 онд 64000 тонн байсан бол өдгөө 146000 тоннд хүрсэн байна. 2013 онд гэхэд KR-2 төслийн хүрээнд Төв аймгийн Угтаалцайд 36000 тоннын элеватор ашиглалтад оруулсан

байх жишээтэй. Үр тарианы элеватор, төмс, хүнсний ногооны зоорийн хэмжээг инфографикийн нүүрээс сонирхоорой.

За тэгээд төмсний үрийн шинэчлэлийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтраад бүрэн шинэчилжээ. Буудай, төмснийхөө дотоодын хэрэгцээг зуун хувь, хүнсний ногооныхоо 54 хувийг хангаж буй. Одоогийн Засгийн газар 2016 он гэхэд хүнсний ногооныхоо дотоодын хэрэгцээг зуун хувь хангана гэсэн зорилт тавьсан. Тариалангийн нийт эргэлтийн талбай өдгөө 750 мянган га-д хүрсэн. Атрын III аянаар эргэлтийн талбайг 660 мянган га-д хүргэнэ гэсэн зорилт ийн даван биелжээ. Мэдээж Шинэчлэлийн Загийн газар Чингис бондын мөнгөнөөс хөдөө аж ахуй тэр дундаа хүлэмжийн аж ахуйн төсөлд чамлахааргүй мөнгө зарцуулж, хийсэн ажил, хийж байгаа зүйл бий.

Гэхдээ төмс, хүнсний ногооны борлуулалт хүндрэлтэй хэвээр, үр тарианы үйлдвэрлэлийн өнөөдрийн хүрсэн түвшинг алдахгүй ахиулж явахын тулд төрийн зөв дэмжлэг, тогтвортой бодлого газар тариаланд зайлшгүй хэрэгтэй нь харагдаж буй. Цаг агаар дандаа ивээгээд байна гэж байхгүй. Мөн газар тариалан, мал аж ахуй хоёр зэрэгцэн оршиж чадах уу гэдэг асуудал улам бүр хурцадсаар байна. Стратегийн хүнсний бүтээгдэхүүн болох улаан буудайн талбайгаасаа ургамлын тосны тарималд алдсаар байх уу. Уринш-буудай гэсэн хоёрхон сэлгээтэй газар тариалан хол явах уу. Тариаланчид өнгөрсөн хугацаанд тарихаа л мэдэж байснаас тордохоо мартаж удтал явсан хөрсний үржил шим өдгөө ядаргаанд орсон хүн шиг болсон гэх. Энэ бүхэн газар тариаланд төрийн шинэ бодлого, тариаланчдаас шинэ бизнес төлөвлөгөөг шаардаж буй юм. Нийтлэлийн эхэнд үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны удирдлагууд, мэргэжилтнүүдийн ажилдаа хэр гаршиж, мэргэшиж байгааг дурьддаг нь үүнтэй холбоотой. Хөл дээрээ тэнцэн босож чадсан салбараа цааш нь зөв дэмжиж авч явах улмаар ухаанаа уралдуулж уул уурхай биш, хөдөө аж ахуйг Монголын тэргүүлэх салбар болгон дахин амьдруулах алтан боломж өнөөдөр зөвхөн тэдний гарт ►►

▶ атгаастай байгааг хэлэх гэсэн хэрэг.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн М.Ариунболд “Манай яам салбарынхаа эрдэмтэн мэргэжилтнүүд, их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, тариаланч, хэрэглэгчдийн төлөөллийг оролцуулж Газар тариалангийн тогтвортой хөгжил хөтөлбөр 2014-2024” гэсэн нэлээд сайн баримт бичгийг боловсруулсан. Н.Алтанхуяг Ерөнхий сайд өөрөө үүнийг санаачлаад, манай яамны ажлын хэсгийг 11 удаа хүлээн авч уулзаж, хэлэлцүүлгийг удирдсан. Батлагдах юм бол өгөөжөө өгөхөөр сайн хөтөлбөр. I үе шат: 2014-2016 он Эрчимжүүлэн хөгжүүлэх, II үе шат: 2017-2020 он Импортыг орлон, экспортыг нэмэгдүүлэх, III үе шат: 2020-2024 он Тогтвортой хөгжих гэж ангилж авч үзсэн байгаа” гэв. Тухайлбал, тус хөтөлбөрт 2025 он гэхэд тариалангийн нийт эргэлтийн талбайг 1.0 сая га-д хүргэх зорилт тавьсан байна. Социализмын үед 1,2 сая га эргэлтийн талбайтай байсан. Өдгөө үүний 200 мянган га газрыг малын бэлчээрт шилжүүлж байгаагаас гадна эвдэрч сүйрсэн нь ч бий. Үүнээс гадна

монголчууд чанартай мах, өндөг зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн идэхийн тулд тариалангийн өөр олон төрлийн сэлгээний тарималд шилжихээс аргагүй цаг үе ирэв. Хамгийн наад зах нь төрөл бүрийн тэжээлийн ургамал тариалах хэрэгцээ шаардлага бий. Гэхдээ хэрэгцээ шаардлага бийг тариаланчид анзаарч байгаа ч тариад ургуулсан тохиолдолд борлуулалтаа бодохоор тийм гэгээтэй дүр төрх харагдахгүй байгаа учраас улаан буудай-уриншаасаа салж чадахгүй хаширлаж сууна. Энд эхний гаралгаа нь нэгэнт мал аж ахуйг хэчнээн хөөж тууж, нүд үзүүрлээд ч Монголд байх л ёстой учраас газар тариалан эрхлэгчид эрчимжсэн мал аж ахуйг хослон хөгжүүлэх нь зөв гэсэн тайлбар байдаг. Өөрөөр хэлбэл, сэлгээнд хөрснийхөө үржил шимийг сайжруулах зорилгоор тэжээлийн ургамал тариад түүнийгээ өөрийн аж ахуйдаа хэрэглэх. Ийм бодит жишээ манайд бий. Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын “Гацуурт” компанийг нэрлэж болно. Гэхдээ тариаланч бүр тус компани шиг том хөдлөх албагүй. Өөр өөрийн бүтэц онцлогт тохируулаад явах. Яваандаа эрчимжсэн аж ахуй эрхлэгчид нэмэгдэж, тэжээлийн үйлдвэр олширч бүтээгдэхүүний борлуулалт төвөггүй

болох ирээдүй ирнэ гэж бодоход буруудахгүй. Нөгөө талаас төр засгийн зүгээс энэ тал дээр зөв бодлого явуулах учиртай.

Хөдөө аж ахуйн шинэ сайдын анхааралд

Сүүлийн жилүүдэд тосны ургамал болох рапсыг тариан талбайтай болгон борлуулалт нь амар /хятадууд шууд өндөр үнээр худалдаад авчихдаг/ учраас хошууран тариалж буй. Олон улсын сатандартад рапсыг нийт тариалангийн талбайн 20 хувиас хэтрүүлэхгүй байх ёстой гэсэн хатуу заалттай аж. Гэтэл манайд 2013 онд уг таримлын нийт талбай 40,000 га-д хүрсэн бөгөөд энэ онд талбайн хэмжээ нь даруй хоёр дахин өсөж 80 гаруй мянган га-д хүрсэн байх жишээтэй. Гэтэл сүүлийн жилүүдэд Монголд ургамлын тосны “Алтан тос”, “Mind Tech” гээд хоёр ч өндөр хүчин чадал, технологитой үйлдвэр ашиглалтад орсон ч дотоодынхоо тэр их тариалалтаас түүхий эдээ хангалттай базааж чаддаггүй нь харамсалтай. Тариаланчид ашгаа бодоод хятадуудад харьцангуй өндөр үнээр өгдөг байна. Яг л нөгөөх ноолуурын зах зээлд урд хөршийнхөн ▶

1998-2008 оныг хүртэл газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх зорилгоор авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ

| Нэр | Бодлого зорилт | Хугацаа | |
|--|--|--|--|
| Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх хөтөлбөр | ГТ-ийн салбарын менежментийг шинэчлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх | 1998 онд ЗГ-ын 103 дугаар тогтоол | Хөрөнгө, санхүүжилт байхгүйгээс үр дүн гараагүй. |
| АНУ-ын хүнсний буудайн тусламж | Хүнсний хангамжийг нмэгдүүлэх | 1998-2006 | 179,0 мян тн хүнсний буудай тусламжаар олгосон. “Мерси кор” ОУБ хуваарилж олгосон. |
| Японы засгийн газрын КР2 хүнсний бус буцалтгүй тусламж | Техникийн шинэчлэлийг эхлүүлэх, дэмжих | 1993 | 2008 онд 10,8 мян.тн хүнсний буудай 1994 онд 90-100 морины хүчтэй /м.х/ Кубота трактор 90 ш 2002 онд 125 м.х 45 ш Нью холланд трактор анжис, борнойн хамт, Беларусь 1221 трактор 36ш, 1997-1998 онд Нива эффект үр тарианы комбайн 26 ш нийлүүлсэн. 2008 онд Хуримтлалын сангаас 80 ш Беларусь 1221 трактор, сийрүүлүүр, хор цацагч авсан. 2013 онд Төв-Угтаалцайдам суманд 36,0 мян тн элеватор ашиглалтад оруулсан |
| “Уринш” төсөл | Ургацыг нэмэгдүүлэх, талбай нэмэгдүүлэх | Засгийн газрын 2001 оны 39 дүгээр тогтоол 2001-2002 он | 2001 онд 275,8 мян га, 2002 онд 229,0 мян га-д уринш боловсруулсан. Эргэлтийн талбайг 500,0 мян га-д хүргэсэн. ХААН банкаар дамжуулан 1200 гаруй ААН, иргэнд 3.8 тэрбум төгрөгийн зээл олгосон. Химийн уринш боловсруулж эхэлсэн. 228,0 сая төгрөгийн гербицид нийлүүлж хөнгөлөлттэй олгосон. |
| “Үр” дэд хөтөлбөр | Үрийн чанар хангамжийг сайжруулах, үр сортын нэгжийн бүтэц тогтолцоог шинэчлэх | Засгийн газрын 2001 оны 39 дүгээр тогтоол 2001-2004 он | Үр үржүүлэхээр сонгогдсон 24 ААН, байгууллагад 417,0 сая төгрөгийн эрг.элтийн хөрөнгийн дэмжлэг үзүүлсэн. Импортоор 2000 тн, дотоодоос 1900 тн элит болон сортын үр авсан. Бүтцийг бий болгох чиглэлээр санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээгүй учраас зогссон. |
| “Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөр | ГТҮ-ийг сэргээх, техник, технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх | Засгийн газрын 2008 оны 70 дугаар тогтоол | 5 брэндийн 120-530 м.х-тэй 332ш трактор, үрлүүр 232ш, сийрүүлүүр 235ш, хор цацах машин 90ш, үр тариа хураах комбайн 186 ш, үтрэмийн техник 154 ш, Булган аймагт 36,0 мян тн, Сэлэнгэ аймагт 10,0 мян тн элеватор ашиглалтад оруулж, Тариалангийн ААН-д 500тн-ын 25 ш, 300 тн-ын 25ш, 100тн-ын 60 ш төмөр агуулах, элит үр 2000 тн нийлүүлсэн. Техник, үр, шатахуун, ургамал хамгааллын бодис ыг 20-50% урьдчилгаатай, төлбөрийг ургацаас нөхөн бүрдүүлэх нөхцлөөр зээлээр олгосон. Улсын төсөв 42,8 тэрбум, ОХУ-ын ЗГ-ын зээлээр 8,8 тэрбум төгрөг оруулсан. Хувийн хэвшлээс 56,6 тэрбум төгрөг оруулсан. |

► яаж дураараа дургидаж байлаа тэр түүх ургамлын тосны таримал дээр давтагдаж байна гэлтэй. Уг нь төрөөс тариаланчдад хавар, намарт үр, шатахуун, ургамал хамгааллын бодис урьдчилгаа нөхцөлтэйгээр тариалалтын хугацаанд нь зээлээр олгож дэмждэг. Том тариаланчдын хувьд энэ дэмжлэгийг сүүлийн үед дэмжлэг биш гэж голдог болсон ч төр өмнөд хөрш рүү тосны ургамал нийлүүлж, хөрснийхөө үржил шимийг муутгах гэж ард түмний мөнгөнөөс дэмжлэг үзүүлээгүй л байлтай. Тиймээс Үйлдвэр, хөдөө аж ахуйн

шинэ сайд Ш.Түвдэндоржийг энэ чиглэлд зохистой түвшинд тариалалт эрхлэх зангарагатай шийдвэр гаргана гэж найдъя. Мөн тариаланчид нэлээд харуулдсаар суугаа хэзээ батлагдах нь тодорхойгүй байгаа “Газар тариалангийн тогтвортой хөгжил” хөтөлбөрийг ойрын хугацаанд тодорхой болгох нь зөв байх.

Бичээд байвал их зүйл бий. Монголын газар тариаланд боломж байна. Өнөөдрийн амжилтаа ахиулж, үүлэн чөлөөний нарыг үүрдийн боломж болгон ашиглаасай гэж хүсье. ■

5-10 хуийг хамардаг. Миний бодлоор урамшууллын мөнгийг тушаасан ургацаар нь биш, тариалсан талбайн хэмжээгээр нь олгох юм бол илүү олон тариаланч хамрагдана. Газар тариалангийн салбар урамшуулалгүйгээр явахгүй. Хамгийн эхлээд тариаланчид амьд байж гурилын үйлдвэр байна. Дараа нь ард түмэн гурилаа иднэ. Хоёрдугаарт, манай аж ахуй олон жилийн өмнө Үр үржүүлгийн аж ахуйтай болсон. Гэтэл тариаланчид биднээс 700.000 төгрөгийн үнэтэй үр авахгүй гадаадаас 800.000-900.000 төгрөгийн өндөр үнэтэй үр авдаг. Үрийн буудайн дээр урамшуулал өгчих ёстой. Тэгвэл асуудал зуун хувь шийдэгдэх юм.

Х.Золжаргал: -Улсын нөөцөд тушаасан нэг тонн улаан буудай тутамд олгож байгаа 100.000 төгрөгийн урамшуулалд Монголын тариаланчид бүгд хамрагдаж чадаж байгаа.

Ц.Элбэгдорж: -Зах зээлд төр буруу орох юм бол завхрал үүсгэдэг. Үнийг нь өсгөдөг. Тарьж байгаа хүмүүсийнхээ урмыг хугалдаг. Тэгэхээр бид газар тариалан дээр Монголын нөхцөлд тохирсон зөв, жинхэнэ дэмжлэг болох бодлогыг л хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнийг л гаргаж ирмээр байгаа юм. Жишээлбэл, ТЭДС-д төрийн тогтоосон үнээр тушааж байгаа бол тэр хэмжээгээр нь урамшуулал олгочих. Тариаланч, гурилын үйлдвэр хоёр тохироод гурилын үйлдвэртээ тушааж байгаа бол тэдний хоорондын асуудал.Тодорхой үнээс доошоо гурилын үйлдвэрт тушаагаад тариаланчид алдагдал хүлээхээр байвал тэр хэмжээнд нь төрөөс дэмждэг ч юм уу.

Хамгийн гол нь бид өнөөдрийн хүрсэн амжилтаа хадгалах хэрэгтэй. Хадгалахын тулд гаднаас хямд үнэтэй гурил, будайны асуудал ерөөсөө байж болохгүй. Өндөр татвар тавьж болно. Манайх энэ тал дээр Дэлхийн худалдааны байгууллагын дүрэм журмаар аваад үзсэн ч хөгжиж буй далайд гарцгүй орон гэдэг утгаараа олон давуу боломж эдэлж болохоор байгаа. Үүнийгээ ашиглаад дотоодын үйлдвэрлэлээ аль ч тохиолдолд дэмжих л ёстой. За тэгээд технологийг бага багаар шинэчлэх. Хамгийн гол нь га-гаас авах ургацаа л нэмэгдүүлэх хэрэгтэй. ■

ТАРИАН ТАЛБАЙД ӨРНӨСӨН “АМТТАЙ” ЯРИА

Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Сэлэнгэ аймгийн тариалангийн аж ахуйн нэгжүүдээр өнгөрсөн сарын дундуур явж, ургац хураалттай танилцсан. Энэ үеэр Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын “Гацуурт” компанийн тариан талбайд өрнөсөн ярианаас товчлон хүргэж байна.

Л.Чинбат/ Гацуурт компанийн ерөнхий захирал/: - Төрийн дэмжлэг тариаланчдыг ашигтай ажиллаж байхад нь дэмжиж байгаа юм биш. Өртөгнөөс нь доогуур үнэлчихээд зөрүүг нь өгч байгаа хэрэг. Өнөөдөр манай энэ талбайн нэг тонн буудайн өөрийн өртөг дунджаар 700 мянган төгрөгт хүрч байгаа. Гэтэл улс 500 мянган төгрөгөөр үнэлж байна. Нэг тонн буудай тутамдаа 100 мянган төгрөгийн урамшуулал авахаар цаана нь би 100 мянган төгрөгийн алдагдалтай ажиллана. Тариаланчид өнгөрсөн хэдэн жил үнэтэй байна уу, үнэгүй байна уу, чанартай байна уу, чанаргүй байна уу хамаагүй дотоодын хэрэгцээгээ хангах зорилт тавьсан. Дөнгөж сүүлийн хоёр жилд дотоодын хэрэгцээгээ хангаж байна.

Ц.Элбэгдорж /Монгол Улсын Ерөнхийлөгч: -Тарианы болц сайн байна. Жил бүр тариалангийн талбайгаар явахдаа нэг асуудал шийдчих юмсан гэж боддог. Буудайн зах зээлийн үнэ цаашид хамгийн гол









Ерөнхийлөгч “Гацуурт” компанийн талбайд. 2014.09 сар

нь нийлүүлэлтээрээ шийдэгдэнэ. Га-гийн ургац нэмэгдээд, нийлүүлэлт нь сайжрах юм бол зах зээлийн үнэ доошоо буудаг. Энэ асуудлыг гурван тал суугаад ярилцчих л хэрэгтэй.

Х.Золжаргал /Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга/: -Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны хувьд эцсийн хэрэглэгчдэд гурилын үнэ өндөр үнэтэй очихгүй байх асуудалд анхаарах ёстой. Манай яамнаас хийсэн судалгаагаар улсын хэмжээнд нэг тонн улаан буудайн дундаж өртөг 395 мянган төгрөг байхаар гарсан. “Гацуурт” компанийн хувьд бидний судалж тогтоосноос өндөр 700.000 байж магадгүй. Эднийх усалгаатай талбай ихтэй, техникийн элэгдэл хорогдлыг тооцсон байх.

Чинбат: -Өнөөдөр улсад тушаасан нэг тонн улаан буудай тутамд олгож буй урамшуулал нийт тариаланчдын


1 Газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2013-2014

| | | | | | | | |
|-------------|---|-------|--|---|---|--|---|
| 2013 | Тариалсан талбай /га/ | 275,0 | 15,2 | 8,1 | 11,9 | 79,4 | 275,0 мян/га |
| | Ургац/мян,тонн/ | 370,3 | 190,4 | 102,2 | 43,6 | 42,6 | |
| | Улаан уудай  | | Төмс  | Хүнсний ногоо  | Тэжээл  | Рапс  | Уринш  |
| 2014 | Тариалсан талбай /га/ | 289,0 | 11,5 | 6,1 | 10,5 | 74,5 | 329,0 мян/га |
| | Ургац/мян,тонн/ | 426,4 | 198,5 | 106,8 | 25,4 | 19,2 | |


2 Улаан буудайн агуулах сав



3 Хүнсний ногооны зоорь, агуулахын хангамж 2013 (мян.тн)




4 Чацаргана тариалалтын үзүүлэлт



| | | | | |
|-----------|------|------|------|------|
| | 2013 | 2016 | 2020 | 2024 |
| Талбай/га | 4,4 | 7 | 12 | 15,0 |
| Ургац /тн | 1151 | 4,0 | 20,0 | 35,0 |

5 Бусад жимс /гүзээлзгэнэ, үхрийн нүд, алим, чавга/



| | | | | |
|-----------|------|------|------|------|
| | 2013 | 2016 | 2020 | 2024 |
| Талбай/га | 0,5 | 1,0 | 3,0 | 5,0 |
| Ургац /тн | 271 | 1,0 | 5,0 | 10,0 |


6 Төмс, хүнсний ногооны зоорийн нийт багтаамж 2013 онд 182,2 мянган тоннд хүрлээ

| | | | | | | | | | | | | | | | | | | | |
|------------|------|------|--------|------------|---------|------------|----------|--------|---------|------------|---------|------------|----------|----------|-----------|------|--------|--------|-----------|
| Баян-Өлгий | Увс | Ховд | Завхан | Говь-Алтай | Хөвсгөл | Баянхонгор | Архангай | Булган | Эрдэнэт | Дархан-Уул | Сэлэнгэ | Өвөрхангай | Дундговь | Өмнөговь | Дорноговь | Чойр | Хэнтий | Дорнод | Сүхбаатар |
| 1250 | 2880 | 2780 | 4540 | 1828 | 4900 | 2170 | 955 | 1200 | 2600 | 9720 | 36400 | 3685 | 470 | 725 | 620 | 350 | 2100 | 3918 | 850 |


Монголбанктай хамтран хэрэгжүүлж буй “Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд 2014 онд 20 мянган тн зоорь, хадалдааны төв ашиглалтад оруулна.

Эх сурвалж: ҮХААЯ


7 Үр тарианы үйлдвэрлэл




8 Хүнсний ногооны үйлдвэрлэл




9 Төмний үйлдвэрлэл




10 Нэгжийн ургац (цн)



11 Улаан буудайн үйлдвэрлэсэн хэмжээ болон тариалсан талбай



12 Рапсын үйлдвэрлэсэн хэмжээ болон тариалсан талбай



13 Үр тарианы үйлдвэрлэлд ашиглагдаж буй техникийн судалгаа-2014

| Техникийн нэр | Нийт | 1-4 жил | 5-8 жил | 9-12 жил | 13-16 жил | 17-20 жил | 20-с дээш жил | Шинэчлэлийн хувь |
|---------------|------|---------|---------|----------|-----------|-----------|---------------|------------------|
| Трактор | 1788 | 312 | 376 | 340 | 277 | 302 | 181 | 57.5 |
| Сийрүүлүүр | 1277 | 230 | 275 | 192 | 217 | 230 | 133 | 54.6 |
| Үрлүүр | 2010 | 311 | 362 | 372 | 442 | 382 | 141 | 52.0 |
| А/жатка | 567 | 68 | 85 | 78 | 109 | 136 | 91 | 40.7 |
| ҮЛТ комбайн | 1138 | 158 | 195 | 223 | 248 | 182 | 132 | 50.6 |
| Нийт | 6780 | 1079 | 1293 | 1205 | 1293 | 1232 | 678 | 52.8 |

14 Тариалангийн эдэлбэр газрын ашиглалт

| Бүсийн нэр | Тариалангийн нийт талбай/га | Ашиглагдаж буй талбай/га | Атаршсан талбай/га | Ашиглагдаагүй талбай/га |
|------------|-----------------------------|--------------------------|--------------------|-------------------------|
| Төв | 821 208 | 569 145 | 252 063 | 30,7 |
| Хангай | 139 768 | 440 98 | 95 670 | 68,4 |
| Баруун | 126 393 | 22 302 | 104 091 | 82,4 |
| Зүүн | 181 753 | 84 811 | 96 942 | 53,3 |
| Говь | 376 | 376 | 0 | 0,0 |
| Улсын дүн | 1 269 498 | 720 732 | 548 766 | 43,2 |

Эх сурвалж: УХААЯ

ХӨДӨӨ АЖ АХУЙ

ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ
ДЭЛХИЙ ДАХИНД

Б.ЖАРГАЛ

Хүнс хүний анхдагч хэрэгцээ. Энэхүү хэрэгцээ аюулгүй, эрүүл бас чанартай байх нь тухайн оронд үндэсний аюулгүй байдлын хэмжээнд ярих асуудал. Хүнсний эрэлтийг шууд хангах цорын ганц салбар бол хөдөө аж ахуй.

Дэлхийн буудайн нөөц, үйлдвэрлэл 2014-2015 онд 6.6 сая тонноор нэмэгдэх төлөвтэй байна. Урд хөршийн улаан буудайн нөөц хоёр сая тонноор нэмэгдэхээр байгаа. Өнгөрсөн онд тус улсын буудайн нөөц ялимгүй багассан тул энэ онд нөөцөө ахиулах зорилго тавин ажиллаж байгаа аж. Ингэснээр үр тариа, буудайн үнэ харьцангуй тогтвортой байх боломж бүрдэх юм. Канадын Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээллээр тус улс буудайн нөөцөө 0.8 сая тонноор нэмэх аж. Ийнхүү дэлхийн улаан буудайн нийт нөөц 720 сая тонн болох юм.

Үйлдвэрлэлийн хувьд Европын холбооны орнууд болон Украин тэргүүлж буй. Төлөвлөгөөт зорилт тус бүр 3.1 сая тонн, 2.0 сая тонн байх аж. Австралийн тариалангийн бүс нутгуудад нүүрлээд буй ган тариа хураалтын дүнд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийг 0.5 сая тонноор “хугаслаад” буй. Дэлхийн газар тариалангийн чухал бүсэд тооцогддог Морокко улс үйлдвэрлэлийн дүндээ 0.4 сая тонн улаан буудай нэмсэн бол Алжир 1.0 сая тоннын хоргодол хүлээгээд байна.

Дэлхийн улаан буудайн эрэлтийн хувьд Хятадын өндөр хэрэгцээнээс үүдэн 3.2 сая тонноор нэмэгдэх юм. Түүнчлэн Ираны хүнсний хэрэглээ нэмэгдсэн нь тус улсын улаан буудайн эрэлтийг 0.5 тонноор нэмж хангах шаардлагыг үүсгэсэн. Мөн буудайн

олон улсын худалдаа өсөж буй нь Иран, Пакистан, Алжир зэрэг улсын импорт өссөнтэй холбоотой аж. Европын Холбоо, Украин, Канадын газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдсэн нь эскпортод нийлүүлэх боломж бүрдүүлж буй. Эдгээр улсаас гадаадад хүргүүлэх буудайн хэмжээ тус бүр 1.0 сая тонноор нэмэгдэхээр байна. Тэгвэл Бразил, Казахстанас ирэх экспорт тус бүр 0.5 сая тонн байх аж. Хэдийгээр буудайн эрэлт дэлхий нийтэд асар хурдацтай нэмэгдэж буй ч нийлүүлэлт түүнээс давж байгааг АНУ-ын газар тариалангийн холбоо онцоллоо.

Хэдийгээр дэлхийн хэмжээнд үр тарианы үйлдвэрлэл 7.9 сая тонноор хумигдах төлөв бий ч нийлүүлэлт 4.0 сая тонноор илүү байна гэх. Харин хэт гантай байсан Хятадын хойд болон зүүн хойд бүсийн үр тарианы тариалалт 5.0 сая тонноор багасахаар байгаа юм. Аргентин улсын хувьд харьцангуй бага тариалалт хийсэн учир үйлдвэрлэл 3.0 тоннын хасах дүн гарах төлөвтэй байгаа юм.

Үр тарианы дэлхийн хэрэглээ 2.3 тонноор нэмэгдэнэ гэсэн таамаг байна. Энэхүү хэрэглээг АНУ, Европын Холбоо хангах бөгөөд ингэснээр Аргентин,

Бразилийн үр тарианы экспортын өрсөлдөх чадварт сөрөг нөлөө үзүүлэх юм. Хэдий дэлхийн үр тарианы нөөц 2014-2015 онд өндөр байх ч Хятад, Аргентин, ОХУ-ын хувьд улсын нөөц багатай оны эцсийг үзэх аж.

Рапс тариалалт нэмэгдсэн нь дэлхийн ургамлын тосны таримлын үйлдвэрлэлийг 6.2 тонноор нэмэгдүүлж 528 сая тоннд хүрнэ гэсэн урьдчилсан таамаг байна. Цаг уурын таатай нөхцөл Европын рапс хураалтыг нэмэгдүүлсэн. Харин Канад улсад тус төрлийн таримлын ургац нэлээд багасна гэсэн таамгийг тус улсын Статистикийн хорооноос гаргалаа. Ургамлын тосны төрлийн тариалалт дэлхийн хэмжээнд өсөх хандлагатай ч нийлүүлэлт их байгаа тул үнэ буурах төлөвтэй байна.

Дэлхийн махны үйлдвэрлэл 2014-2015 онд буурна. Учир нь энэ оны хувьд мал аж ахуйн үйлдвэрлэл харьцангуй бага дүнтэй байсан нь ирэх оны нийлүүлэлтийн хэмжээнд ийн нөлөөлж буй аж. Судлаачдын таамаглаж буйгаар үхрийн махны эрэлт ирэх онд нэмэгдэхээр байгаа нь үйлдвэрлэл буурсан, хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотой. Улмаар тус төрлийн махны үнэ энэ онд өсөх ч ирэх онд тогтвортой байна хэмээн үзжээ. ■

1 Дэлхийн улаан буудайн зах зээл /сая.тн/

| | 2010/11 | 2011/12 | 2012/13 | 2013/14 таамаг | 2014/15 | |
|--|---------|---------|---------|-------------------|-------------|------------|
| | | | | | өмнөх 7 сар | Одоо 9 сар |
| Үйлдвэрлэл | 653.8 | 702.5 | 660.6 | 717.1 | 707.2 | 716.5 |
| Нийлүүлэлт | 844.0 | 887.2 | 840.8 | 873.5 | 881.1 | 891.1 |
| Хэрэглээ | 658.3 | 698.6 | 685.9 | 687.4 | 699.2 | 699.5 |
| Худалдаа | 128.0 | 147.5 | 140.9 | 157.1 | 149.0 | 148.0 |
| Сүүлийн нөөц | 184.7 | 180.3 | 156.4 | 174.6 | 180.0 | 188.4 |
| Нөөц /хэрэглээ хувь/ | 26.4 | 26.3 | 22.7 | 25.0 | 25.3 | 26.4 |
| Томоохон экспортлогчдын хувь ашиглалт/ (%) | 20.7 | 17.9 | 14.1 | 14.1 | 14.4 | 15.6 |

АСУУДАЛ

ГОМДОЛЛОХ ГЭСЭНГҮЙ ГАРЦ ХАЙВ

Б.ҮҮРИЙНТУЯА

Уул уурхайнхан цуглалаа бас хэлэлцлээ. Улиг болсон өнөө л хэдэн нөхөд гэж бодож байгаа бол тоогдохоо байтлаа ярилцаж хэлэлцэхээс өөр арга тэдэнд алга. Учир нь та бидний амьдрал, улсын эдийн засагтай хамгийн их холбоотой нь уул уурхай. Бөмбөрцөгийн хаанаас ч ирэх эрэлтийг тодорхой хэмжээнд хангах байгалийн нөөц бидэнд байна. Гэтэл “тэжээгч” салбар маань өнөөдөр таг зогсоход хүрээд буй.

“Эрдсийн бүтээгдэхүүний экспорт, өрсөлдөх чадвар: Жишиг үнэ” сэдэвт хэлэлцүүлгийг Уул уурхайн ассоциаци өнгөрсөн сарын 24-нд зохион байгуулав. Хүйт даасан хурлын танхимд хүрэлцэн ирсэн холбогдох салбарын төлөөллүүд, тэдний чуулах сэдвийг чухалчлан сурвалжлахаар чих тавих сэтгүүлчдийг харахад уул уурхайн сэдэв хэн бүхний сэтгэлийн гүнд чухал хэвээр байгааг илтгэх мэт. Нүүрсээ ярих төдийхнөөр өндөрлөдөг байсан зарим хэлэлцүүлгийг бодвол оролцогчдын хүрээг аль болох өргөн байлгахаар зорьсон нь онцлог санагдаж байлаа. Төр, хувийн хэвшлээс гадна аж ахуйн нэгж болон хуульч, судлаачид цугласан харагдав.

“Эрдсийн бүтээгдэхүүний үнэ тогтоох аргачлал, олон улсын онол, практик” гэх үндсэн сэдвээр Эрдэс баялгийн эдийн засагч, доктор, профессор Д.Галсандорж илтгэсэн бол төмөрлөг, жонш, өнгөт металлын салбарынхан тулгамдаж буй асуудлуудаа мөн хэлэлцсэн юм. Түүнчлэн Ашигт малтмалын нөөц ашигласны татварыг хэрхэн тооцох, олон улсад ямар практик хэрэгждэг тухай судалгаа, хууль эрх зүйн орчны



“Эрдсийн бүтээгдэхүүний экспорт, өрсөлдөх чадвар: Жишиг үнэ” сэдэвт хэлэлцүүлэг. 2014.09.24

талаар сонирхолтой илтгэлүүд олны анхаарлыг татаж байлаа. Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Н.Алгаа “Төр, хувийн хэвшлийн хүрээнд талууд тоо баримт бүхий мэдээлэл бэлтгээд нэгэндээ танилцуулах зорилго агуулж байна. Түүнээс биш, ямар нэг байгууллагад буруу тохих эсвэл гомдоллох гэсэнгүй. Хэлбэрийн хувьд холбогдох холбоод тухайн дэд салбараар жишиг үнийн хэрэгжилтийн асуудлаар бодит байдлын зураглал өгөх юм” гэв.

Буруу жишвээс...

Уул уурхай гэхээр нүүрс гэж ойлгодог. Засгийн газар ч хар алтны үнэ цэнийг мэддэг тул жишиг үнэ гээчээр нүүрсний салбарыг боомилох нь эдийн засгаа “хутгалж” буйгаас өөрцгүй гэдгийг ухаарч гэрээний үнээр татвар тооцох журамд шилжээд буй. Гэвч уул уурхай зөвхөн нүүрсний экспорт биш.

Урд хөршийн үсрэнгүй хөгжил төмрийн баяжмалын эрэлтийг хэсэгхэн зуур өсгөөд авсан. Харамсалтай нь төмрийн баяжмал тренд байхаа больж үнэгүй эд болох цаг ойр иржээ.

Энэ талаар Монголын төмөрлөг үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал Л.Баяраахүү “2020 оноос эхлэн тус төрлийн бүтээгдэхүүний хэрэглээ эрс буурах төлөвтэй байна. Хятад төмрийн хүдрийн худалдан авалтаараа тэргүүлж байгаа. Дэлхийн хаана ч Хятадтай адил төмрийн хүдрийг их хэмжээгээр авахаа больсон” гэдгийг онцлов. Түүний хэлснээр хөршийнхөө эрэлтэд суурилан хөрөнгө босгох нь манай улсын хувьд ухаалаг алхам болох аж. Гэвч жишиг үнийг хэт өндөр тогтоож байгаа нь тус салбарт тун таагүй нөхцөлийг дуудаж байгаа юм. Тэрбээр “Рио Тинто зэрэг уул уурхайн томоохон компаниудын бизнесийн төлөвлөгөөг харахад 2025 он хүртэл гарсан байгаа юм. Энэ сайны дохио биш. Учир нь 2025 оноос хойш төмрийн баяжмалын эрэлт байхгүй болно гэж тооцоолж байгаа” хэмээн илтгэлийнхээ үеэр дурьдлаа. Түүнчлэн бодит байдалд нийцээгүй үнээр (Австралиас Хятад руу экспортолдог ханшаар жишиг үнийг тооцдог) жишиг тогтоохын зэрэгцээ тухайн үнээс хамаарсан татвар авч байгаа нь төмөрлөгийн ▶

▶ салбарын экспортлогчдын ирээдүйг улам бүрхэг болгож байна. Үүний нотолгоог өвдөг шороодож буй салбарынханы үйл ажиллагаанаас харж болох юм. Өнөөдрийн байдлаар төмөрлөгийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 90 хувь зогссон, ойрын 2-3 жилдээ өөдтэй сэргэхгүй гэсэн таамаг гарчээ.

Өөр нэг жишээ. Хайлуур жоншны дэлхийн нөөц 240 сая тонн, боломжит нөөц 500 сая тонн. Үүний 10 орчим хувь буюу 22 сая тонн нь Монголд бий. Энэ төрлийн үйлдвэрлэлээрээ манай улс тэргүүлэгчдийн гуравт багтдаг. Гэтэл өнөөдөр үйл ажиллагаа эрхэлдэг байсан 40 гаруй уурхайгаас долоо нь дөнгөн данган ажиллаж байна гэсэн харамсмаар тоо гарав. Ойролцоогоор 400 мянган тонн бүтээгдэхүүн гадагш гаргадаг байсан бол 100 орчим мянган тонноор үнэлэгдэх болж. Монголын жоншны холбооны гүйцэтгэх захирал Д.Мөнхбазар “Жоншны салбар татварын ерөнд унасан. Зах зээл эрэлт, үнэ буураад байна. ОХУ тэргүүтэй томоохон худалдан авагчид

манайхаас жонш нийлүүлэхээс татгалздаг боллоо. Үүний зэрэгцээ амьдралд нийцэхгүй үнэ жишиг болгон тогтоосон нь салбарын хувьд дарамт болж байгаа. Төсвийн орлого бүрдүүлэгч салбараа ийн дарамтлах нь зөв үү гэдгийг сайтар бодох хэрэгтэй” гэв. Түүний илтгэлд дурьдсанаар салбарыг ийм замаар уналтад “уриалах” нь өрхийн орлогод сөргөөр нөлөөлж ажилгүйдлийг нэмэгдүүлэхээс гадна улсын хэмжээнд валютын, татварын мөн төсвийн орлого тасалдах нөхцөл болох юм.


Жишиг үнэ тогтоох нь буруу гэж салбарынхан хэлсэнгүй. Тэд төрөөс тогтоож буй аргачлалыг үндэслэлгүй гэж үзэж байна. Алс холын Австралиас олон мянган километр гатлан Хятадын боомтуудад хүрэх зардлыг тооцоолон гаргасан жишиг үнийг “soru&paste” хийж байгааг буруушааж байгаа юм. Хэлэлцүүлэгт ирсэн нэгэн оролцогчийн хэлснээр эдийн засгийн тулгуур болсон уул уурхайн салбараа сайжруулах гээд муутгаад байх шиг.

Хууль биш гууль мөрдөх үү

Ашигт малтмалын тухай хуулийн 47.2.1-д “Экспортод бүтээгдэхүүн гаргасан бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлана” хэмээн заажээ. Тэгвэл Татварын ерөнхий газар өөрийн гэсэн аргачлалаар тооцон татвараа авч байгааг “Металлимпэкс” ХХК-ийн захирал Л.Бямбажав тайлбарласан юм. Тэрбээр “Тухайлбал, цайрын баяжмалын олон улсын зах зээлийн үнэ борлуулалтын үнэлгээг Ашигт малтмалын тухай хуульд зааснаар тооцвол ойролцоогоор 597 ам.доллар болж байгаа. Харин Татварын ерөнхий газрын даргын 2010.06.17-ны өдрийн 322 тоот тушаалаар баталсан аргачлалаар бодвол хуульд зааснаас 1.6 дахин их буюу 954 ам.доллар орчим болж байгаа юм. Татвар төлөх нь үйлдвэрлэгчийн үүрэг хэдий ч энэ нь хуулийн дагуу, шударга байх хэрэгтэй. Татварын ерөнхий газар мөрдөж буй аргачлалаа Ашигт малтмалын тухай хуулийн заалттай нийцүүлэн шинэчлэх нь зүйтэй” хэмээн илтгэлдээ онцолсон.

Хууль гууль болж буй талаар “MBS” хуулийн фирмийн захирал Б.Цэцэнбилэг “Борлуулалтын үнэлгээ, жишиг үнэ гэдэг нь тусдаа ойлголт. Жишиг үнээс борлуулалтын ▶

Өнөөдрийн байдлаар төмөрлөгийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 90 хувь зогссон, ойрын 2-3 жилдээ өөдтэй сэргэхгүй гэсэн таамаг гарчээ.



Эх сурвалж:

► үнэлгээг тооцоолон гаргах учиртай. Борлуулалтын үнэлгээний үндэслэл болох жишиг үнийг олон улсын бирж тогтооно гэж хуульд заасан байдаг. Улмаар Засгийн газар жишиг үнэ тогтоож буй биржийг зарлах юм. Гэтэл төр эрх мэдлээ хэтрүүлэн ашиглаж эх сурвалж зааж байгаа нь гаргасан хуулиа гууль болгож байгаатай адил. Учир нь хуулиар зохицуулагдаагүй асуудлыг Засгийн газар зохицуулаад ирэхээр ямар нэг хязгаар үгүй болж хуулийн хэрэгжилтийг алдагдуулах сөрөг үр дагавартай” гэв. Өөрөөр хэлбэл, биржийн нэр зарлах эрхтэй Засгийн газар эх сурвалж тогтоож, түүнээс АМНАТ төлөхийг тулгаж байна гэсэн үг. Б.Цэцэнбилэгийн дүгнэж буйгаар Засгийн газар хуулиар олгогдоогүй эрх эдлэн жишиг үнийг хүчээр тогтоож байна. Хуулийн заалт хэрэгжих үгүй нь төрийн үзэмжийн асуудал болж байгааг тэрбээр онцлов.

Угтаа бол...

Эрдсийн бүтээгдэхүүнийг Лондонгийн, Шанхайн гээд дэлхийд данстай 23 биржээр дамжин худалдаалдаг. Ингэхдээ эрдсийн болон эрдсийн бусад бүтээгдэхүүнийг арилжаалах ерөнхий нөхцөл буюу инкотермд үндэслэдэг.

НҮБ, Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орон, тусгаар тогтносон улс гэдэг утгаараа Монгол өөрийн нөхцөлд тохирсон, онцлогтой уялдсан жишиг үнэ нэвтрүүлэх нь зүйтэй. Гэтэл өнөөдөр Австрали, Хятадын далайн эргийн үнийг ямар ч тохируулга, зохицуулалтгүй шууд ашиглаж байна. Далайд гарцгүй орон далайн эргийн үнээр уул уурхайн бүтээгдэхүүнээ борлуулна гэдэг хэр логиктой асуудал вэ. Энэ талаар Эрдэс баялгийн эдийн засагч, доктор, профессор Д.Галсандорж “Сангийн яам, Уул уурхайн яамны жишиг үнэ тооцох журамд зах зээлийн үнийн мэдээллийг холбогдох эх сурвалжаас авч тооцоолол хийн нэгдсэн санал боловсруулна гэсэн байдаг. Өнөөдрийн байдлаар тохиргоо хийж тооцоолсон юм алга. Тухайлбал, төмөрлөгийн салбарт www.umetals.com эх сурвалжийг ашиглан Австралийн боомтоор Хятадын баруун хойд боомтод хүрэх үнийг, хайлуур жонш дээр Хятадын FOB (худалдагч орны далайн боомтын үнэ) үнийг жишиг

болгож байгаа юм. Манай орны хувьд DAP (худалдагч орны хилийн үнэ) руу ойртуулж жишиг үнэ тогтоох боломж бий” гэсэн юм.

Бусад орны туршлагаас судлан өөрийн хөрсөнд буулгах боломж байна. Шууд хуулбарлан экспортлогчиддоо тулгах мэт үнэ тогтоож байгаа нь тэднийг элгээр нь хэвтүүлж байгааг салбарын төлөөллүүд хэлж байв. Доктор Д.Галсандоржийн хэлснээр жишиг үнэ, татварын бодлогоо оновчтой, бодитой явуулахгүй бол эрдсийн салбарынхан хүчин чадлаа ашиглаж чадахгүйд хүрэх, татварын дарамтаас үүдэн эргэлтийн хөрөнгөгүй болох эрсдэл үүрч байгаа аж. Иймд жишиг үнэ тогтоох аргачлалыг дахин боловсруулж, улс орныхоо нөхцөл байдалтай уяж шаардлагатай байгааг хурлын танхимыг дүүргэх олон дуу нэгтэй хэлсэн билээ.

Олон улсын практикаас суралцахад буруудах зүйл үгүй. Гэхдээ гаднын туршлагыг монгол хөрсөнд буулгах шаардлага байна. Тив алгасан 6000 гаруй километр туулах үнэлгээгээр бүтээгдэхүүнээ хөршдөө нийлүүлнэ гэдэг өрсөлдөх чадвар харьцангуй тааруу манай орны хувьд эдийн засгийн эргэлтгүй болох үүдийг нээж байгаа юм. Монголын жоншны холбооны гүйцэтгэх захирал Д.Мөнхбазар “Манай уул уурхайн бүтээгдэхүүн муу учраас борлогдохгүй байгаа юм биш. Хууль эрх зүй тогтворгүй, тодорхойгүй байгаа учраас уул уурхай “хөрж” байна. Жоншны хувьд ОХУ хаа байсан Мексикээс жонш татаж байна. Бодоод үз л дээ. Хажуу айлдаа бүтээгдэхүүнээ борлуулж чадахгүй байна. Олборлож чадахгүй, нийлүүлж чадахгүй байгаа нь худалдан авагчдын үргээж байна. Манай бодлогын алдаа

Гаднын туршлагыг монгол хөрсөнд буулгах шаардлага байна. Тив алгасан 6000 гаруй километр туулах үнэлгээгээр бүтээгдэхүүнээ хөршдөө нийлүүлнэ гэдэг өрсөлдөх чадвар харьцангуй тааруу манай орны хувьд эдийн засгийн эргэлтгүй болох үүдийг нээж байгаа юм.

Монголын хөрсөнд буулгая

Уул уурхайн салбарын асуудал нэг иймэрхүү. Бүтээгдэхүүн нь байна. Борлуулалт нь даанч бага. Үүн дээр нэмэгдээд Монголд “ахадсан” жишиг үнэ. Орлогын үүдээ хаах үлгэр жишээ нөхцөл өнөөдөр манай Засгийн газар бүрдүүлээд өгчээ. Учир нь жишиг үнээр тооцсон үнэлгээнээс тогтоосон АМНАТ-ийн хэмжээ бодит байдлаас хол тасарсан нь улсын эдийн засгийн үзүүлэлтүүд ташаа мэдээлэл агуулах “нягууртай” байна. Иймд салбарынхан нэн даруй гарц хайх шаардлагатай байгааг чухалчилж эхэллээ. Ингэхдээ жишиг үнийг тогтоохдоо уурхайн ам нөхцөлтэй эсвэл хилийн үнээр жиших асуудлыг нэвтрүүлэх, түүнээс борлуулалтын үнэ тооцоолж гарган АМНАТ-ийн журамыг шинэчлэх нь боломжит шийдэл болох юм.

тэдэнд харагдаад байна шүү дээ. Асуудал шийдэгдэхгүй удаж буй нь салбарынхныг үүдээ барихад хүргэж байгаа” гэв. Түүнчлэн төрийн байгууллагын уялдаатай үйл ажиллагаа чухал гэдгийг тэрбээр сануулав.

Уул уурхайн яамны Стратегийн бодлого, төлөвлөлийн газрын ахлах мэргэжилтэн Ч.Цогтбаатар “Төрийн үйл ажиллагааг нэлээд шүүмжилж байна. Арга ч үгүй. Шийдэгдэхгүй асуудлууд олон бий. Шийдээ гээд явж байсан удаа ч бас бий. Жишиг үнийг олон улсын жишгээр явуулах асуудлыг хэлэлцэж байсан. Та бүхэнд хандаж хэлэхэд хэлэлцэж буй асуудлаа санал болгож холбогдох яамд, газруудад нь хүргүүлээч ээ. Бид дамжуулаад хэлнэ гэж байхгүй. Шийдэл агуулсан саналаа тодорхой боловсруулаад албан ёсоор хандах хэрэгтэй байна” гэдгийг хувийн хэвшлийнхэнд анхааруулав. ■

■ НООСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Жилд **18 000 тн** түүхий ноосыг Т-өөр бэлтгэдэг
 Үүний **50%** буюу **9 000 орчим тн** ноосыг угааж экспортолдог
 Хэрэв экспортлогүй дотооддоо ашиглах бол жил бүр **1.5 сая.м2** хивс **3 сая тууш.м** даавуу **100 мян.м2** эсгий дотооддоо үйлдвэрлэх боломжтой

ТУЛГАРЧ БҮЙ АСУУДАЛ

Манай улсын хонины ноос бүдүүн бүдүүвтэр ангиллын ноосонд багтааг учир ноосон даавууг дан ганц дотооддоо бэлтгэсэн ноосоор үйлдвэрлэх боломжгүй.



ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

ЗЭЭЛДЭГЧИЙН СЭТГЭГДЭЛ

Ц.Урнаа "Эрдэнэт Хивс" ХХК-ийн гүйцэтгэх захирал:

Чингис бондын санхүүжилтээр "Эрдэнэт хивс" ХХК нь Бельги улсын Van-De-Wiele фирмийн хамгийн сүүлийн үеийн хивс нэхэх технологитой, 5м өргөнтэйгээр дэлхийд анх удаа үйлдвэрлэгдсэн UCIO3 маркийн хивсний нэхэх машин суурилуулж байна.

Уг тоног төхөөрөмжийг худалдан авснаар одоогийн хүчин чадлаа 2,5-4 дахин нэмэгдүүлж, хэрэглэгчдийнхээ таашаалд нийцсэн олон нэр төрлийн шинэ өвөрмөц загвар технологитой хивсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, дотоод болон гадаад зах зээлээ өргөжүүлэн тэлэх боломжтой боллоо.

ГОЛОМТ БАНКНААС 1 ЗЭЭЛДЭГЧИД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ДҮН /САЯ ТӨГ/

Хамгийн бага **300** | Хамгийн их **8 300** | Дундаж **2 562**
 ШИНЭЭР НЭМЭГДСЭН АЖЛЫН БАЙР **574**

■ НООЛУУРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ


Ноолуурын жилийн хэрэглээ **24000 тн** түүхий ноолуур Энэ нь дунджаар **41.0 сая** ширхэг цамц хийх боломжтой
 Үүний **70%** буюу **16800 тн** ноолуур БНХАУ-с бэлтгэн нийлүүлдэг

МОНГОЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Жилд 6000 тн түүхий ноолуур гарган авдаг
 Үүний **85%** буюу **5100 орчим тн** ноолуурыг БНХАУ руу угааж экспортолдог

ТУЛГАРЧ БҮЙ АСУУДАЛ

Экспортлогүй дотооддоо боловсруулах бол жил бүр 306.0 тэрбум Т эргэлтийн хөрөнгө шаардлагатай.



ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

ЗЭЭЛДЭГЧИЙН СЭТГЭГДЭЛ

Ц.Цэцгээ "Говь" ХК-ийн үйлдвэрлэлийн дарга:

"Говь" ХК Чингис бондын санхүүжилтээр хоёр төсөл хэрэгжүүлж байна. Эхний төслийн хүрээнд 2013 оны дөрөвдүгээр сард бүтээгдэхүүнийг бүтнээр нь сүлжих зориулалттай сүлжигч 24 машиныг үйлдвэрлэлд нэвтрүүлээ. Өмнө нь бид бүтээгдэхүүнийг детальчилж оёдог байсан. Харин энэхүү машин нь бүтээгдэхүүнийг ямар нэгэн зүйдэлгүйгээр бүтнээр нь үйлдвэрлэдэг бөгөөд шат дамжлагыг хэмнэснээр үйлдвэрлэлийн бүтээмж 30 хувиар нэмэгдээд байна.

ГОЛОМТ БАНКНААС 1 ЗЭЭЛДЭГЧИД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ДҮН /САЯ ТӨГ/

Хамгийн бага **50** | Хамгийн их **14 000** | Дундаж **1 741**
 ШИНЭЭР НЭМЭГДСЭН АЖЛЫН БАЙР **259**

| ДАМЖЛАГА | Угаах | Самнах | Будах | Ээрэх | Сүлжих | Нэхэх | Эсгий үйлдвэрлэл | Дулаалгын материалын үйлдвэр |
|---|--------|--------|--------|----------|----------------|-----------|------------------|------------------------------|
| Нэмэгдсэн дамжлагын тоо | 16 | 54 | 5 | 15 | 279 | 1 | 2 | 4 |
| Боловсруулах хүчин чадлын өсөлт /жилээр/ | 700 тн | 743 тн | 108 тн | 480 тн | 2.0 сая ширхэг | 460 000 м | 200 000 м | 1.3 сая мкв |
| МУ-ын нийт хүчин чадлын өсөлт | 4% | 16% | - | 28% | 60% | Шинээр | 200% | Шинээр |
| Хөтөлбөрөөр нэмэгдүүлэхээр төлөвлөсөн хүчин чадал | - | 777 тн | - | 1 300 тн | 1.6 сая ширхэг | 2.5 сая м | - | - |
| Хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт | - | 95% | - | 37% | 125% | 18% | - | - |

■ СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

МОНГОЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Улсын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээ
455.2 сая литр

59.3 сая литр шингэн сүү үйлдвэрийн аргаар боловсруулсан нь нийт хэрэгцээний **28.3%**-г эзэлж байсан.

Нийт **600** орчим сая литр сүүний нөөцтэйгээс **46%-г нь үнээний сүү** эзэлдэг **36.8 сая литр** сүүг импортын хуурай сүүгээр үйлдвэрлэдэг

*2012 оны статистик

ТУЛАГРЧ БҮЙ АСУУДАЛ

Малчид сүү нийлүүлэхэд

1 Төвлөрсөн цэг бага

2 Тээвэрлэх тусгай машин хэрэгтэй

Үйлдвэрүүд сүү тогтмол авахад

1 Сүүний гарц хэлбэлзэлтэй

ЧИНГИС БОНДЫН ЗОРИЛГО

1 Эрчимжсэн фермийг хөгжүүлэх

2 Бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог хөгжүүлэх

3 УБ хотын хүн амын сүүний хэрэгцээг хангах

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

ЗЭЭЛДЭГЧИЙН СЭТГЭГДЭЛ

Э.Эрдэнэбилэг "Тэсо" ХХК-ийн Бизнес хөгжлийн газрын дарга

"Тэсо" ХХК-ийн охин компани болох "Милко" компани нь Чингис бондын санхүүжилтээр хоёр төсөл хэрэгжүүлж байна. Эхний төсөл бол хуурай сүүний үйлдвэр байгуулж, Монголд үйлдвэрлэх төсөл. Төслийг хэрэгжүүлэх болсон гол шалтгаан нь Монголд хэрэглэж байгаа хуурай сүүний 60-70 хувь нь импортын бүтээгдэхүүн байна. Харин манай үйлдвэр ашиглалтад орсноор өдөрт 98 тонн хуурай сүү боловсруулж, улмаар нийт импортын хэрэглээг хоёр дахин бууруулна. Ингэснээр Монголын хуурай сүүний зах зээлийн 40-50 хувийг дотоододоо хангах боломжтой болох юм.

ГОЛОМТ БАНКНААС 1 ЗЭЭЛДЭГЧИД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ДҮН /САЯ ТӨГ/

Хамгийн бага **20** | Хамгийн их **6 000** | Дундаж **768,4**

ШИНЭЭР НЭМЭГДСЭН АЖЛЫН БАЙР **181**

| Төрөл | Өсөлт | Өмнөх хүчин чадалын өсөлт | Хөтөлбөрөөр нэмэгдүүлэхээр төлөвлөсөн хүчин чадал | Хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт |
|---------------------------------|--------------|---------------------------|---|-----------------------------------|
| Ухрийн тоо | 1 600 толгой | 73% | 4 860 толгой | 33% |
| Сүүний гарц /жилд/ | 7 320 тн | 121% | 22 234 тн | 33% |
| Ухрийн байрны багтаамж | 1 937 толгой | 123% | 4 860 толгой | 40% |
| Хуурай сүүний үйлдвэрлэл /жилд/ | 900 тн | Шинээр | 3 050 тн | 29.5% |
| Сүү боловсруулах цех | 11 | - | 37 | 30% |

■ ХҮЛЭМЖ ба ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

ЧИНГИС БОНДЫН ЗОРИЛГО

1 Нарийн ногоо тариалагч 4 улирлын хүлэмж байгуулах

ШИНЭЭР НЭМЭГДСЭН АЖЛЫН БАЙР

146

ЗЭЭЛДЭГЧИЙН СЭТГЭГДЭЛ

Э.Ганбат "Green Vegetal" ХХК-ийн гүйцэтгэх захирал:

Green Vegetal ХХК нь Шинэчлэлийн засгийн газрын хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр хангах ажлын хүрээнд 2013 онд Чингис бондын санхүүжилтийг авч Япон улсын технологигор хүнсний нарийн ногооны хүлэмжийг УБ хот болон Өмнөговь аймгийн Ханбогд суманд байгуулаад байна. Орчин үеийн дэвшилтэд технологийн хүлэмжийн давуу тал нь гадна орчноос бүрэн тусгаарлагдсан учир агаар хөрсний бохирдол, ургамлын өвчлөөс бүрэн сэргийлж чадсан. Төслийн гол зорилго нь импортоор орж ирж байгаа эрүүл ахуйн чанарын шаардлага хангадаггүй хүнсний ногооны оронд эх орондоо тариалсан шинэ хүнсний ногоогоор иргэдийг тогтмол хангах юм.

ГОЛОМТ БАНКНААС 1 ЗЭЭЛДЭГЧИД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ДҮН /САЯ ТӨГ/

Хамгийн бага **35.4** | Хамгийн их **8 240** | Дундаж **1 090**

| Төрөл | Тариалалтын талбай | Улаан лооль /жилд/ | Өргөст хэмж /жилд/ | Бусад (гүзээлзгэнэ, усан үзэм, тарвас салатны навч, г.м) |
|-------|--------------------|--------------------|--------------------|--|
| Өсөлт | 8.2 га | 1 640 тн | 2 460 тн | 520 тн |

■ ОЁДОЛ ба ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

ЧИНГИС БОНДЫН ЗОРИЛГО

1 Импортыг орлох дотоодын үйлдвэрлэл нэмэгдүүлэх

ШИНЭЭР НЭМЭГДСЭН АЖЛЫН БАЙР

265

ЗЭЭЛДЭГЧИЙН СЭТГЭГДЭЛ

Н.Майцэцэг Эксклюзив ХХК-ийн захирал

Манай компани үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш Голомт банкаар үйлчлүүлж байгаа бөгөөд энэ жил энэ төслийн зээлийг Голомт банкаар дамжуулж авсан. Санхүүжилтийн эцсийн үр дүн юу байх ёстой вэ гэжээр хамгийн гол нь ажлын байрыг нэмэгдүүлэх ёстой, мөн ажилчид маань боломжийн цалинтай байх ёстой. Мөн бараа бүтээгдэхүүний үнэ маань өөрөө бодитой үнийг барих, одоо 400,000-500,000 үнэтэй куртка нь манайд 180,000, 150,000, 120,000-р зарагдаж байх жишээтэй. Энэ бол үнэхээр бодит эцсийн үр дүн юм болов үү гэж бодож байна.

ГОЛОМТ БАНКНААС 1 ЗЭЭЛДЭГЧИД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ДҮН /САЯ ТӨГ/

Хамгийн бага **30** | Хамгийн их **750** | Дундаж **216,5**

| Төрөл | Шулуун оёдын машин | Оёх хүчин чадал /жилд/ | Тусгай зориулалтын тоног төхөөрөмж |
|-------|--------------------|------------------------|------------------------------------|
| Өсөлт | 164 ш | 970 000 метр | 156 ш |

ДААТГАЛ

ЗАХ ЗЭЭЛ БҮХЭН ӨӨРИЙН
ГЭСЭН ҮНЭТЭЙ

Б.ЭНХЦЭЦЭГ

Лорен Пушет Котиллу нь Эрүүл мэндийн даатгалын салбарт 18 жил ажилласан нэгэн. Тэрбээр Сингапурт төв оффис нь байдаг олон улсын эрүүл мэндийн менежментийн АХА компанид ажиллаад дөрвөн жил болж буй. Лондоны их сургуулийг төгссөн Лорен хөлөө олж буй компани болон дэлхийн хэмжээний томоохон корпорацийн аль, алинд ажиллаж үзсэн туршлагатай.

70 жилийн түүхтэй АХА компанийн Ази, Номхон далайн бүсийн давхар даатгалын зах зээлийг хариуцсан захирал нь Лорен. Тэрбээр энэ удаад Монголын зах зээлд эрүүл мэндийн хувийн даатгал хэмээх манай улсад хөгжлийн шинэ гэж хэлж болохуйц чиг хандлагын үрийг тарихаар иржээ. Манайд эрүүл мэндийн даатгал гэхээр иргэд улсад сар бүр төлдөг хэдэн төгрөгнийхөө хариуд улсын эмнэлгүүдээс үйлчилгээ авдаг тогтолцоо гэж ойлгодог. Төрийн үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээ өдөр ирэх тусам цаг үеийн хэрэгцээгээ дийлэхээ болино, хүлээх дараалал уртсаж, тоног төхөөрөмж нь хуучирч, эмч нарын ур чадвар гологдон, гаднын эмнэлгүүдийг зорих монголчуудын цуваа уртассаар. Үүнийг нөгөө талаас хувийн эмнэлэг болон эрүүл мэндийн хувийн даатгалын зах зээл хөгжих, нөхөх орон зай гэж гадна болон дотоодын бизнесийнхэн аль хэдийнэ хараад эхэлж. Монголд өнөөгийн байдлаар 17 даатгалын компани байдаг. АХА компанийн хувьд Монголын “Бодь даатгал” компанитай хамтарч эрүүл мэндийн даатгалын чиглэлээр ажиллах бөгөөд ажил олгогчид суурилсан байдлаар даатгалын бүтээгдэхүүн санал болгох аж.



Гэрэл зургийг Б.Бямба-Очир

-Олон улсын стандартад нийцсэн эрүүл мэндийн даатгалыг Монголын эрүүл мэндийн салбарт оруулж ирэхээр үйл ажиллагаа эхлүүлээд байгаа юм байна. Тэгвэл чухам ямар бүтээгдэхүүнүүд танилцуулах вэ?

-Монголд эрүүл мэндийн даатгал санал болгодог хувийн компаниуд угаас бий. Бидний хувьд Азийн бусад оронд үзүүлдэг шиг иж бүрэн даатгалыг Монголд танилцуулж буй. Энэ нь төлсөн мөнгөнийхөө хариуд илүү ихийг авч, эмчилгээний туршид гарсан бүх зардлаа төлүүлнэ гэсэн үг. Та Улаанбаатар хотын хамгийн сайн эмнэлгүүд тухайлбал, “Интермэд” гээд шинээр нээгдсэн тоног төхөөрөмж, олон сайн эмчтэй эмнэлэгт ч хандаж болно. Мөн бид шаардлагатай гэж

үзвэл Солонгос, Япон, Сингапур, Бангкок, Хятад болон Европ гэх зургаан газарт очиж, эмнэлгийн үйлчилгээ авахыг зөвшөөрнө. Бидний үзүүлж буй үйлчилгээ ард иргэдийг нийтээр нь хамрах хүрээнийх биш. Зорилтот зах зээл маань дунд болон дундаас дээш хэрэглэгчид. Монголын хувьд 100.000 хүн энэ бүтээгдэхүүнийг авна гэсэн тооцоо байна.

-Өнөөдрийн түвшинд Монголд ажилчиддаа танай компанийн даатгалын бүтээгдэхүүнийг аваад өгөх компани, ажил олгогч цөөн байх болов уу. Ийм нөхцөлд Монголын зах зээлд байр сууриа олох хэцүү биш үү?

-Хүмүүс үүнд дасаагүй учир эхэндээ үйл явц нэлээд удаан байх төлөв бий.

Зорьсон үр дүндээ хүртэл нэлээд хэдэн жил болно. Гэвч бид тэвчээртэй улс. Бид олон компанийн төлөөлөл, ажил олгогчтой уулзаж, санаа бодлыг нь сонирхож, сайн судалгаа хийсэн. Бидний уулзсан Хүний нөөцийн менежер бүр “Бид үүнийг судалж байна, энэ талаар бодож байна” гэж хэлж байсан. Тэд хараахан манай бүтээгдэхүүнийг худалдаад авчихаагүй ч, энэ талаар бодож байгаа нь ирээдүйд хийнэ гэсэн үг.

-Бизнес эрхлэгчийн хувьд энэ удаад яагаад Монголыг сонгов?

-Би том бүс нутгийг хамран ажилладаг. Монгол бол энэ бүс нутагт бидний хамтрагчгүй ганцхан зах зээл байсан. Хэдийгээр том зах зээл биш ч, хэдэн жилийн дараа юу болохыг ▶

▶ харна гэхээс бидэнд сэтгэл хөдлөм санагддаг. MCS шиг цөөн хэдэн томоохон ажил олгогч ажилтнууддаа эрүүл мэндийн даатгал олгоод эхлэх л хэрэгтэй байна. Тэгэхээр нэг хэсэг нь жишиг болоод ирэхээр бусад нь зах зээлийнхээ жамаар дагана. Нэг эхэлчихвэл хурдтай явдаг үйл явц юм. Бид мэдээж Хятад, Энэтхэг, Малайз, Индонез, Тайланд гэх мэт томоохон зах зээлд мөн үйл ажиллагаагаа явуулдаг.

-Танайх нийт 17 компаниас “Бодь даатгал”-ыг яагаад хамтрагчаараа сонгосон юм бэ?

-АХА болон Бодь нь зөвхөн эрүүл мэндийн даатгал бус томоохон салбаруудын эрсдэл болох онгоц, эрчим хүчний станц зэргийн даатгал дээр мөн хамтарна. Бодь нь салбартаа хоёрдогч том компани. Тэд цаг үетэйгээ уялдан хөгжиж, өөрчлөгдөж чаддаг. Мөн тэд олон сайн менежертэй бас салбар олонтой учир түгээлт сайн.

-Ихэнх хөрөнгө оруулагчид Монголоос нүүрээ бууруулж байгаа үед Та Монголд бизнесээ эхлүүлж буй нь юунд найдсан шийдвэр вэ?

-Одоогийн эдийн засгийн удаашрал нь түр зуурынх. Дараагийн том төсөл хэрэгжээд эхлэнгүүт ажил эрхлэлт нэмэгдээд л ирнэ. Бидний үйл ажиллагаа явуулдаг Монголтой нэгэн адил хэдэн томоохон төслүүдээс ихээхэн хамаардаг Мьянмар, Шинэ Гвиней, Индонез зэрэг улст ч адилхан нөхцөл байдал үүсдэг. Одоохондоо ийм байгаа ч Монгол Улсын хэтийн төлөвт санаа зовохгүй байгаа.

-Бүс нутагтаа аль улс эрүүл мэндийн хувийн даатгалыг хамгийн сайн ашигладаг вэ?

Ерөнхийдөө, хөгжиж буй зах зээлтэй орнуудад улсын эрүүл мэндийн даатгалын тогтолцоо нь нэлээд асуудалтай байдаг. Тухайлбал, Энэтхэг, Индонез Хятадын иргэд нь эрүүл мэндийн нэгдсэн даатгалаараа үйлчилгээ авахад хүндрэлтэй тулгардаг. Энэ нь хувийн эрүүл мэндийн даатгал дутаж байгааг илэрхийлж байна. Олон газар маш урт дарааллууд үүссэн байдаг. Хэдийгээр Индонез улс нийгмийн хамгааллын шинэ тогтолцоо-юниверсал эрүүл мэндийн даатгал танилцуулсан ч

Индонезийн эмнэлгүүдийн үүдэнд асар урт дараалал байсаар л байна. Бидний бүтээгдэхүүн Индонезид сайн борлогддог. Бид олон зах зээлд амжилт олоод байгаа.

-Танай даатгалын бүтээгдэхүүн Монголын хэдэн эмнэлгийг хамрах вэ?

-Одоогийн байдлаар 6-8 голлох эмнэлэг гэж харж байна. Бид мөн гаднын эмнэлгүүд рүү очиж үйлчлүүлэх боломжоор хангана. АХА дэлхий даяар 12,000 эмнэлэгтэй гэрээтэй.

-Танай даатгал эмчилгээний зардлын хэдэн хувийг гаргах вэ?

-Худалдаж авсан бүтээгдэхүүнээс шалтгаална. Ерөнхийдөө 100 хувь бид хариуцна. Гэвч манай даатгалд хамрагдахаас өмнө туссан болон уг хүнд байсан өвчний эмчилгээг бид хариуцахгүй. Өөрөөр хэлбэл, Та манай бүтээгдэхүүнийг худалдаж авахаас өмнө зүрхний өвчтэй байсан бол бид танд зүрхтэй холбоотой ямар нэг үйлчилгээ үзүүлэхгүй гэсэн үг. Харин шинээр гарч ирсэн өвчин бол бид холбогдох бүх зардлыг гаргана.

-Уул уурхай гэх мэт эрсдэл өндөртэй салбарт танай компани бусад салбарынхаас өөр бодлого барьдаг уу?

-Салбараас шалтгаалан үнийн ачаалал гэж бий. Банкинд ажилладаг бол хямд бол уул уурхайн салбарын ажиллагсдын хувьд илүү үнэтэй. Бид “Бодь даатгал”-ын компанитай жилийн 500-3000 ам.доллар хүртэлх өртөгтэй олон бүтээгдэхүүн дээр хамтарч ажиллана.

-Хувийн эмнэлгүүд нэмэлт онош, эмчилгээ бичиж өгч тухайн хүний даатгуулсан компаниас үндсэн өртгөөс давсан мөнгө авахыг оролдох тохиолдол бий. Тэгвэл танайх онош зөв эсэхийг хэрхэн баталгаажуулдаг вэ?

-Бид нэхэмжлэлийг хянан шалгахад багагүй цаг зарцуулдаг. Манай компани чадвартай эмч, сувилагчдыг авч ажиллуулдаг. Тэд тухайн хүний эмчилгээний зардал хэд болохыг хэлээд өгдөг учир бид яагаад тав хоног эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх хүн 10 хонож байгаа, хоёр шинжилгээ өгөх өвчинд олон шинжилгээ өгүүлэх болсон зэргийг бид нэхэн асуун

хэлэлцдэг. Эмнэлэг, эмч нарын үүрэг бол хүмүүсийг эмчлэх байдаг ч тэд заримдаа илүү ихийг үрчих гээд байдаг. Ажил олгогчийн зүгээс эмчилгээний зардалд тийм их мөнгө зарцуулаад байхыг хүсэхгүй. Учир нь энэ нь даатгалд төлөх хөлсийг нь ихэсгэчихдэг. Бидний зүгээс хүмүүс тохирсон сайн эмчилгээгээ авч буйг баталгаажуулахын зэрэгцээ үйлчилгээний үнийг доогуур барихыг хичээдэг.

- Монголд зүрхний өвчлөл нэлээд өндөр үзүүлэлттэй байдгийг дуулсан байх. Энэ зах зээлд орж ирэхээс өмнө анхаарлыг тань татсан монголчуудын дундах өвчлөл, амьдралын хэв маяг юу байв?

-Бид бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхдээ тухайн улсын амьдралын хэв маягуудыг харгалздаг. Тухайн бүтээгдэхүүнийг бүхий л эрсдэл бүхий хүчин зүйлсийг тооцож үзсэн байдлаар зах зээлд гаргана. Хэрвээ аливаа нэг оронд тамхины хэрэглээ өндөр бол бүтээгдэхүүн илүү үнэтэй болно. Зах зээл болгон өөрийн үнэтэй. “Бодь”-той хамтран хэрэгжүүлэхээр зорьж буй бүтээгдэхүүнээр дамжуулан бид хүмүүсийг илүү зөв амьдралын хэв маяг руу залахыг хүсч байна. Эрүүл байхын тулд зөв хооллолт, дасгал хөдөлгөөн чухал. Зарим улсад бидний санал болгодог бүтээгдэхүүний багцад эрүүл зөв амьдрах үйлчилгээ багтдаг. Өөрөөр хэлбэл, хэрхэн эрүүл амьдрахыг хэлж өгч, одоогийн нөхцөлд юу, юуг өөрчлөх ёстойг зааж өгдөг.

-Монголчууд танай үйлчилгээг авснаар ямар давуу талуудыг мэдрэх вэ?

-Тоног төхөөрөмж сайтай шилдэг эмнэлгээр хурдан шуурхай оношоо тодорхойлуулж, чанартай үйлчилгээг цаг алдалгүй авснаар даатгуулагчид гэр бүл, ажил гэх мэт бусад ажил төрөлдөө илүү их цаг зарцуулах, төлөвлөлт хийх боломж олдоно. Мөн гаднын эмнэлгүүдэд ч цаг алдалгүй хүргэж эмчилгээ үзүүлнэ. Бидэнтэй уулзсан олон монгол хүн Өмнөд Солонгос, Өвөр Монгол, Хятад, Сингапурт очиж эмчлүүлж байсан гэж хэлсэн. Ийм хэрэгцээ шаардлага байгаа одоогийн нөхцөлд манай бүтээгдэхүүн үйлчилгээ сайхан боломж юм. ■

СУДАЛГАА

ЗАСАГЛАЛ-КОМПАНИЙН ИРЭЭДҮЙ

А.БҮРЭНЖАРГАЛ

“Компанийн засаглал” Монголд ямар байна вэ гэдэг асуултад төдийлэн сайн дүн сонсогддоггүй. Тэр дундаа төрийн өмчит компаниудын хувьд хаяхан мэргэжлийн байгууллагын шалгалт ордгийг эс тооцвол тэдэнд засаглалын талаар хийгдсэн судалгаа бараг байдаггүй.

Уг нь бол гадаад дотоодын зээл, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж урт хугацаанд тогтвортой ажиллах, үйл ажиллагаагаа амжилттай явуулах боломжийг компанийн засаглал олгодог гэж дэлхий даяар үздэг.

Тэгвэл манайд анх удаа төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалын талаар судалгаа хийжээ. Тус судалгааг Нээлттэй нийгэм форум энэ оны дөрвөөс наймдугаар сарын хооронд есөн компанийг хамруулан Олон улсын санхүүгийн корпорацийн боловсруулсан арга зүйг ашиглан Уул уурхайн яамтай хамтран хийсэн байна. Манай улсын хувьд компанийн засаглалын талаар сүүлийн жилүүдэд эрчимтэй яригдах болсон. Холбогдох дүрэм журам хууль эрх зүйн орчинг сайжруулах үйл явц шат дараалан хийгдэж байгаа ч судалгаанд хамрагдсан компаниудын засаглалын дундаж үнэлгээ тун хангалтгүй гарчээ.

Судалгааны зорилго нь улсын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалыг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулахад орших аж.

Судалгаанд хамруулсан компаниуд засаглалын үнэлгээгээрээ нийт 100 хувийн үнэлгээ авахаас 10-48 хувийн үнэлгээ авчээ. Энэ нь тухайн компаниудын үйл ажиллагаанд засаглалын талаарх хууль дүрэм, заалтууд хангалтгүй байгааг харуулж байна.

Дээрх үзүүлэлтээс харахад ихэнх компани авбал зохих онооны дөнгөн данган гуравны нэгийг л авч. Харин Оюутолгой компани 48 хувийн үнэлгээгээр тэргүүлжээ. Нийт компанийн засаглалын дундаж үнэлгээ 28 хувьтай гарсан байна. Энэ нь Вьетнам, Филиппин, Тайланд, Хонконг зэрэг Азийн зарим оронтой харьцуулахад 1.5-2.5 дахин бага үнэлгээтэй гэсэн үг.

Түүнчлэн судалгааны үзүүлэлтээс харахад төрийн өмчит компанийн засаглалын үнэлгээ хэт доогуур байна. Гэтэл

1 Компанийн засаглалын үнэлгээ



2 Азийн зарим орны компанийн засаглалын харьцуулалт

| Улсын нэр | Үнэлгээ хийсэн хугацаа | Үнэлгээ | Тайлбар |
|---|------------------------|---------|--------------------------------|
| Вьетнам | 2009 он | 43,9% | Улсын нэгдсэн үнэлгээ |
| Хонконг | 2008 он | 72% | -* |
| Тайланд | 2011 он | 77% | -* |
| Филиппин | 2008 он | 72% | -* |
| Монгол Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй ТОП20 компанийн дундаж | 2013 он | 27,5% | Нээлттэй ХК-ийн үнэлгээ |
| Монгол Улсын уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит компанийн дундаж | 2014 он | 28% | Төрийн өмчит компанийн үнэлгээ |

Азийн хөгжиж буй зарим орны компанийн засаглалын үнэлгээ 48-77 хувьтай байх жишээтэй.

“Төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалын үнэлгээ” судалгааг ахалсан ННФ-ын судлаач, гавъяат эдийн засагч Д.Байлхүү “Манай компаниудын ихэнх нь компанийн засаглалыг бүтээлчээр үйл ажиллагаандаа нэвтрүүлэх бус нэр төдий авч яваа нь өөрсдийнх өсөлт хөгжилд саад болж байна. Гадаадын хөрөнгө оруулалттай, хөрөнгийн биржэд бүртгэлтэй компаниудын үйл ажиллагаа харьцангуй ил тод байдаг. Ил тод байдал нь өөрөө тухайн компанийн засаглалын хувьд нэн тэргүүнд хэрэгжүүлэх ёстой үйл ажиллагааны нэг” гэлээ. Учир нь аливаа компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан ил тод байх ▶

► нь засаглал хэр хэрэгжиж буйг илтгэх үзүүлэлт болдгийг судалгааны баг онцолсон.

Сүүлийн жилүүдэд компанийн засаглалын талаар нэлээд яригдаж хууль эрх зүйн зохицуулалтыг ч компаниуд тусган ажиллах болсон.

Гэхдээ хуулиар зохицуулагдахгүй олон асуудал байдаг аж. Үүнд: компанийн бодлого байхгүй, тайлан баланс, цалин урамшууллын мэдээлэл нээлттэй бус, ТУЗ-ийн гишүүдийн ажлыг дүгнэдэггүй, хариуцлага хүлээдэггүй зэрэг багтана. Энэ байдлыг өөрчлөхийн тулд компаниуд дотоод үйл ажиллагаандаа нээлттэй байдлыг хэрэгжүүлэх, санхүүгийн болон үйл ажиллагааны ил тод байдлыг зорилго болгон ажиллах шаардлагатайг судалгааны төгсгөлд онцолжээ. Харин компанийн засаглалд сайн зүйл ажиглагдсан нь хяналтын тогтолцоо, засаглалтай холбоотой дүрэм журмыг бий болгож үйл ажиллагаандаа тусган ажиллаж байгаа аж.

Түүнчлэн судалгааны үр дүнг нэгтгэж төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн засаглалыг сайжруулах талаар төрөөс хийх ажлын зөвлөмжийг гаргасан байна. Судалгаанд хамрагдсан төрийн өмчит уул уурхайн компаниудад “Компанийн засаглалыг сайжруулах талаарх зөвлөмж”-ийг тус бүрийнх нь тайланд хавсаргаж өгсөнөөрөө энэхүү судалгаа нь ач холбогдолтой болсон талаар судлаачид тэмдэглэв. Тодруулбал, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанид төрийн төлөөллийн хэрэгжүүлэх ажиллагааг компанийн төрөл хэлбэрт нь тохируулаагүйгээс тухайн албан тушаалтны үзэл бодлоор шийдэгдэх алдаатай бодлого бүрийг сайжруулах зөвлөмжийг бэлтгээд байгаа аж.

Судалгааны үр дүнд төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалын хууль эрх зүйн заалт хэрэгжихгүй байгаагаас зарим албан тушаалтны эрх мэдэл давамгайлах, Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн, гүйцэтгэх удирдлага зэрэгт төрийн оролцоо хангалтгүй байгаагаас засаглал хүчтэй биш байна. Мөн аливаа албан тушаалтан өөрийн үзэл бодлоор асуудалд хандах биш “засаглал”-ыг компанийнхаа ирээдүйгээр хэмжих цаг

ирснийг тус судалгаа илтгэж байна.

Цаашид энэхүү судалгааг жил бүр явуулж, төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалд гарч буй ахиц дэвшлийг үнэлж байх аж.

Тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй компаниудаас төрийн өмчийн 10 компани байдгаас есөд нь дээрх судалгааг хийжээ. ■

3 Судалгаанд хамрагдсан компаниудын хэлбэр

| Хувьцаа эзэмшигчийн хэлбэр | Компанийн нэр |
|---|-----------------------------------|
| Төр дангаараа хувьцааг нь эзэмшдэг ХХК | Монатом ХХК Эрдэнэс монгол ХХК |
| ТӨК хувьцааг нь дангаараа эзэмшдэг хаалттай ХХК | Эрдэнэс оюу толгой ХХК |
| Төрийн өмч давамгайлсан ХК Нээлттэй ХК | Багануур ХК Шивээ Овоо ХК |
| Төрийн өмч давамгайлсан ХК Хаалттай ХК | Эрдэнэс ТТ ХК |
| Төрийн өмч давамгайлсан ХК Хаалттай ХХК | Эрдэнэт ХХК Монрсцвєтмет ХХК |
| Төрийн өмч оролцсон хаалттай ХХК | Оюу толгой ХХК |

4 Үнэлгээний үзүүлэлтүүдийн түвшинг тодорхойлох асуулга

| Үзүүлэлтүүд | Асуулгын дундаж тоо | Нийт дүнд эзлэх хувь |
|--|---------------------|----------------------|
| Хувьцаа эзэмшигч түүний эрхийн хэрэгжилт | 14 | 11 |
| ХЭ-ийн хурал | 15 | 12,3 |
| Төлөөлөн удирдах зөвлөл | 48 | 39 |
| Гүйцэтгэх удирдлага | 10 | 8 |
| Мэдээллийн ил тод нээлттэй байдал | 10 | 8 |
| Чухал хэлцэлүүд | 9 | 7,5 |
| Ногдол ашиг | 5 | 4,2 |
| Дүрэм болон засаглалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулж буй бусад эрхийн актууд | 5 | 4,2 |
| Хяналтын тогтолцоо | 8 | 6,4 |
| Тухайн компанийн асуулгын нийт дүн | 124 | 100 |



Гэрэл зургийг Б.Бямба-Очир



Сөүлд 100 орчим сая вонтой байхад хотын төвөөс холгүйхэн гурван өрөө байр худалдан авах боломжтой.

ТЭМДЭГЛЭЛ

ТЭД ХЭЗЭЭ Ч ХООРОНДОО ДАЙТАХГҮЙ ГЭДЭГТ ИТГЭДЭГ

Б.БАЯРТОГТОХ

Өмнөд Солонгост ажил хийхээр зорих монголчуудын цуваа сүүлийн жилүүдэд эрс багассан байна. Тэр тусмаа одоогийн Ерөнхийлөгчийнх нь авч хэрэгжүүлж буй шинэ бодлого дорно зүгт тэмүүлэх хэнд ч хатуу сонгогдож мэдэхээр. Амьдралаа сайжруулахаар очсон гаднынханд энэ нь тун таагүй байдлаар эргэж байгаа аж. Ийм хөндүүр сэдвээр тэмдэглэлээ эхэллээ. Тэндээс тээж ирсэн хатуу үнэнг дэлгэе. Дэлхийн эхний аравт орох эдийн засагтай тус улсад хууль бусаар ажиллаж амьдрах гаднынхан нутаг буцсаар байгаа аж. БНСУ-ын удирдагч Пак Гынхе солонгосчуудаа ажилтай, орлоготой болгох үүднээс ийн гадаадын ажиллах хүчнээс татгалзахад хүрчээ.

Шалтгаан нь солонгосчууд өөрсдөө ажилгүй байгаад оршиж байгаа юм. Өөрөөр хэлбэл, тухайн ажлын байранд нь гаднын иргэд ихээр ажиллах болсон нь нийгэмд сөрөг хандлага үүсгээд эхэлсэн байна. Иймээс зорилтот аян өрнүүлж, хяналт шалгалтыг өндөржүүлжээ. Энэхүү бодлогын хүрээнд хараар амьдардаг нутаг нэгтнээ барьж өгвөл 500 мянган воны урамшуулал олгоно гэсэн зар хүртэл түгээсэн гэнэ. Зөвхөн үүнээс болж цөөнгүй монголчууд нутаг буцсан гэж Сөүлд суралцаж буй Б.Болорчулуун ярьсан юм. Хагас Ерөнхийлөгчийн засаглалтай Өмнөд Солонгост албан бус тоогоор 30 гаруй мянган монгол хүн ажиллаж амьдарч байгаа гэх. Гэхдээ сүүлд явуулсан судалгаагаар 25 мянга гэж тогтжээ. ▶



Хоёр Солонгос нэгдэх цагийг билгээдсэн буддын сүм



Хан мөрнийг холбосон 27 гүүр байдаг



Тэд үндэсний дурсгалт газраар зугаалж байгаа нь.

► Ган хайлуулалтаар дэлхийд эхний гуравт, автомашин үйлдвэрлэлээрээ тавд багтах БНСУ хямд зээлээр үйлдвэрлэлээ дэмжиж, дараагийн “Самсунг”, “Хьюндэй моторс”-тэй зэрэгцэх хэмжээний брэндийг төрүүлэхээр шамдан буй. Төвбанкных нь мөнгөний бодлогын хүү манайхаас арав дахин бага бөгөөд инфляци нь гурван хувьтай тэнцэж байна. Мөнгөний бодлогын хүү нь хоёр хувиас хэтрэхгүй, тогтвортой. Мөн ам.доллартай харьцах воны ханш сүүлийн таван жилийн хугацаанд огцом хөдлөөгүй байна. Солонгост нэг ам.доллар 1035 вонтой тэнцэх бөгөөд зээлийн жилийн дундаж хүү 4.39 хувь. Энэ нь манай арилжааны банкуудын олгож буй ипотекийн зээлийн хүүнээс бараг хоёр дахин бага.

Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн, Азийн тэргүүлэх эдийн засаг импортлогч бус экспортлогч. Богино хугацаанд хөгжиж чадсан бөгөөд хөгжингүй орны зэрэглэлд хамаарагдах Өмнөд Солонгос одоогоос 50 жилийн өмнө Азийн хамгийн ядуу орнуудын нэг байсан гэдэг. Тэгвэл өнөөдөр дэлхийд шинээр үйлдвэрлэж буй гурван онгоц тутмын нэгийг тус улс үйлдвэрлэж буй. АНУ-ын хөгжлийн загварыг хуулбарласан хан улсын иргэдийнх нь дундаж цалин 2.5 сая вон. Сөүлд 100 орчим сая вонтой байхад хотын төвөөс холгүйхэн гурван өрөө байр худалдан авах боломжтой юм байна. Гадаад худалдааны гол түнш нь БНХАУ бөгөөд “Made in china” гэсэн шошго үйлдвэрлэгч орны зах зээлийг зээлсэн байгаа нь хачирхмаар.

“Өвлийн хайрын дуу”. Уншигч та үүнийг андахгүй мэдэх

байх. Хэдхэн жилийн өмнө монголчууд шимтэн үздэг байсан олон ангит уран сайхны киноны зураг авалт хийсэн газар өдгөө аялал жуулчлалын чухал үзэмэр болон хувирчээ, Сөүлд. Нами хэмээх жанжин амьдарч байсан гэх хэн ч үл анзаарах буйд арлыг “Өвлийн хайрын дуу” хөгжүүлж, жуулчдын төдийгүй солонгосчуудын зорин очих дуртай газрын нэг болсон байна. Үндэс нэг атлаа тусгаар улс болон орших нь Хойд, Өмнөд солонгосчуудын амьдрал, өнөөгийн хөгжил нь тэнгэр, газар шиг зөрүүтэй. Гэхдээ хоорондоо өширхөн дайснагн бус нэгдэн нийлэх тэр цагийг хүлээдэг гэмээр. Ийм цаг ирнэ гэдэгт эрхгүй итгэдэг бололтой. Хэдий дайны түгшүүр зарлахад бэлэн байх ёстойг ухаарсан ч үндэстэн хоорондоо дайтахгүй гэх битүүхэн горьдлого Өмнөд солонгосчуудад байдаг аж.

Хан мөрний хөвөөн дэх Дорнод Азийн улс бус БНСУ тусгаар тогтнолоо олоод 60 гаруй жилийг үдэн буй. Экспортод чиглэсэн эдийн засагтай тус улс Европын холбооны улс дахь экспортын хэмжээгээ нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа аж. Өөрөөр хэлбэл, Азийн зах зээлээс гадна Евро бүсэд ч эцсийн бүтээгдэхүүнээ нийлүүлэх туйлын хүсэлтэй байгаагаа илэрхийлсээр. Бидний өвөг дээдсийн довтолгоонд өртөж, 30 гаруй жилийн турш хараат байсан Хангүг үндэстэн Ази тивийн хөгжлийн чигийг тодорхойлдог. Хөх толботой хүүхэд төрвөл манай хүн гэж гүнээ итгэх солонгосчууд монголчуудад хүндэтгэлтэй ханддаг юм билээ. Будан суух уулс нь номин ногоон, нарны өнгөнд хувилах моддын навчис нь салхин нүүдэлтэй, Сөүлийн урт намар ард хоцорлоо. ■



Д.ЭНХБАТ: МОНГОЛ ДЭЛХИЙН НЭЭЛТТЭЙ МЭДЛЭГ МЭДЭЭЛЛИЙН ДАВАЛГААНД НЭГДЭХ ЁСТОЙ

МИНИЙ ЗОЧИН



“Mongolian Economy”
сэтгүүлийн Эрхлэгч Д.Бэхбаяр

“Миний зочин”. Ийм нэртэй буланг миний бие хөтлөн явуулахаар эхлүүлээ. Мэдлэг, оюун ухаан, авьяас, хөдөлмөр бүтээлээрээ амжилттай яваа хүмүүсийг урьж ярилцах юм. Зочид маань ямар ч салбарт ажилладаг, мөн ямар ч ажил эрхэлдэг байж болно. Сайд дарга, захирал, мэргэжилтэн, бизнесмэн, улстөрч, багш, эмч, ажилчин, газар тариаланч, малчин, оюутан гэх мэт. Сэтгүүлийн маань өмнөх дугааруудын зочдоор УИХ-ын гишүүн Р.Амаржаргал, Дэлхийн банкны зөвлөх Н.Энхбаяр нар оролцсон билээ. Энэ удаагийн “Миний Зочин” бол УИХ-ын гишүүн асан, “Нээлттэй мэдлэг боловсролын сан”-гийн ТУЗ-ийн дарга Д.Энхбат.

Монголд интернэт гэх ертөнцийг бидэнд нээж өгсөн Д.Энхбат захирал одоо интернэтийн хоёрдугаар шатыг хөгжүүлэхээр ажиллаж байна. Бидний ярилцлага мэдээллийн технологийн хөгжил, улс төр гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Эхний хэсэг та бидний өдөр тутмын хэрэглээ болсон технологийн хөгжлийн тухай үргэлжилнэ. Хоёр дахь хэсэг нь улс төрийн сэдвээр ярилцах бөгөөд тэрбээр “Би яагаад улстөрөөс гарсан бэ. Өнөөдрийн манай улстөрний тоглоомын дүрмээр Монгол улсад тулгараад буй асуудлуудыг шийдэх ямар ч боломжгүй. Мөнгөөр сонгуульд ордог, мөнгөөр намд ордог, мөнгөөр лидер болдог системтэй нөхцөлд хөгжлийн асуудлуудыг хэзээ ч шийдэхгүй” хэмээн хэлсэн юм. ▶

► **-Сангийн дэд сайд асан Ч.Ганхуяг “Би твиттерийн дагалдагчаар “Датаком”-ын захирал Д.Энхбатыг гүйцэх” хэмээн хэлсэн байдаг. Та одоо энэ ертөнцөд хэдэн дагалдагчтай байна вэ?**

-60 гаруй мянга. Миний өмнө олон хүн бий. Би өнөөдөр твиттерт тийм ч идэвхтэй байхгүй байгаа. Тоо чухал бус. Твиттерийг хэр суваг болгон ашиглаж байна гэдэгт анхаарах хэрэгтэй юм. Түүнээс 60 мянган хүнтэй чатлаад байвал юу болох вэ.

-Манайхан твиттерийг чат хэлбэрээр их ашиглаж байх шиг байна. Энэ ер нь ямар ертөнц юм бэ?

-Манайхан ихэнхдээ твиттерээр чатлаад байгаа. Энэ нь тухайн улсын боловсролоос ихээхэн хамаардаг. Гадны боловсролын тогтолцоо нь бичгийн хэлний соёлтой. Оюутнууд нь байнгын эссэ бичихэд суралцдаг. 10 ном уншаад ойлгосноо бичих хэлбэрээр явдаг бол Монголын боловсролын систем багшийн ярьсныг оюутнууд нь буцааж ярьдаг. Аман ярианы соёлтой. Блог хөтлөх, өөрийн сайттай байх соёл байхгүй. Багш самбарын өмнө зогсоод 30 хүүхдэд ярина. Багшийн ярьсныг буцааж хамгийн сайн ярьсан нь онц үнэлгээ авна. Гадаадад оюутан өөрөө мэдээлэл ухаад боловсруулж, судлаад багшид танилцуулдаг. Багш дасгалжуулагч шиг ажиллана. Багшаар дамжуулж боловсрол олгодоггүй. Манайх XVIII зууны ажилтнуудыг бэлтгэхэд зориулсан Европт мөрдөж байсан боловсролын системтэй. Тэгвэл мэдлэгийн эриний тогтолцоо нь өөрөө өөрийгөө авч явах, бүтээлч, хөдөлмөрч байхад чиглэж байна. Үүнээс хамаараад твиттерт хандах хандлага өөр байгаа юм. Уг нь хүмүүс твиттерээр өөрсдийн хийсэн бүтээснээ мэдээлэх, хуваалцах ёстой. Англи хэл дээрх твиттерийн үндсэн санааг үзэхээр үндсэн ажлынхаа мэдээллийг түлхүү өгөхөд чиглэсэн байдаг. Харин монголчууд ярианы хэллэг рүү оруулчихаад байгаа.

-Сошиал медиа манайд хэр хөгжиж байна вэ?

-Маш сайн. Бид өнөөдөр фэйсбүүкийг голтлоо хөгжиж байна шүү дээ. Гар утаснаасаа үнэгүй ярьж, материал, зургаа явуулж, бүхнийг хийдэг болсон.

Мэссэж явуулаад 10 секундын дараа хариу өгөхөд уурлаж байна. 20 жилийн өмнө таван секундын дотор хариу өгөхгүй бол уурлах байсан уу. Одоо бид интернэтийн дараагийн хөгжил рүү орох ёстой.

-Вэб сайтын хувьд борооны дараах мөөг шиг л олноор гарч ирж байна. Манай вэбүүдийн хөгжлийг харвал танд юу бодогддог вэ?

-Монголын вэб сайтуудыг би сайн мэдэхгүй. Гадны ганц хоёр сайтаар зочилдог. Манай хэвлэл мэдээллийн салбар миний дээр хэлсэн нэг багш яриад 30 хүн сонсдогтой адилхан. Нэг телевиз яриад арван мянган хүн үздэг. Үүнийг англиар push буюу түлхэх технологи гэдэг. Чамд мэдээллийг хүссэн ч, эс хүссэн ч өгдөг. Сүүлийн үеийн мэдээллийн урсгал татах технологид шилжсэн. Би хэрэгтэй үедээ л мэдээлэл авна. Над руу байнга мэдээлэл явуулах хэрэггүй. Өнөөдөр хүн бүр өөрөө сонин, телевиз болж байна шүү дээ. Тухайлбал, би жаран мянган дагалдагчтай. Блогоо сайн хөтөлбөл Монголын аль ч сонин, телевизээс илүү уншигчтай. Энэ бол давуу тал, технологийн хөгжил. Манай твиттер ертөнцөд 200-300 мянган хүн санал бодлоо хуваалцаж байна. Эдгээр хүнтэй харилцах, мэдээллээ солилцох, хүргэх технологийн боломж хүн бүрийн ширээ дээр бий.

-Та бичиж байгаа юу?

-Бичихгүй байгаа. Миний өмнөх сэдэв улс төр байсан. Одоо интернэтийн хоёр дахь хөгжлөөр удахгүй блогоо хөтөлж эхэлнэ.

-Хүүхдүүд фэйсбүүк гэх боллоо. Тэд эндээс сөрөг, янз бүрийн мэдээлэл их авч байна гэж эцэг эхчүүд дургүйлхэх болсон. Та яаж харж байна вэ?

-Очих газруудгүй учраас ордог ганц газартай гэдэг шиг энэ орчноос өөр зүйл интернэтэд байхгүй байна шүү дээ. Гэхдээ хүүхдүүд интернэтээр аялаад яваад байна. Гэтэл багш нар нь фэйсбүүкээ ч мэдэхгүй, сургуулийн захирлууд бүр ойлгохгүй сууна. Сургууль, банк, төрийн зарим байгууллагад интернэтийн орчин алга. Монголчуудыг мэдлэгийн, мэдээллийн ертөнцөөс хаягдчихсан улс гэж хэлж болно. Өмнөд Солонгосын хаана ч интернэт, онлайн үйлчилгээ бий. Тус улс эхлээд

гэрийн эзэгтэй нарт онлайн үйлчилгээг хүргэсэн байдаг. Хамгийн завтай, хамгийн их үйлчлүүлэх хүмүүс бол энэ бүлэг гэдгийг олж харжээ. Хүүхдийн хүмүүжил, боловсрол, хоол, эмнэлэг, сургууль эмэгтэйчүүдийн гоо сайхны бүх мэдээлэл, сургалт, зөвөлгөө интернэтэд бий. Өөрөөр хэлбэл, Солонгост интернэтийн хувьсгал гэрийн эзэгтэй нараас эхэлсэн. Хүүхдийнхээ цэцэрлэгт камер суурилуулаад ээж аавууд нь охиноо, хүүгээ хэрхэн хүмүүжиж, хооллож байгааг харж хянана. Цэцэрлэгийн багш нартай нь харилцана. Төрийн системтэй бодлогоор улсынхаа айл бүрийн гал голомтод интернэтийг ингэж хүргэснээр Өмнөд Солонгос эрчимтэй хөгжил рүүгээ орсон.

-Интернэтийн хөгжилд шинэ алхам хийх ямар шаардлага манайд байна вэ?

-Жаахан тайлбар хэлье. Улс орны хөгжлийн хөдөлгүүр нь чадвартай ажиллах хүчин. Бусад нь хөгжлийн нөөц. Чадвартай ажиллах хүчин байхад нөөцийг ашиглаж, боломжийг бий болно. Чадамж байхгүй бол нөөц, боломж байгаад ч түүнийг эдийн засгийн эргэлтэд зөв оруулж чадахгүй. Монголд хүмүүсийн чадвар маш бага, бусад оронтой харьцуулахад. Монголын хөгжлийг иргэдийнх нь оюуны чадвараар дүгнэнэ. Өөрөөр хэлбэл, гурван сая хүнийг зургаан тэрбум хүн дотор өрсөлдөж амьдрах тухай асуудал юм. Гадныхан биднийг жигнүүрийн нэг талд miningголиа гэсэн бол нөгөө талд нь би mind буюу майндголиа ухааны гээд байгаа юм. Уул уурхайн өсөлт, хүний чадвар нь хөгжил. Өсөлтийг яаж хөгжил болгох вэ.

Яагаад боловсрол гэж. Энэ асуудлыг хэдэн инженер, эрдэмтэн шийдэхгүй. Гурван сая хүн насан туршдаа тасралтгүй сурч боловсрох, мэргэжлээ дээшлүүлдэг, өндөр технологи эзэмшиж, инновацийн эринд хөл нийлүүлж байж дэлхийтэй өрсөлдөж амьдарна. Оюун санааны хувьд улс орноороо, ард түмнээрээ байнга сурах хөгжих, мэдлэгийн соёлтой үндэстэн болмоор байна.

Манай улсын өнөөгийн албан ёсны боловсролын систем залуудаа дээд сургуульд 4-5 жил сураад түүгээрээ 50 жил амьдрах. Хүмүүс амьдралынхаа хугацаанд 4-5 удаа мэргэжлээ, арваад удаа ажлаа сольдог статистик бий. ►

► Өнөөдөр хүн цоо шинэ зүйл сурах суралцах хэрэгтэй болж байна. 40,50,60 настай хүнийг сургах боломж манайд алга. Орчин үеийн боловсролын тогтолцоо долоон настнаас далан нас хүртлээ ажлын хажуугаар, гэрээсээ сурах нөхцөлийг бүрдүүлж өгч байгаа. Насан туршдаа сурна гэсэн үг. Тэр нь дөрөв таван жилийн сургуулийн программаар мэргэжил олгохдоо бус, хэрэгцээт зүйлээ сурахад чиглэнэ. Жишээлбэл, шинээр компани эрхэлж буй хүн

80 гаруй мянган хүн үүнийг хийж бичиж байгаа бол зургаан тэрбум хүн чөлөөтэй уншиж хэрэглэж байна. Хамгийн анхны том, амжилттай төсөл. Хамтын нээлттэй соёлд монголчууд өөрсдөө оролцох ёстой.

Хоёр дахь том загварыг Монгол дотроо зохион байгуулах хэрэгтэй байна. Дунд сургуульд 27 мянган багш нар ажилладаг ч математикийн сурах бичгийг 4-5 багш л хийдэг. Бусад нь яагаад оролцохгүй байгаа юм. Дээд

байхгүй. Дэлхийд олон нийтийн буюу нээлттэй өмчийн хэлбэр байдаг. Тухайн бүтээгдэхүүнийг гурван сая хүн бүгд хэрэглэж болно гэсэн хамтын өмчийн хэлбэр. Цаашлаад дэлхийн бүх хүн хэрэглэж ашиглах боломжтой. Бид Монгол Улсад өмчийн ийм нээлттэй хэлбэрийг бий болгохоор ажиллаж байна. Тухайлбал, Монголын түүхийн номыг дэлхийн бүх хүн хэрэглэж, гэртээ хэвлэж болно, CD-нд ч хувилж болно. Өөрийн өмч шиг хандана гэсэн үг. Үүнийг хийхэд олон зуун мянган хүн оролцдог. Монголчууд эхлээд дотроо, бүгд нийлээд гадагшаа ажиллах шинэ мэдлэг мэдээлэл, соёлын асуудлыг би яриад байна. Мэдлэгийн болон материаллаг баялаг нь олон хүн хуваах тусам багасдаг бол мэдлэгийнх олон хүн хуваах тусам ихэсдэг. Мэдлэгийн эдийн засгийн нууц энэ юм. Үнэгүй тараана гэхээр манайхан материаллаг талаас буруу ойлгоод байгаа.

Интернэтийн хоёрдугаар үе буюу агуулга мэдлэгийг өгөх ажлыг эхлүүлж байна. Товчлоод энэ бүх ажлыг хийсний дараах 10 жилийн зургийг дүрсэлбэл, монголчууд дэлхийн төрөл бүрийн онлайн сургууль, сургалтад жилийн 365 хоногийн 24 цагийн турш холбогдох боломжтой болно.

Бид Сангаа саяхан бүртгүүлсэн. Монголд бухимдалтай асуудал олон ч гар нийлбэл асуудал хурдан явдгийн жишээ манай сангийн ажил юм. Хөтөлбөрөө УИХ-аар батлуулаад Засгийн газрын 15 жилийн хөтөлбөр болгосон. Хууль дүрэм нь гараагүй байхад төрөөс санаачлаад мөнгө гаргаж байна. Дэлхийн дахинд нээлттэй Хаан академийн англи хэл дээрх 4000 видео кино хичээлүүд байдаг. Дунд сургуулийн математик, физик зэрэг бүх хичээлээр хийсэн 15 минутын видео. Дэлхийн хүүхдүүд үзэхэд зориулсан нээлттэй хичээл. Манай сан тус академтай гэрээ хийгээд монгол руу орчуулах эрх авсан. Боловсролын ямаар дамжуулан УИХ-ын гишүүдээр дэмжүүлж, эхний 1000 киног хийх санхүүжилт батлуулсан. Тэгэхээр хүүхдүүд математикийн томъёонуудыг гар утас, компьютер дээрээ гэртээ үзэж хичээлээ давтах нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

-Монгол Википедиа толь бичгийг хийх гэж байгаа тухай сонссон?

-Монголын түүх,соёл хэлний толь бичиг Википедиа төслийг эхлүүлсэн. Хэцүү ажил. Монголчууд хамтарч чаддаггүй юм байна. Эрдэмтэд компьютер мэдэхгүй, хамтын ажиллагааг ойлгохгүй, залуус нь ►

санхүүгийн тайлан яаж хөтөлдгийг нэг өдрийн, 14 хоног, гурван сарын сургалтад суугаад л юу хэрэгтэйгээ олоод авна. Тэгэхээр цаашид монголчууд яаж тасралтгүй суралцдаг үндэстэн болох вэ гэдэгт анхаарах шаардлагатай байгаа юм.

-Тасралтгүй насан туршдаа суралцдаг үндэстэн болох урсгалыг яаж бий болгох вэ?

-Хоёр зам бий. Нэг нь дэлхий нийтээр өргөн тархсан нээлттэй мэдлэг мэдээллийн соёл, давалгаанд нэгдэх ёстой. Дэлхий даяар хэрэглэж буй программ хангамжийн 70 гаруй хувь нь үнэгүй. Олон мянган хүн ажиллаад үнэгүй тарааж хэрэглүүлж байна. Тухайлбал, дунд сургуулийн сурагчдын сурах бичгийг олон мянган эрдэмтэн нийлж бичээд интернэтэд тавьж хүүхдүүдэд үнэгүй ашиглуулдаг. Ном, зохиол, кинонууд байна. Бүр ч үнэгүй гэж хэлж болохгүй. Солилцоо хэлбэрээр түгээдэг. Би нэг төсөл эхлүүлж байгаа. Бизнес эхэлж буй хүмүүст 50 видео кино хийж үнэгүй тараана. Нэг компани нэг видео киног спонсорлоод 49 киног үнэгүй авна. Нэгийг өгөөд 100-г үнэгүй ав. Энэ бол хамтын ажиллагааны нээлттэй соёлтой солилцоо. Дэлхий дээрх хамгийн том жишээ Википедиа юм.

сургуулийн багш нар мөн адил. Монгол хэлний толийг зөвхөн монгол хэлний багш нар бус бүх салбарын эрдэмтэн доктор, судлаач нар оролцсоноор сайн, чанартай, мэргэжлийн толь бичгийг гаргаж ирнэ. Геологийн нэр томъёог монгол хэлний багш нар геологичоос илүүтэй тайлбарлаж чадах уу. Дэлхий өнөөдөр бүгд өгнө, бүгд авна зарчмаар ажиллаж байна. Тэгэхээр нээлттэй мэдлэг боловсролын тогтолцоонд нэгдэх ажлыг манайд мэдлэг оюун, технологи, зохион байгуулалт, санхүү, хууль эрх зүйн орчин, олон улсын хамтын ажиллагааны хувьд яаж хийх вэ.

-Энэхүү том ажлыг хийхийн тулд “Нээлттэй мэдлэг боловсролын сан” байгуулагдсан гэж ойлгож байгаа?

-Тиймээ. Сангийн гол зорилго энэ төслийн санхүүжилтийн нэгдсэн системийг боловсруулах ёстой. Санхүүжилт нэлээд хүндрэлтэй. Ганцхан жишээ хэлэхэд манай төр, хувийн өмчийнхөн хамтраад хүүхэлдэйн кино хийе гэж бодъё. Боловсролын яамны өмч гэхээр хийсний дараа нь хувийнхан төрийн компанид мөнгө өгөхгүй. Хувийн өмч бол яам тэдэнд санхүүжилт олгохгүй. Хамтарч ажиллах хэлбэр манайд

► үнэгүй хийхгүй гэдэг. Түвшин түвшинд ойлгуулахын тулд семинар, уулзалт, сургалтууд зохион байгуулна. Анхны идэвхтэй бүтээл хийсэн хүмүүс, байгууллагыг урамшуулна. Мөн бид Гүүгл компанитай хамтраад Гүүглийн бүх программ хангамж үйлчилгээг Монголын залууст насан туршид нь үнэгүй өгөхөөр тохирсон. Гэх мэтчилэн том ажлууд эхэлсэн явж байна.

-Таны хувьд энэхүү хөдөлгөөнийг үүсгэн байгуулагч, зохицуулагч хийж байгаа юу?

-Интернэтийн нэгдүгээр үед бүх иргэнд интернэтийг ойлгуулж, хүргэх байсан. Интернэтийн хоёрдугаар үед агуулга мэдлэгийг өгөх. Товчлоод энэ бүх ажлыг хийсний дараах 10 жилийн зургийг дүрсэлбэл, монголчууд дэлхийн төрөл бүрийн онлайн сургууль, сургалтад жилийн 365 хоногийн 24 цагийн турш холбогдох боломжтой болно. Энгийнээр хэлэхэд өргөн хүрээтэй онлайн Нарантуул захыг бий болгож байгаа юм. Зарим багш нар хичээлээ өгч болно. Нэг жишээ хэлье.

Солонгосын англи хэлний багш интернэтэд өөрөө видео хичээл хийж, давтлага өснөөр жилийн дотор дөрвөн сая ам.доллар олсон тухай Фортун сэтгүүлд нийтлэгдсэн. Тийм өндөр хэрэгцээ интернэтэд байна. Монголын хүүхэд, залууст, англи хэл, компаниудад компьютер эзэмших хэрэгцээ асар их. Гэрийн эзэгтэй нарт хүүхдээ хэрхэн асрах, хоол яаж хийх, эмнэлгийн үйлчилгээ зэрэг мэдлэг хэрэгтэй. Дээд сургуулийн оюутнуудад төрөл бүрийн хичээл, давтлага, лекц, төрийн албан хаагчдад төрийн удирдлага, менежментийн сургалтууд, компаниудад бизнес зөвлөгөө шаардлагатай байна.

Бусад улс орон энэ хөгжил рүү хэдийнэ орчихсон. Олон янзаар туршиж байна. Интернэтийн хоёр дахь хөгжлийг эхлүүлэхэд төрөөс дэмжиж, идэвхжүүлж, хөгжүүлэх ёстой. Төр татвар төлөгчдийн мөнгөөр гурван сая хүнд хамгийн хэрэгтэй зүйлийг нь хийж өгнө гэсэн үг.

-Төрийн түшээд ойлгож байна уу?

-Ойлгож байгаа учраас улстөрчид төслийг дэмжээд явж байна. Энэ нь улстөрждөг асуудал биш, бүгд дэмжиж, хамтарч бүтээх том үйлс.

Монголчуудын соёлыг өөрчлөх сэтгэлгээний том төсөл. Монголчууд мэдлэгт түшиглэж хоолоо олж иддэг болно. Мэдлэгт түшиглэж хоолоо олж идэхийн тулд тэр хүн бактериагаа, оюун тархиа байнгын цэнэглэх хэрэгтэй болно доо. Тийм орчин, сонголт нээлттэй байх. Үүнд бид өөрийгөө, хүүхдүүдээ бэлтгэх ёстой. Хамгийн онцлог нь манай хүүхдүүд бэлэн байна. Харин багш нар хоцрогджээ. Аль ч сургууль дээр очиход толгойны өвчин багш нар, хамгийн хэцүү хүн нь захирал. Бага ангийн хүүхдүүд тусмаа алив зүйлийг маш амархан тусгаж авдаг. Залуу үе нийгмийн шаардлагаар явж байгаа. Түүнийг нь багш нар, улстөрчид, дунд үеийнхэн гүйцэхгүй байна.

Миний энэ яриад буй зүйлийг манай залуус ер нь яагаад байхгүй байгаа юм гэж гайхаж байна. Тэгэхээр бид залуусаа гүйцэж л байвал том амжилт. Өнөөдрийн байдлаар төсөл эхлэх түвшинд байгаа ч гадаадын түншүүдтэйгээ гэрээ хэлэлцээр хийгээд гарын үсэг зурчихсан. Хамгийн хүндрэлтэй нь маш их судалгаа шинжилгээ хийх ёстой. Туршилтын журмаар идэвхтэй ажиллаж буй хүмүүс

-Танай Датаком компанийн үйл ажиллагаа өнөөдөр ямар яваа вэ?

-Компанийнхаа ажилд оролцохгүй байгаа. Манай компани домайн нэрийг монгол болгох ажлыг хийгээд дуусаж байна. Хүмүүс, байгууллагууд домайн нэрээ монгол үгээр авч болно гэсэн үг. Тухайлбал, итали гутал зарна гэсэн нэр аваад нэг хуудас вэбтэй байхад бизнес өргөжөөд ирэх боломжтой. Монгол Улсад их ач холбогдолтой ажил юм.

Монголчууд Пу, Си-гийн талд хуваагдана

-Та улс төрөөс бүр гарчихсан уу. Намын гишүүн хэвээр байгаа юу?

-Надад сонголт байсан. УИХ-ын гишүүнээр дахин сонгогдоод явах уу, эсвэл өөр ажил хийх үү. Шийдэл нь улс төрд биш, сэтгэлгээнд байгааг ойлгосон. Миний сонголт УИХ-ын сайн, мууд биш юм аа. Интернэтийн хөгжлийг урагшуулах нь миний УИХ-д суухаас илүү том өргөн цар хүрээтэй, маш чухал ач холбогдолтой, Монгол улсын соёлыг шинэчлэн өөрчлөх учраас ийм шийдвэрт хүрсэн.

Юу хийхээ мэдэхгүй хүнд мөнгө тус болдоггүй гэдэг. Монгол улс яг л ийм байдалд орчихсон. Монголчууд яг юу хүсэж, мөрөөдөж, хийх гээд байгаагаа мэддэггүй гэж гаднынхан дүгнэж байна. Монголын проблем бол улс төрийнх бус хэн бэ гэдгээ, юу хүсэж буйгаа мэдэхгүй явдал.

бий. Хаан академийн хичээлүүдийг орчуулах ажлыг МУИС, Орчлон дунд сургууль, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, төрийн бус хоёр байгууллага хийж буй. Өнөөдөр 200 видеог нь гараас гаргасан. Том ажил. Монгол хэл рүү орчуулна, зургийг засна, дуу хоолой оруулна, багш нарын гарын авлага хийнэ гэх мэт. Удахгүй төсөв мөнгө батлагдахаар багш нарт сургалт, семинар хийнэ зэрэг олон ажил зохион байгуулна. Үүнийг үндэстний том бодлого болгох хэрэгтэй гэж би үзэж байгаа.

Одоо би намын гишүүн бус. Би яагаад улстөрөөс гарсан бэ. Өнөөдрийн манай улстөрийн тоглоомын дүрмээр Монгол улсад тулгараад буй асуудлуудыг шийдэх ямар ч боломжгүй. Мөнгөөр сонгуульд, намд ордог, лидер болдог системтэй нөхцөлд хөгжлийн асуудлуудыг хэзээ ч шийдэхгүй. Хувийн эрх ашиг, хувийн бизнесийн сонирхол, тендерт ялах хүслээр орж ирсэн бүлэг, командтай байхад улс яаж хөгжих билээ. Өндөр мэргэжлийн технократууд командаар шүдээ тас зууж байгаад хувийн эрх ►►

▶ ашгаа хойш нь тавьж ажиллавал байдал өөрчлөгдөнө. Түүнээс хөлбөмбөгийн багийн 10 дугаарын тоглогч байхын тулд мөнгө өгөөд л гарч ирдэг бус, хамгийн хурдан гүйдэг, дамжуулах арга барил сайтай, харах, бодох, сэтгэх чадвартай шилдэг тоглогч байх ёстой. Багийн 11 хүний нэг нь нөгөө арваа сонсохгүйгээр цааш нэг баг болоод явж чадахгүй. Монголын улс төр өөр түвшинд гарах хэрэгтэй байна. Мөнгөөр бүхнийг шийддэг энэ байдал улс орны хөгжлийн төлөө командыг бүрдүүлэх боломжгүй юм аа.

Юу хийхээ мэдэхгүй хүнд мөнгө тус болдоггүй гэдэг. Монгол улс яг л ийм байдалд орчихсон. Монголчууд яг юу хүсэж, мөрөөдөж, хийх гээд байгаагаа мэддэггүй гэж гаднынхан дүгнэж байна. Монголын проблем бол улс төрийнх бус хэн бэ гэдгээ, юу хүсэж буйгаа мэдэхгүй явдал гэж энгийнээр хэлэх байна.

-Сүүлийн үед улс төрийн намуудын хөгжил, төлөвшлийн тухай их ярих боллоо. Улс орны хөгжил намуудаас шалтгаалаад байгаа учраас тэр байх?

-Орчин үед нам нь иргэдийн төрийн эрхэд оролцох гүүр байх ёстой. Германы Ногоон намыг би сайн мэднэ. Намын их хуралд аль ч намын хүн сууж болно. Асуудлыг өөр намын хүн ч оруулж ирж болно. Жинхэнэ иргэдийг төлөөлсөн олон нийтийн байгууллага гэдэг утгаар ажилладаг юм билээ. Манайд бол намын гишүүд бус мөнгө төлсөн спонсоруудын нам шүү дээ. Өөр сонирхолтой, түүнийхээ төлөө мөнгө төлсөн хүмүүсийн лобби бүлэглэл. Тэр хүмүүс л УИХ-д уралдана. Түүнээс жирийн гишүүд ямар ч үүрэггүй.

1990 оноос хойш манай улсын бүх зүйл өөрчлөгдсөн. Ганцхан намууд бахь байдгаараа үлдсэн. Монгол улсын амин чухал асуудлууд намаар шийдэгдэх механизмтай. Манай улс төрийн намууд хүй нэгдлийн үеийнхээрээ гээд бод. Хэн мөнгөтэй, хэн ууртай, хэн их ярьдаг нь дийлдэг. Энэ сэдвээр би Шинэ Зеландын улстөрийн хоёр судлаачтай уулзаж ярилцаж байлаа. Тэд бусад орны туршлагаар хоёр л зам байдаг гэсэн юм. Нэг нь үхэж дуусна. Баабарын

хэлдгээр. Нөгөө нь бүгдийг буудах. Тэгэхээр танай улсад үхэхийг хүлээх, эсвэл ямар нэг аргаар тэднийг зайлуулах аргууд байна гэж билээ. 10 дээрэмчин, худал, хулгайчууд нэгдэн нийлж, нэг команд болж хэзээ ч ажиллаж чаддаггүй юм байна л даа.

-Одоо тэгээд яах вэ?

-Монголд өрнөсөн өөрчлөлтүүд ихэнхдээ гадны нөлөөллөөс хамаарсан байдаг. 1911 онд Манжийн засаг унасан, 1921 онд Барон Унгерн орж ирсэн, 1945 онд Японы дайн, 1961 онд дэлхийн ардчилсан орнуудын, 1990 он перестройка Оросын өөрчлөн багуулалт. Тэгэхээр одоо Оросын Путин, Хятадын Си Жимпин хоёр манай улсыг өөрчилж магадгүй. Би улстөрийн намуудын талаарх өөрийн прогнозыг хэлье.

МАН, АН, аль ч нам цааш явахгүй. Одоо монголчууд намаар биш, Пу, Си-гийн тал гэж хуваагдана. Учир нь Алтанхуягийг дагаад 10 жилийн дараа сайхан хөгжилд хүрнэ гэж АН-ынхан итгэхгүй. МАН ч мөн адил.

өгүүлэлд бүр тод томруунаар бичсэн байсан. Хятадууд ч мөн ингэж бодож байгаа. 100 жилийн өмнөх шиг Хятад, Орос, Америкаар хуваагдана. Намууд хамаагүй. Яагаад гэвэл Монголд хөгжлийн тодорхой санаа алга. Санаа байлаа гэхэд аваад явах лидер байхгүй. Лидер төрүүлэх боломжгүй дүрэмтэй улс.

Жинхэнэ лидер ганцхан тохиолдолд төрдөг. Тэрний төлбөрийг амиараа ч хамаагүй төлөхөд бэлэн гэсэн хүмүүс бий болсон тохиолдолд лидер төрнө. Ганц хүн биш л дээ. Тодорхой тооны хүн. Өөрөөр хэлбэл, бид үүнийг хийчихээд үхсэн ч хамаагүй гэсэн хүмүүс гарч ирэх үед л байдал өөрчлөгдөнө. Монголын төлөө цохилох зүрхтэй төрийн хар хүн ч өнөөдөр тун ховор. Гурван сая хүний хувь заяаны төлөө үнэн сэтгэлээсээ санаа зовдог хүн л дээ. Лидер бэлтгэнэ гэхээр ганцхан Доржийг гээд явдаггүй. Арван мянган хүнийг спорт шиг л бэлтгэж байж төрүүлнэ. Монголын хүүхэд бүрийг багаас нь бэлтгэх хэрэгтэй. Түүнээс баян айлын 10 хүүхдийг сонгоод англи хэлтэй сургуульд

Саяхан Оросын сэтгүүлүүд дээр Оросын Монголд хийсэн алдааны талаар нэг өгүүлэл гарсан. Гол утга нь Монголд бид өөрийн нам, өөрийн хүнтэй болоогүй нь том алдаа гэсэн утгатай өгүүлэл нийтлэгдсэн. Орос улс цаашид энэ тал дээр анхаарах хэрэгтэй. 2016 оны Монголын УИХ-ын сонгуульд Оросын талын хүмүүсийг гаргах хэмээн бүр тод томруун бичсэн байсан.

Яагаад гэвэл Монголыг зангидах жинхэнэ лидер байхгүй байна шүү дээ. Найдвар Хятад, Оросыг дагах. Хүмүүс томьёолж чадахгүй ч цаад учрыг сайн мэдэж байгаа. Саяхан Оросын сэтгүүлүүд дээр Оросын Монголд хийсэн алдааны талаар нэг өгүүлэл гарсан. Гол утга нь Монголд бид өөрийн нам, өөрийн хүнтэй болоогүй нь алдаа гэсэн утгатай өгүүлэл байв. Орос улс цаашид энэ тал дээр анхаарах хэрэгтэй. 2016 оны Монголын УИХ-ын сонгуульд Оросын талын хүмүүсийг гаргах хэмээн тэр

сургаад Харвард явуулах тухай яриа биш. Япон, солонгосчууд хүүхдүүдээ багаас нь шударга, ажилсаг, оюунлаг байх талаас нь харж, төлөвшүүлж хүмүүжүүлсний үр дүнд өнөөдрийн хөгжилд хүрсэн.

Тэгэхээр Монголын улс төр эмоциийн үеэсээ одоо институцийн үе рүү шилжих цаг болсон. Улс төрд эмоци хэрэгтэй байсан он жилүүд бий. Одоо хуучин арга барилаасаа салж, шинжлэх ухаан, өндөр технологи, чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх, мэдлэг шүтэх шаардлагатай байна. ▶



Д.Энхбат: Монголын улс төрийн намуудын хөгжил хүй нээдлийн үеийнхээр гээ д бод.

▶ Ардчилсан, ардчилсан бусаар хэрэлдэж, сэргөлдөхгүйгээр улс төрийн дөрвөн жилийн сонгуулийн циклээс гарч эрүүлээр асуудалд хандмаар байна. Улс орныг улстөрөөр удирдахаа болиосой.

-Эдийн засгийн хүндрэл танд нөлөөлж байна уу?

-Маш их. Энэ хүндрэлийг орлогоо өөрийн хөдөлмөр, зүтгэлээр олдог хүмүүс ихэд мэдэрдэг. Харин орлогоо төсвийн мөнгөнөөс хумсалдаг, авлигаас, албан тушаалаас бүрдүүлдэг хүмүүст эдийн засаг хүндрэх эсэх хамаагүй.

-Та Алтанхүягийн Засгийн газарт ямар дүн тавих вэ?

-Маш том боломжийг ашигласангүй. Монгол улсын нэр төр, уул уурхайгаас их мөнгө олсон. Тэрийгээ шингээж чадсангүй дээ. Тиймээс хийсэн ажилд нь дүгнэлт өгч, хангалтгүй бол явуулах ёстой. Үнэхээрийн мэдлэг чадвар, ажлаараа сонгогдсон бол ажлаа дүгнүүлээд цааш явах эсэхээ шийднэ. Мөнгөөр сонгогдсон бол илүү их мөнгө өгсөн хүнийг гарч иртэл гүрийгээд байна. Монголын улс төрийн дүрэм энэ. Намд хамгийн их мөнгө өгсөн хүн л том байдаг хууль үйлчилдэг.

Ер нь монголчууд бид хэдий болтол хоёр нүүрээр амьдрах вэ. Үнэнээр явж байгаа зүйл байна уу. Эмнэлэг, шүүх, сургууль, банкны асуудал бүгд таньдаг хүнээр шийдэгддэг. Хуурамчаар хөгжиж, хуурамчаар асуудлыг шийдэж болдог юм уу. Чехийн Ерөнхийлөгч Вацлав Хавел өөрийн номондоо “Ардчилал бол олон намын тогтолцоо биш, үр дагавар нь. Харин ардчилал бол өөрийн хүсэж буй амьдралаар амьдрах боломжийг хэлнэ. Нийгэм чиний хүссэнээр, үнэн нүүр царайгаараа амьдрах боломж олгохгүй байвал тэр ардчилсан нийгэм биш. Олон намтай эсэх хамаагүй, иргэн хүн хуурамчаар амьдрахаас өөр аргагүйд хүрвэл тэр ардчилал биш” гэж бичсэн байна.

Монголчууд бид хоёр нүүрээр амьдардаг байдлаа хэзээ цэгцлэх вэ. Өнөөдөртөө аргалаад, яваад байж болно. Хэр удаан явах уу. Үргэлж аргална, үргэлж царай алдана. Хэзээ өөрчлөгдөх бол. ■

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

“ЧИНГИС” БОНДЫН ЗАРЦУУЛАЛТ

С.АЗ

“Чингис” бондын хөрөнгийг ямар компаниудад өгсөн нь олон нийтэд төдийлэн ил бус. Тиймээс манай сэтгүүл “Чингис” бондоос ямар аж ахуйн нэгж хэдэн төгрөгийн зээл

авсныг цувралаар хүргэж буй. Өмнөх дугаарт хөдөө аж ахуйн салбар болон “Гудамж” төслийн зарцуулалтын талаар мэдээлсэн. Мөн эрчим хүч болоод барилгын салбарт хэрэгжүүлсэн төслийн хүрээнд хэчнээн компанид


хэдэн төгрөг өгснийг дэлгэрэнгүй нийтэлсэн билээ. Харин энэ удаа аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбоход гүйцэтгэгчээр ажиллаж буй компаниудын жагсаалтыг хүргэж байна.

Аймгийн төвүүдийг Улаанбаатартай холбох авто замын санхүүжилт (тэрбум төгрөгөөр)

| | Замын урт | Төсөвт өртөг | Гүйцэтгэгч | Санхүүжүүлэгч | ЧБ-оос санхүүжүүлсэн | ХБ-ны эх үүсвэрээс санхүүжүүлсэн | Нийт санхүүжилт | Ажлын гүйцэтгэл (%) |
|---------------------------------------|-----------|--------------|--------------------------------------|---------------|----------------------|----------------------------------|-----------------|---------------------|
| Улаанбаатар -Мандалговь чиглэл | | | | | | | | |
| 1 | 104 км | 49.2 | "Монголын Хурдны Зам" ХХК | Хөгжлийн банк | 31.8 | 12.9 | 44.7 | 100.0% |
| 2 | 100 км | 42.5 | "Шинжиан Констракшин Инженеринг" ХХК | Хөгжлийн банк | - | 19.2 | 19.2 | 100.0% |
| Нийт | 204.0 км | 91.7 | | | 31.8 | 32.1 | 63.9 | |
| Мандалговь-Даланзадгад чиглэл | | | | | | | | |
| 1 | 163 км | 69.3 | "Шинжиан Констракшин Инженеринг" ХХК | Хөгжлийн банк | 31.4 | 34.6 | 66.0 | 100.0 |
| 2 | 25 км | 13.3 | "Эсто" ХХК | Хөгжлийн банк | 10.9 | - | 10.9 | 60.4 |
| 3 | 25 км | 13.3 | Мадимос групп, Наранбулаг хан ХХК | Хөгжлийн банк | 6.9 | - | 6.9 | 60.4 |
| 4 | 43 км | 21.5 | "Ялгуусан" ХХК | Хөгжлийн банк | 15.8 | - | 15.8 | 56.7 |
| 5 | 20 км | 10.0 | "Шинжиан Шин Фа" ХХК | Хөгжлийн банк | - | - | - | 4.0 |
| 6 | 20 км | 10.0 | "Шинжиан Шин Фа" ХХК | Хөгжлийн банк | - | - | - | |
| Нийт дүн | 296.0 км | 137.3 | | | 65.0 | 34.6 | 99.6 | |
| Арвайхээр-Баянхонгор чиглэл | | | | | | | | |
| 1 | 57 км | 24.0 | "Шинжиан Бэйшин" ХХК | Хөгжлийн банк | 11.1 | 12.0 | 23.1 | 100.0 |
| 2 | 50 км | 21.5 | "Нэйшнл девелопер" ХХК | Хөгжлийн банк | 10.5 | 10.7 | 21.3 | 100.0 |
| Нийт | 107.0 км | 5.5 | | | 21.6 | 22.7 | 44.3 | |
| Өндөрхаан-Чойбалсан чиглэл | | | | | | | | |
| 1 | 30 км | 15.8 | "Насны зам" ХХК | Хөгжлийн банк | 10.4 | - | 10.4 | 51.8 |
| 2 | 27 км | 14.3 | "Хансуун зам" ХХК | Хөгжлийн банк | 8.9 | - | 8.9 | 49.1 |
| 3 | 27.75 км | 14.7 | "Гашууны гол" ХХК | Хөгжлийн банк | 7.5 | - | 7.5 | 49.4 |
| 4 | 10.65 км | 5.8 | "ЗЗБ" ХХК түншлэл | Хөгжлийн банк | 3.5 | - | 3.5 | 51.2 |
| 5 | 143 км | 60.8 | "Насны зам" ХХК | Хөгжлийн банк | 11.2 | - | 11.2 | 73.0 |
| 6 | 50 км | 12.6 | "Чайна Жео" ХХК | Улсын төсөв | - | - | - | 65.0 |
| Нийт | 288.4 км | 123.9 | | | 41.5 | - | 41.5 | |
| Өндөрхаан-Баруун урт чиглэл | | | | | | | | |
| 1 | 132.6 км | 66.3 | "Арж капитал" ХХК | Хөгжлийн банк | 17.9 | 14.8 | 32.7 | 34.4 |
| 2 | 45.3 км | 21.5 | "Түм ариажих" ХХК | Хөгжлийн банк | 10.6 | - | 10.6 | 49.7 |
| Нийт | 177.9 км | 87.8 | | | 28.6 | 14.8 | 43.4 | |

| Булган Уньт- Тариалан-Мөрөн чиглэл | | | | | | | | |
|--|-----------|---------|--------------------------|---------------|----------------------|----------------------------------|-----------------|---------------------|
| 1 | 79 км | 37.0 | "Эйч Кей Би" ХХК түншлэл | Хөгжлийн банк | 22.4 | 7.7 | 30.1 | 100.0 |
| 2 | 32 км | 17.1 | "Хотгор зам" ХХК | Хөгжлийн банк | 10.6 | - | 10.6 | 40.0 |
| 3 | 25 км | 13.1 | "Их монгол барилга" ХХК | Хөгжлийн банк | 6.4 | - | 6.4 | 38.0 |
| 4 | 29.3 км | 15.4 | "Пик девелопмент" ХХК | Хөгжлийн банк | 12.5 | - | 12.5 | 86.0 |
| 5 | 4.5 км | 1.5 | "Хөвсгөл зам" ХХК | Улсын төсөв | - | - | - | 100.0 |
| 6 | 88 км | \$ 33.5 | "Эйч Кэй Би" ХХК | Кувейтийн сан | - | - | - | 24.5 |
| Нийт | 257.8 км | 84.1 | | | 51.9 | 7.7 | 59.5 | |
| Улаангом- Наранбулаг- Хяргас нуур чиглэл | | | | | | | | |
| 1 | 15 км | 7.0 | "Шинжиан ШинФа" ХХК | Хөгжлийн банк | 6.7 | - | 6.7 | 100.0 |
| 2 | 85 км | 38.0 | "Шинжиан ШинФа" ХХК | Хөгжлийн банк | 28.5 | - | 28.5 | 100.0 |
| 3 | 90 км | 49.5 | "Шинжиан ШинФа" ХХК | Хөгжлийн банк | 13.4 | 20.2 | 33.6 | 71.2 |
| 4 | 190.0 км | 94.5 | | | 48.6 | 20.2 | 68.8 | |
| | Замын урт | Төсөвт | Гүйцэтгэгч | Санхүүжүүлэгч | ЧБ-оос санхүүжүүлсэн | ХБ-ны эх үүсвэрээс санхүүжүүлсэн | Нийт санхүүжилт | Ажлын гүйцэтгэл (%) |

Аймгийн төвүүдийг холбох орон нутгийн авто замын төсөл



тэрбум/тегер

| Тосонцэнгэл-Улиастай чиглэл | |
|-----------------------------|---|
| Урт | 67 км |
| Гүйцэтгэгч | Тэнгэр-Уул констракшн ХХК Шандун жунхун рөүд энд бридж ХХК-ийн түншлэл |
| Тогтоолоор батлагдсан дүн | 38,3 |
| Гэрээний дүн | 38,3 |
| Олгосон дүн | 17,3 |
| Эхлэх хугацаа | 2012.05.15 |
| Дуусах хугацаа | 2013.12.01 |



тэрбум/тегер

| Цахир-Тосонцэнгэл чиглэл | |
|---------------------------|------------------|
| Урт | 127.1 км |
| Гүйцэтгэгч | "Хурдны зам" ХХК |
| Тогтоолоор батлагдсан дүн | 62.9 |
| Гэрээний дүн | 28.0 |
| Олгосон дүн | 19.0 |
| Эхлэх хугацаа | 2012.06.04 |
| Дуусах хугацаа | 2014.10.01 |



тэрбум/тегер

| Алтай-Баянхонгор чиглэл | |
|---------------------------|-------------------|
| Урт | 128 км |
| Гүйцэтгэгч | Шинжиан ШинФа ХХК |
| Тогтоолоор батлагдсан дүн | 54.4 |
| Гэрээний дүн | 35.6 |
| Олгосон дүн | 32.9 |
| Эхлэх хугацаа | 2010.12.15 |
| Дуусах хугацаа | 2013.09.01 |



тэрбум/тегер

| Халзанбүргэдэй-Солонготын даваа | |
|---------------------------------|---------------|
| Урт | 100 км |
| Гүйцэтгэгч | "Моңроуд" ХХК |
| Тогтоолоор батлагдсан дүн | - |
| Гэрээний дүн | 46.3 |
| Олгосон дүн | 13.9 |
| Эхлэх хугацаа | 2013.09.24 |
| Дуусах хугацаа | 2014.10.30 |



тэрбум/тегер

| Манхан-Дарви чиглэл | |
|---------------------------|------------------|
| Урт | 100 км |
| Гүйцэтгэгч | "Алтайн зам" ХХК |
| Тогтоолоор батлагдсан дүн | 43,0 |
| Гэрээний дүн | 21,6 |
| Олгосон дүн | 19,36 |
| Эхлэх хугацаа | 2010.10.13 |
| Дуусах хугацаа | 2013.10.30 |

ЯДУУРАЛ

АЗИ АФРИКААС ӨӨР



Б.ТУЯА

Хятад, Япон, Өмнөд Солонгос тэргүүтэй хүчирхэг орнуудыг багтаасан Ази тив “баячууд” олонтой. Гэсэн ч Азийн зарим орны ядуурал өдрөөс өдөрт нэмэгдэж байна. Азийн эдийн засаг асар хурдтай хөгжиж 1960-аад оны эхээр тус тивийн амьжиргааны баталгаажих түвшин дээшилж тивийн иргэдийн нэлээд хувь нь хангалуун амьдрахын жаргал мэдэрч эхлэв. Гэсэн ч 1990 онд гаргасан статистикаар тивийн зүүн бүсийн нийт хүн амын 56 хувь, өмнөд Азийн 54 хувь нь өдөрт 1.25 ам.доллараас бага орлоготой гэсэн дүн гарчээ. Тэгэхээр азиудын тэн хагас нь амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур буюу ядуу байсан аж.

Харин 2010 оны судалгаагаар тивийн ядуурлын хэмжээ буурсан, зүүн хэсгийн хүн амын ердөө 12 хувь, өмнөдийнхний 31 хувь нь ядуу гэсэн үзүүлэлттэй байлаа. Гэтэл өдгөө ядуу иргэдийн тоо зүүн Азид 7.1 хувиар, өмнөдөд 5.2 хувиар тус тус өссөн дүнтэй гарчээ. Энэ нь дэлхийн аль ч тивд гараагүй муу үзүүлэлт гэнэ.

Азийн хөгжлийн банкны саяхны тайланд амьжиргааны баталгаажих доод түвшин болох 1.25 ам.долларын өдрийн орлого Ази тивийн ядуурлын түвшинг тогтооход учир дутагдалтай гэдгийг онцолжээ. Тус банкны ахлах эдийн засагч Гуангуа Вангийн хэлснээр тивийн амьжиргааны доод түвшинг шинэчлэн тогтоох нь бодит тоо гаргах үндэс болох аж. Тэгвэл үнэн бодит статистик гаргахад юуг хэрхэн чухалчлах шаардлагатайг тус банкны ерөнхий эдийн засагч Гуангуа Ван тайлбарласан байна.

Азийн хөгжлийн банкны судалгааны баг судалгааны шинэ өгөгдөхүүнд үндэслэн 2010 онд 28.8 хувьтай гарсан ядуурлын түвшин үнэн хэрэгтээ 49.5 хувьтай гарах байсныг тайлбарлажээ. Ингэснээр Ази тивийн ядуу иргэдийн тоо 0.73 тэрбумаар нэмэгдэн 1.75 тэрбум болж буйг тодорхойлжээ. Тэгэхээр 1.25 ам.доллар гэж тогтоосон орлогын доод түвшин Азийн ядуурлын түвшинг тогтооход алдаатай бас адармаатай аргачлал юм. ▶

► Ийнхүү Азийн хөгжлийн банкны ерөнхий эдийн засагч Вангийн Герман улсын “DW” (Deutsche Welle) мэдээллийн агентлагт өгсөн сонирхолтой ярилцлагыг орчуулан хүргэж байна.

DW: Судалгааны тулгуур үзүүлэлтүүд юу байв?

Wan: Юуны өмнө Ази-Номхон далайн орнуудын ядуурлын түвшин таамгаас тааруу байгааг хэлэх нь зүйтэй. Манай судалгааны аргачлалд ядуурлын түвшинг арай өргөн хүрээнд авч үзсэн. Уламжлалт хэмжүүр болох өдрийн орлогыг 1.25 ам.доллараар тооцсон нь Ази тивийн ядуурлыг бүрэн дүүрэн илтгэж чадахгүй байгааг харуулсан. Улмаар 2010 онд 21 хувиас хэтрэхгүй гэж үзэж байсан тооцооллыг бидний гаргасан шинэ аргачлалаар тооцон үзэхэд 50 хувь болтлоо өссөн үзүүлэлт гарсныг хэлэх хэрэгтэй. Түүнчлэн бидний гаргасан судалгаагаар 2030 он гэхэд Азийн нийт хүн амын 17 гаруй хувь нь нэн ядуу гэсэн ангилалд багтана гэж таамаглаж байна. Үүнийг уламжлалт хэмжүүрээр авч үзвэл 1.4 хувьтай байна гэж гарах юм л даа.

Бид судалгаандаа нэн чухал хэдий ч үл ойшоогдсоор ирсэн ядуу болон нэн ядуу хүмүүсийн өртөмтгий байдлын эрсдэлийг оруулж ирсэн.

DW: Өнөөгийн ядуурлын түвшинг тодорхойлох хэмжүүр яагаад учир дутагдалтай байна вэ?

Wan: Өдрийн орлого 1.25 ам.доллараас доошгүй байна гэдэг үндсэн үзүүлэлт нь Азийн орнуудын ядуурлын түвшинг бүрэн дүүрэн илэрхийлж чадахгүй байна. Үүнд хоёр шалтгаан бий. Нэгдүгээрт, дээрх хэмжүүрийг гаргахдаа үндэсний ядуурлын түвшин өндөртэй дэлхийн 15 орны үзүүлэлтээр тооцсон. Үүний 13 нь Африкийн орон бол ердөө хоёр нь Азийн орон байгаа юм. Тэдгээр нь Тажикистан, Непал.

Амьжиргааны баталгаажих түвшний доод хэмжээ болох 1.25 ам.доллар Африкийн орнуудад хүний анхдагч хэрэгцээг хангахуйц байж болох ч Азид бол өөр хэрэг. Учир нь зарим өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний ханш Азид илүү үнэтэй болох нь харагдсан.

Хоёрдугаарт, анхдагч хэрэгцээ нь орон

бүрт харилцан адилгүй. Түүнчлэн доод хэмжээг тогтооходоо 1988-2005 оны үзүүлэлтүүдийг харгалзан үзсэн нь өдгөө хоцрогдсон. Ази тив асар хурдтай хөгжиж байна. Тэгэхээр шинэчилсэн мэдээлэл хэрэгтэй. Өнөөдөр ашиглагдаж буй үндсэн зарчимд үндэслэн, гэхдээ арай өргөн хүрээг хамрах өгөгдөл ашиглан амьжиргааны доод түвшинг тодорхойлоход нэг хүн өдөрт 1.51 ам.долларын орлоготой байх шаардлагатай болж байна. Ийн тооцоход 2010 онд 9.8 хувийн өсөлттэй гарсан тус бүсийн ядуусын тоо 343 хүнээр нэмэгдэж буй.

DW: Амьжиргааны баталгаажих доод түвшинг тодорхойлодог тооцооллыг засаж өөрчлөх нь юунд тустай вэ?

Wan: Ядуурлыг мөнгөн дүнгээр тодорхойлох нь асуудлын гол биш. Харин ядуу иргэдийн эрүүл мэнд, нийгэм хамгааллын хүртээмж, хамрах хүрээг тодорхойлох нь жишиг хэмжүүр тогтоох гол зорилго. Орлого, зарлагын мөнгөн дүн уруудаад байхад ядуурлын жишиг болдог мөнгөн дүнг нэг түвшинд барих утгагүй. Иймд ядуурлын зураглалыг гаргахдаа учир шалтгааныг өргөн хүрээнд авч үзэх, тэдгээрийг ойлгох, шийдвэрлэх арга замыг олох, дэмжих, улмаар зөв бодлого тодорхойлох бас хэрэгжүүлэхэд шинэ аргачлал дөхөм болно гэж үзэж байна.

DW: Нэн ядуу гэх ойлголтыг шинэчлэн тодорхойлоход ямар хүчин зүйлс чухал вэ?

Wan: Ядуурлын түвшинг тодорхойлоходоо гурван зүйлийг багтаах шаардлагатай. Нэгдүгээрт, Азийн орнуудын хэрэглээний өртөг. “Нэн ядуу” гэдэг ойлголт үргэлж хувьсан өөрчлөгдөж байдаг. Иймээс тодорхойлох явцад шинэ мэдээлэл, мэдээллийн сан шаардлагатай болдог. Тэр тусмаа асар хурдан хөгжиж буй Азийн орнуудад. Хоёрдугаарт, нэн ядуу иргэдийн өртөмтгий байдал. Бага орлоготой иргэд “Нэн ядуу” ангилалд шилжих тун амархан. Байгалийн гамшиг, санхүүгийн хямрал, өвчин эмгэг зэрэг сөрөг үйл явдлууд тэдэнд шууд нөлөөлдөг. Иймд тэднийг ядуугийн зовлонд удаан тарчлаахгүйн тулд бодлого, хөтөлбөрүүд шаардлагатай.

Урьдчилан сэргийлэх ганц үйлдэл өвдөхгүй байх зөв алхам гэдэг шүү дээ. Тиймээс ядуурлын тухай ярьж байгаа

бол хүнсний аюулгүй байдлын асуудлыг заавал хөндөх хэрэгтэй. Өдөр хоногийг өлсгөлөн өнгөрөөж буй хүнтэй орлогын жишиг яриад хэрэггүй.

DW: Таны дурдаж буй тулгамдсан асуудлуудыг өнөөгийн жишиг хэмжүүр болох 1.25 ам.долларын жишигт оруулан тооцвол Ази тивд хэчнээн хүн ядуу гэсэн эгнээнд багтах бол.

Wan: Уламжлалт аргаар тооцоолбол Ази тивд 733 сая хүн нэн ядуугийн тоонд орж байна. Харин манай судалгааны багийн гаргасан аргачлалаар тооцоод үзвэл 2010 онд 28.8 хувьтай гарсан ядуусын тоо 49.5 болж өснө. Өөрөөр хэлбэр, дөнгөн данган өдөрт 1.25 ам.доллар олдог хүмүүс 1.02 тэрбум байсан бол шинэ тооцооллоор 1.75 тэрбум болох юм.

DW: Азийн эдийн засгийн хурдацтай хөгжил энэ тоог бууруулж чадах болов уу?

Wan: Мэдээж. Азийн хөгжил дэлхийд тэргүүлж байна. Ингэснээр сая сая хүмүүс ядуугийн зовлонгоос ангижирч буй. Эдийн засгийн өсөлт, хөгжлийг тогтвортой байлгах нь ядууралтай тэмцэх чухал арга. Тус тивийн эдийн засаг дахь эерэг өөрчлөлтүүд үргэлжилбэл ядуурлын түвшин 2020 онд 31.7 хувь, 2030 он гэхэд 17.1 хувь хүртэл буурах боломжтой.

DW: Ядуурлыг эрчимжүүлж буй хүчин зүйлстэй тэмцэхийн тулд төр болон иргэний нийгмийн байгууллагууд юу хийх хэрэгтэй вэ?

Wan: Эдийн засгийн өсөлтийг дэмжих хэрэгтэй. Үүнээс гадна ядуурлыг бууруулах бодлого, стратеги болон хөтөлбөр хэрэгжүүлэхдээ ядуусын хэт өртөмтгий байдал, хүнсний асуудлыг цогцоор хөндөх нь чухал.

Үйлдвэрлэлийн дэвшил, технологийн шинэчлэл хүнсний аюулгүй байдал болон хүртээмжийг сайжруулдаг. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд тухайн орны Засгийн газар эрсдэлтэй гэгдэж буй орон нутагт мөн гамшигийг бууруулах зорилгоор аюулаас урьдчилан сэргийлэх систем болон хоол, тэжээлийг төрөлжүүлэх ажилд хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй. Түүнчлэн ургацын даатгал зэрэг бүс нутгийн газар зүй, байгалийн тогтоцоос хамаарсан зах зээлд түшиглэсэн бодлогыг дэмжих нь зүйтэй. ■



Завхан аймгийн 999 морин хуурч Чингисийн талбайд. 2011 оны долдугаар сарын 5.



Гэрэл зургийг Б.Бямба-Очир

10.000 морьтон жагсаж Генрист бүртгүүлсэн түүх шинэхэн. 2013.08.09.



Монголын хүүхдийн авъяас чадварыг хүлээн зөвшөөрүүлж, геннист бүртгүүлэх 9999 шатарчны тоглолтыг Дэлхийн шатрын холбооны ерөнхийлөгч Илюмжинов сонирхон өндрөөр үнэлэв

МОНГОЛ БАХАРХАЛ

9999 ШАТАРЧИН ГЕННИСТ

Завхан аймагт энэ сарын 20-нд 9999 шатарчин нэгэн зэрэг өрөг нүүсэн үйл явдал боллоо. Тус үйл ажиллагааг УИХ-ын гишүүн, Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав санаачлан зохион байгуулжээ. Нээлтийн арга хэмжээнд Олон улсын шатрын холбооны ерөнхийлөгч Кирсан Илюмжинов урилгаар ирж оролцсон байна.

Оюуны спортыг түгээн дэлгэрүүлэх зорилготой тус тэмцээнд Завхан аймгийн 24 сумаас шалгарсан шатарчид Улиастай хотод нэгдэж шилдгээ тодруулсан байна. Шигшээ тэмцээнд шалгарсан 100 гаруй хүүхдийг гадаадад аялах эрхийн бичиг, алт, мөнгө, хүрэл медалиар шагнажээ.

Нээлтийн үеэр УИХ-ын гишүүн, Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав “Очирваань хайрханаараа овоглосон Завхан нутагт шилдэг шатарчин хүүхдүүдийн тоглолт амжилттай боллоо. Миний санаачилсан гурван тулгуурт бодлого хэрэгжээд зургаан жил болжээ. Энэ хүрээнд 666 хүүхдийг компьютертэй болгосон. 999 морин хуурч Отгонтэнгэр хайрханы бэлд хуурдсан, мөн Улаанбаатар хотын Чингисийн талбайд 999 морин хуурч тоглосон түүхэн үйл явдал болсон. Харин одоо гурав дахь тулгуур бодлогынхоо тайланг тавьж байна. Энэ удаад анх удаа 9999 шатарчин нэгэн зэрэг тоглолт

хийлээ. Энэ түүхэн гавъяаг бид хамтдаа хийж чадлаа” гэлээ.

Олон улсын шатрын холбооны ерөнхийлөгч Кирсан Илюмжинов “Дэлхийн шатрын холбоонд 181 орон гишүүнээр элссэн. Миний хувьд жил бүр олон орноор явж ажилладаг ч Монголд болж байгаа шиг ийм гайхалтай арга хэмжээг үзэж байсангүй. Завхан аймагт 10 мянга гаруй шатарчид нэгэн зэрэг тоглосон нь аймгаа зөвхөн Монголынхоо хэмжээнд биш, олон улсад сурталчилж байгаа хэрэг юм” гэдгийг онцолсон.

Хүүхэд багачуудын оюун ухаан, сэтгэн бодох чадварыг сайжруулах, шатрын спортыг хөгжүүлэх, дэлхийд монгол хүүхдүүдийн авъяас, чадварыг хүлээн зөвшөөрүүлж, анх удаа 9999 шатарчин нэгэн зэрэг тоглосон үйл явдлыг Геннисийн амжилтад бүртгүүлэх зорилготой аж. Тэгвэл Олон улсын шатрын холбооны ерөнхийлөгч Кирсан Илюмжинов Завхан аймгийн Их-Уул суманд очих үеэрээ энэхүү үйл явдлыг дэлхий нийт үнэлж, Геннисийн амжилтад бүртгэнэ гэдгийг дуулгасан байна.

Энэ дашрамд дурдахад өнгөрсөн оны долдугаар сард Монголчууд Улаанбаатар хотын СХД-ийн нутаг дэвсгэр болох хүй долоон худагт 10.000 морьтон жагсаж, морьтон монголчууд Геннист бүртгүүлсэн түүх шинэхэн байна. ■

ХҮНИЙ ХӨГЖИЛ

ОНЫ ЗАЛУУС ЛЕКЦ
УНШЛАА

Монголын залуучуудын холбоо, Залуу удирдагч сан хамтран оны залуусыг шалгаруулдаг уламжлалтай. 2013 оны “Next Stop” наадмын эдийн засаг, бизнесийн салбарын оны залуугаар “Вульф петролеум” компанийн ТУЗ-ийн дарга Т.Лхагвадорж, нийгэм,улс төрийн салбарын оны залуугаар АН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Оюундарь нар шалгарсан билээ. Тус наадмаас тодорсон шилдгүүд дараа оны намарт оюутан залууст зориулсан лекц уншдаг уламжлал тогтжээ. Улс орныхоо хөгжлийн төлөө хөдөлмөр, сэтгэлээрээ зүтгэж, хувь нэмрээ оруулж яваа салбарын салбарынхаа олон шилдэгтэй өрсөлдөн гарч ирсэн хоёр залуу Төрийн ордны Их танхимд төрийн болон төрийн бус байгууллагын залуу мэргэжилтнүүд болон 1000 гаруй оюутанд өөрсдийн лекцээ уншсан юм.

Ц.Оюундарийн “Толгойг олборлох тойм зураглал” сэдэвт илтгэлийн гол санаа нь газрын хэвлийдээ их хэмжээний баялагтай толгойнуудыг олборлож, улсыг хөгжүүлэхээс гадна монгол хүний тархийг ашиглаж, ялангуяа урлаг, соёлын салбарын хүмүүсийн толгойг олборлож, тэдний оюун санааны мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, өөрөөр хэлбэл, бүтээлч салбарыг кластерийн аргаар дэмжин хөгжүүлбэл уул уурхайгаас дутуугүй ажлын байр бий болж, байгальд ээлтэй хөгжлийг бүтээж болох тухайд лекцээ толилууллаа. Урлагийг эдийн засагжуулах түүний илтгэл манай улсад өнөөдөр тулгар ч буй шинэ сэдэв. Бүтээлч салбарыг хууль эрх зүйн орчин, боловсон хүчин, сэтгэлгээ талаас төрөөс тодорхой бодлогоор дэмжин



“Next Stop” наадмын 2013 оны шилдэг залуу “Вульф петролеум” компанийн ТУЗ-ийн дарга Т.Лхагвадорж, АН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Оюундарь нар. 2014.09.27. Төрийн ордон

хэрэгжүүлэхийн чухлыг хэлээд энэхүү үйлсэд эрх барьж буй намын Ерөнхий нарийн бичгийн даргын хувьд хүчин зүтгэхээ тэмдэглэсэн.

Харин Т.Лхагвадорж “Уул уурхай-Хөрөнгө оруулалт-Хөрөнгийн зах зээл” сэдвээр илтгэл тавьсан. Монгол орон яагаад уул уурхайг хөгжүүлэх ёстой, уул уурхайгаас гаргаж авдаг олон бүтээгдэхүүн бидний өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэглэгддэг, энэ салбарт яагаад олон тоогоор илэрхийлэх хөрөнгө оруулалтууд хэрэгтэй байдаг, салбарын эрсдэл, боломжийн тухай ч ярьсан. Мөн уул уурхайн хөрөнгө оруулалтын хүндрэл, ирээдүй болон дэлхийн хөрөнгийн зах зээлүүд дээр уул уурхайн бүтээгдэхүүнд түшиглэсэн хөрөнгө оруулалтыг хэрхэн босгодог талаар энгийн бөгөөд тодорхой ойлголт өгсөн юм. Түүний илтгэлийг уншигчдадаа бүрэн эхээр нь толилуулж байна.

Төмөрийн Лхагвадорж. Улаанбаатар хотын 31-р дунд сургуулийг 1987 онд төгссөн. Украйны Аж үйлдвэрийн их сургуулийг ашигт малтмалын баяжуулалтын техникч, АНУ-ын Колорадагийн Уул уурхайн дээд сургуулийг металлургич мэргэжлээр бакалавр, магистрийн зэрэгтэй төгссөн. Тэрбээр “Эрдэнэт” уулын баяжуулах үйлдвэрт баяжуулагч, ерөнхий диспетчер, “Монголросцветмет” нэгдлийн Ерөнхий захирлын Хөгжил хэтийн төлөв хариуцсан орлогч, “Юнигаз” компанийн ерөнхий захирал, “Энержи ресурс” компанийн гүйцэтгэх захирал, “Хүннү коал” компанийн ерөнхий захирлаар тус тус ажиллаж байсан. Одоо Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Вояжер ресурс” компанийн ТУЗ-ийн гишүүн, “Вульф петролеум” компанийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна. ■

ИЛТГЭЛ

УУЛ УУРХАЙ-ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ -ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

“Вульф петролеум” компанийн ТУЗ-ийн дарга Т.Лхагвадорж

Та бүхний өмнө лекц унших боломж олгосон Монголын Залуучуудын Холбоо, Залуу Удирдагч Сангийн хамт олонд талархал илэрхийлье. 2013 оны эдийн засаг, бизнесийн салбарын шилдэг залуугаар шалгарахдаа миний бие өөрөөсөө илүү, хамт нэр дэвшиж амжилт бүтээлээрээ шалгарсан залуучуудаар ихэд бахархсан. Миний хувьд эзэмшсэн боловсрол мэдлэгээ уул уурхайн салбарт зориулж тодорхой амжилт олсныг минь үнэлж байгаад баярлавч, илүү ихийг хийж бүтээх хариуцлага байгааг ухаарч байна.

Залуучуудын орон болсон Монгол улсад маань хөгжил хурдтай явагдаж байна. Хөгжлийн гол түлхүүрүүдийн нэг уул уурхай, хөрөнгө оруулалт, хөрөнгө босгох гол хөшүүргүүдийн нэг олон улсын хөрөнгийн зах зээлийн тухай танилцуулахыг зорилоо.

Уул уурхайн салбар

Сүүлийн хэдэн жилд манай уул уурхайн салбар бүх нийтийн анхаарлын төвд байж ирлээ. Улс орны эдийн засгийн томоохон ачааг үүрч явдаг салбар учир арга ч үгүй. Уул уурхайг хөгжүүлэх, ашигт малтмал олборлох хэрэггүй гэж зарим нь мэтгэдэг. Гэтэл хүний амьдралд хамгийн чухал хэрэгцээтэй материалуудыг зөвхөн уул уурхайн баялгыг олборлож, баяжуулж, боловсруулж байж бүтээн байгуулалтуудыг бий болгодогийг тэр бүр хүн анзаардаггүй. Хүний хэрэглээнд ордог гар утаснаас авахуулаад шинэ технологийн нарийн бүтээгдэхүүнд газрын хөрсөнд буй металл, бодисууд маш өргөн хэрэглэгддэг. Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэхэд ч ашигт малтмалууд хэрэг болно.

Уул уурхай шинжлэх ухааны нэг салбар. Анагаах ухаан хүний гэдэс дотрыг судалж, эрүүлжүүлдэг, шаардлагатай бол


хагалж, салгаж авч, сольж сайжруулж, эмчилж эдгэрүүлдэг. Түүний адил уул уурхайн салбар газрын хэвлийг судалж, илрүүлж, хэрэгтэй зүйлийг нь авч, цааш нь боловсруулдаг, хэрэггүй зүйлийг нь ялгаад, дараа нь нөхөн сэргээж унаган төрхөнд нь оруулах тухай шинжлэх ухаан билээ. Монгол орон минь байгалийн баялгаар баян ч, аль нэг ашигт малтмалын нөөцийг тоо хэмжээгээр илэрхийлэхэд багцаасан бүдэг бадаг таамаг голдуу байдаг. Баялгийг хайж олоход цаг хугацаа их ордог, эрсдэл өндөртэй хайгуулын ажил гэдгийг тэр бүр ухаарч хандаггүй нь бидний алдаа.

Зарим нэгний хувьд хурдан морьны хийморь ивээгээд ч гэх юмуу, үздэг хардаг хүнээр зүг чигээ тогтоолгодог, эсвэл мөнгөөр зодож өрөмдөж байгаад орд газар нээж илрүүлнэ гэх тохиолдол байдаг. Магадгүй аз таарч тийм амжилтад хүрч болох ч геологи хайгуулын ажил өөрийн гэсэн шинжлэх ухааны үндэслэлтэй дэс дараалалтай, зохион байгуулалттай явагдаж байж, мянгад нэг нь амжилттай орд газар болж тогтоох магадлалтай.

Геологичид сансраас зураг авахаас эхлээд газраар хэдэн зуун километр алхаж, газрын гадаргаас сонирхолтой чулуунуудыг нь шуудайлж үүрэн явсаар орд газар байж болох талаар таамаг дэвшүүлдэг. Түүнийг нь геофизикийн нарийвчилсан судалгаа хийж нягталснаар хамгийн үнэтэй ажил цооног өрөмдөх шатандаа орно. Мэдээллээ жаахан л буруу орчуулж ойлгосон бол хэдэн метрийн хажуугаар өнгөрөөд өрөмдчих том эрсдэлтэй. Зарим орд газрыг 4-5 компани дамжин хайгуул хийж амжилтад хүргэх нь бий. Оюу Толгойн ордыг 163 дахь өрөмдлөгөөр нээж илрүүлсэн бол 10 жил тасралтгүй өрөмдлөгийн ажил хийж байж дэлхийн хэмжээний нөөцтэй орд газар болохыг тогтоосон. Дэлхийн хэмжээний орд газруудын нэг Эрдэнэтийн зэс молибдений уурхай 35 жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Цаашид 20-30 жил ашиглах нөөц бий гэж тооцоолдог. Ил уурхай 300-гаас доош метрийн гүн рүү ороод ирвэл, нэмэлт хөрөнгө оруулалтаар далд аргаар ашиглахаас өөр аргагүй болно. Гэтэл арай хийж илрүүлсэн орд газрууд дэд бүтцээс хол, ус цахилгаан ▶▶

ХҮН БҮР ТӨРСӨН ЦАГААСАА ХОЙШ ДУНДЖААР 1 САЯ 360 МЯНГАН КГ БАЙГАЛИЙН БАЯЛАГ ХЭРЭГЛЭДЭГ

Алт - 55 гр
Зэс - 440 кг
Давс - 12447 кг
Фосфорит - 7866 кг
Нүүрс - 208554 кг
Хөнгөн цагаан 2589 кг
Төмрийн хүдэр 11202 кг
Цайр - 236 кг
Цемент 11202 кг
Байгалийн хий 192 сая
Газрын тос 11202 литр
Хар тугалга 403 кг
Шавар - 5501 кг
Элс чулуу - 535 тонн
Бусад - 24646 кг



► хүрэлцээгүй, эсвэл метал ялгаж авах технологи нь хүндрэлтэй, үнэтэй, зах зээлийн үнэ нь дэндүү доогуур зэргээс болоод эдийн засгийн хувьд ашиглах боломжгүй байх нь олонтаа. Тухайлбал, Асгатын мөнгөний орд Монгол-Оросын хилийн зааг дээр оршдог, дэд бүтцээс хол, өндөр ууланд мөнх цэвдэгтэй газар оршиж, мөнгө агуулсан чулуунд нь хэрэгтэй хэрэггүй олон бодис байдаг. Хамгийн гол хүндрэл нь манайд ялгах технологи байхгүйгээс одоо хүртэл ам дамжин яригдахаас цаашгүй төсөл боллоо.

Орд газар болгон уурхай болох нь эргэлзээтэй. Зэсээр жишээ авъя. Зэс агуулсан ашигт малтмал газрын гүнд үүсэхээсээ хэр гүнд оршиж нар салхи, халуун хүйтэн, ус чийг, химийн урвалд өртсөнөөс шалтгаалж янз бүрийн хэлбэрийн минерал болоод байрладаг. Ногоон, цэнхэр өнгөтэй үнэт чулуу эсвэл харлаж шарласан хүнд анзаарагдахааргүй хад асга шиг байж мэднэ. Газрын хөрсөнд ойр оршдог минерал нь голдуу ус агаартай урвалд орсон байдаг тул хүхэрийн хүчилд уусгаж, дараа нь цахилгаан электролизийн аргаар цэвэрлэж авч болдог. Гэтэл гүн рүүгээ хүхэр, төмөр, уур янз бүрийн ховор хүнд металлууд урвалд ороод ялгахад хэцүү холилдсон байна. Ийм олон янзын бодис яаж холилдсоноос нь шалтгаалж, эдийн засгийн үр ашигтай уурхай, үйлдвэр байгуулж босох эсэхийг техник, эдийн засгийн үндэслэлээр боловсруулж тодорхойлдог. Зэс идэх дуртай бактери ашиглаж ялгаж авдаг талаар та бүхэн сонсон уу? Ялгахад хэцүү зарим тохиолдолд бактери үржүүлж, зэс агуулсан шороотой холиод, дараа нь ялгаад авдаг арга дэлхийн зарим орд газарт ашигладаг. Бактери нь дулаан оронд амьдрах чадвартай учир манай эрс тэс уур амьсгалтай улсад хэрэгжих боломжгүй.

Яагаад Эрдэнэт үйлдвэрийг байгуулах хэрэгтэй болов? Яагаад Оюу Толгой нь том хөрөнгө шаардсан төсөл болов оо. Энгийнээр тайлбарлъя.

Эрдэнэтийн зэс молибдений орд гэдэг маань газарт байхдаа 100 кг шороонд нэг хүрэхгүй кг, одоогийн байдлаар 500 гр зэс агуулагддаг. Оюу Толгойн зэс ч ялгаагүй. Баяжуулах гэдэг нь шороогоо буталж нунтаглаад, химийн бодис хольж ялгаж байж 100 кг тодорх зэсийн хэмжээ нь 25-30 кг болохыг хэлнэ. Баяжсан нунтагаа өндөр температур, даралттай зууханд халааснаар бидний мэдэх зэс металл


бий болж хэрэглээнд орно. Гурил шиг нунтаглахад зэс, төмөр, молибден гэх мэт металлууд ширхэгээрээ салах хэмжээнд хүрдэг. Зэс, молибден нь усанд нордоггүй учир тэр чанарыг нь ашиглаж, хөөсөрсөн усанд химийн бодис нэмж гадарга дээр хөвүүлэн гаргаж ирнэ. Яг үйлдвэр дотор баяжуулдаг машины дэргэд зогсоод процессыг ажиглахад их сонирхолтой. Туршлагатай баяжуулагчид хөөсний өнгийг хараад л хэр их зэс агуулж байгаа, өөр зүйлс холилдсон эсэхийг тодорхойлж чадна.

Тэгэхээр эрдэнэт үйлдвэр жилд 25 сая тонн чулуу шороог буталж нунтаглаж байж ойролцоогоор 150 мянган тонн зэс ялгаж авна. Тэр их шороог боловсруулахад асар өндөр хүчин чадалтай техник төхөөрөмжүүд тасралтгүй ажиллах хэрэгтэй. Тус үйлдвэрийн хувьд баялгууд газрын гадаргатай ойрхон учраас экскаватор эл уурхайн аргаад ухаад авч болж байна. Харин Оюу Толгойн зэс хэдэн зуун метрийн гүнд байгаа учраас далд аргаар олборлох шаардлагатай. Өргөн цооног нүхэлж, тэрийгээ хүн орж гаргахад аюулгүй болгон бэхлэн агааржуулалтын систем суурилуулна. Дараа нь том том техник гүнд нь оруулж байж илүү өндөр зардлаар ашигт малтмалаа ухаж гаргах хэрэгтэй болж байна.

Яагаад их хэмжээний эрчим хүч шаардагддаг байна вэ? Төсөөлөөд үз дээ. Намайг Эрдэнэт-д ажиллаж байхад цахилгааны хангамж хүнд байсан 1990-ээд оны үед эрдэнэт хотыг тэр чигт нь тоггүй болгох уу, эсвэл чулуу нунтагладаг найман том тээрмийн нэгийг зогсоогоод хотыг тогтой байлгах уу гэсэн сонголтууд үүсдэг байсныг санаж

байна. Сэлэнгэ мөрний усыг 70 км-ийн зайнаас нэг метр голтой хоолойгоор татаж үйлдвэрт ашиглана. Ийм их эрчим хүч, ус, техник төхөөрөмж шаардагддаг учир хөрөнгө оруулалт нь тэрбум тэрбумаар хэмжигддэг. Маш их үнэтэй тоног төхөөрөмж, экскаватор, ачигч машиныг эвдрэлгүй ажилуулж сурах нь ажилчин хүнээс том хариуцлага, ур чадвар шаардах нь гарцаагүй. Уул уурхайн компаниудын хувьд хүний амь нас, эрүүл мэнд хамгаас чухал. Тиймээс “аюулгүй ажиллагаа” гэдэг үг нь уурхай, үйлдвэрт амны уншлага болно. Барууны зарим орны уурхай хүний эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг дээд зэрэгт тавьдгаараа дэлхийн бусад орноос хэдэн арван жилээр тэргүүлсэн байдаг. Намайг 10 гаруй жилийн өмнө оюутан байхад хамт сурдаг түрк оюутан маань Швед улсын Kiruna төмрийн далд уурхайд очиж дадлага хийгээд ирэхдээ тэр уурхайн хөгжил бидний мэддэгээс даруй 50 жилээр түрүүлж явна гэж билээ. Яагаад гэвэл тэр далд уурхай доторх бүх техник нь алсын удирдлагаар ажиллаж, уурхайчин нь ерөөндөө компьютер тоглоом тоглож буй аятай удирдлага бариад сууж байдаг, уурхайн гүнд дэх засмал замаар техник машинизм нь нааш цааш явж, ажилтнууд нь камераар бүх ажлаа хянаад ажилладаг тухай бид сонсоод гайхан биширч байсан сан. Хэрэв дэлхийн уул уурхайн хөгжилтэй хөл нийлүүлэн алхаж чадвал ирээдүйд уул уурхайн талаарх бидний ойлголт үндсэндээ өөрчлөгдөнө.

Уул уурхайг ашиглаж дуусаад зөнд нь хаядаг гэж ойлгож болохгүй. Дэлхий нийтийн туршлагаар нөхөн сэргээлт хийж, унаган төрхөнд нь оруулж чадахгүй бол музей, аялал жуулчлалын чиглэлээр ►►



▶ хөгжүүлдэг. Манай улсад одоогоор нөхөн сэргээлт хийх түвшинд хүрсэн, төгсгөлийн шатандаа орж яваа уурхай байхгүй. Гэхдээ олон улсын стандартад нийцсэн уурхайн үйл ажиллагааг заавал нөхөн сэргээлтээр дуусгадаг учир ажлаа дөнгөж эхэлж буй уурхай руу газрын хөрсийг сүйтгэлээ, эрдэнэсийг нь аваад хөсөр хаялаа гэж болгоомжлох нь нэг талаар мэдлэг дутсаных юм. Цаашид уул уурхайн компаниуд үйл ажиллагаагаа олон нийтэд зөв сурталчилж, таниулах нь зүйтэй. Манай “Хүннү Коал”-д хөрөнгө оруулсан Тайландын “Банпу” компани нутагтаа ашиглаж дууссан нүүрсний уурхай дээр гольфын сайхан талбай байгуулсныг үзсэн. АНУ-ын нэртэй том “Reabody” компани Булган аймгийн Эрээний нүүрсний уурхайн нөхөн сэргээлтийг бараг унаган төрхөнд нь оруултал нь сэргээжээ. Англид 150 жил ажилласан “Eden” уурхайн талбай дээр маш сонирхолтой аялал жуулчлалын цогцолбор байгуулсан нь бий.

Уул уурхайн салбарыг төр засаг бодлогоороо зохицуулж, компаниуд нь хариуцлагатай, зөв засаглалтайгаар үйл ажиллагаагаа явуулж, харин ард иргэд хянаж, эдийн засгийн үр шимийг нь ойлгож ухамсартай хандвал жинхэнэ хөгжил болно. Харин муйхраар уул уурхай хэрэггүй хэмээн хааж боодог хүмүүст хариуцлагатай уул уурхайн талаар өргөн ойлголт өгөх нь чухал байна. Зөвхөн байгаль сүйтгэдэг гэдэг өнцгөөс харж, уул уурхайн салбарыг бараантуулах нь хөрөнгө оруулалт хийх шийдвэрт сөргөөр нөлөөлөх болдгийг энд онцлон тэмдэглэе.

Хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалт гэх мөнгө, ашиг ханхалсан том ойлголтын цаана энгийнээр бодвол аливаа хүн хөрөнгөө жаахан ч болтугай арвижуулахын тулд банкинд хүүтэй хадгалах уу, эсвэл хөрөнгө нь үржиж ирээдүйд ашиг авчирч болох бизнест итгэж мөнгөө зарцуулах уу гэдэг сонголтоос үүсэх шийдвэр явж байдаг. Хөрөнгө оруулалтын мэргэжлийн байгууллага, банкирууд дэлхийн томоохон хөрөнгөтэй хүмүүсийн итгэж өгсөн хөрөнгийг нарийн тооцоо хийсний үндсэн дээр тодорхой төслүүдэд хувааж хөрөнгө оруулаад, удаан хугацааны туршид ашиг олох замаар хөрөнгийг өсгөдөг. Уул уурхайн том төслүүдийн хөрөнгө оруулалтыг тэрбумаар нь босгодог хүндтэй олон банк дэлхийд бий. Тэдний ердийн арилжааны банкуудаас ялгагдах

гол зүйл нь хувьцаа зарж хөрөнгө босгохоор төлөвлөсөн байгууллагуудад хувьцааг нь бусдад сурталчилж, үнэлж зарж өгөөд хувь хүртэх, нөгөө талаар хувьцаа худалдан авах байгууллагуудад судалгааг нь хийж, бодит үнэ тодорхойлж, наймаалцсан үйлчилгээ үзүүлээд татвар авах үндсэн зарчимтай. Энэ үйл ажиллагааг брокерууд буюу зуучлал гэж нэрлэдэг.

АНУ, Канад зэрэг оронд хэдийгээр татвар өндөр, хууль дүрэм нь чанга боловч дэлхийн бусад орнуудаас илүү ихээр хөрөнгө оруулалт хийдгийн учир нь эдгээр улсад үйлчилдэг хууль зүйн, татварын орчин нь хэр барагтай өөрчлөгдөхгүй, 50- 100 жилээр тогтвортой байдагт байгаа юм. Урт хугацааны орчинд тохируулж тооцоогоо хийнэ гэсэн үг. Ер нь уул уурхайн томоохон компаниуд анхан шатны хайгуулын ажилд оролцох нь нэн ховор. Тиймээс JUNIOR гэж нэрлэгддэг дунд хэмжээний хайгуулын компаниуд төслийн хэмжээнээс хамааран 5-20 сая долларын хөрөнгө оруулалт хийж, өндөр эрсдэлтэй хайгуулын ажилд оролцдог. Тэдний илрүүлсэн орд газрын хэмжээ, потенциал нь тухайн уул уурхайн компанийн бодлоготой нийцэж байвал хувьцааг нь хэсэгчилэн юмуу бүхэлд нь үнэ хайрлахгүй худалдан авч, илүү өргөн далайцтайгаар хөрөнгө оруулж ажилладаг. Оюу Толгойн хайгуулын жишээг дурдаж болж байна.

Маш их хэмжээний зардлаар ордыг илрүүлдэг, илрэхгүй ч тохиолдол олонтаа. Эрсдэл өндөртэй учраас хөрөнгө татахад хүндрэлтэй бизнес. Жишээ нь Канадад 3000 төслөөс зөвхөн нэг нь л эдийн засгийн үр ашигтай уурхай болж хөгжих магадлалтай гэж үздэг. Хайгуулын компаниуд азтай байхыг хүснэ, хөрөнгө оруулагчид азтай төслийг сонгож оролцохыг хичээнэ. Австралын хөрөнгө оруулагчдыг уул уурхай, хайгуулын эрсдэл, ашгийг бусдаас илүү ойлгодог гэж би боддог. Баруун Австрали нь байгалийн баялаг ихтэй, газар нутгийн хэмжээ нь Монголыхтой ойролцоо, хүн ам нь ч гурван сая орчим. Уул уурхайн баялгаа зүй зохистой олборлож, экспортолж ихэнхдээ далайгаар Хятад руу тээвэрлэж, олсон ашгаараа нийслэлээс холд орших хотуудаа хөгжүүлжээ.

Хөрөнгө оруулалт татахын тулд боловсруулдаг эдийн засгийн тооцоог хэр нарийвчлалтай хийж чадна, тэр хэмжээгээр итгэл үнэмшил төрүүлж хөрөнгө оруулах шийдвэрт хүргэх

боломжтой. Bankable Feasibility study буюу банкны шалгуур давах ашгийн тооцоо судалгаа бол маш өргөн хүрээтэйгээр аливаа төслийн техник, эдийн засаг, байгаль орчин, нийгэм гэх мэт нөлөөлөх хүчин зүйлсийг бодитойгоор тооцоолж боловсруулахад олон сая доллар зарцуулах хэрэгтэй болдог. Харин тооцоо нь аль ч том банкны сорилт шалгуурыг давах хэмжээнд хийсэн байдаг учир хэрэв тэр тооцоо эдийн засгийн үр өгөөжтэй гэсэн дүгнэлттэй бол хөрөнгө босгоход саадгүй. Үнэндээ хөрөнгө оруулалтын банк их хэмжээгээр мөнгө хадгалдаг газар биш л дээ. Жишээ нь Таван толгойн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хэдэн тэрбум долларын төслийн тооцоо хангалттай түвшинд хийсэн нь банкны судалгаагаар батлагдлаа гэж үзье. Тэгвэл банк цааш нөгөө жинхэнэ хур баячууд эсвэл том том хуримтлалын сангууд руу ханддаг. Сингапур улсын төрийн мэдлийн хуримтлалын сан Temasek эсвэл Канадын тэтгэврийн сан гэх мэт ард түмнийхээ хуримтлалыг улам баяжуулахаар зориулагдсан байгууллагууд удаан хугацаанд үр ашгаа байнга өгөх уул уурхайн төслүүд рүү орохоос буцаагүй.

Хөрөнгө оруулалтын олон сайхан жишээ дурьдаж болох боловч дэлхийг доргиосон нэгэн том хайгуулын тухай сонирхуулъя. 1995 онд Канадын хөрөнгийн биржид Bre-X компани Индонезид хоёр жил хийсэн хайгуулын үр дүнгээрээ асар том хэмжээний алтны нөөцтэй орд газар илрүүлснээ зарласан юм. Энэ амжилтын үр дүнд нэгж хувьцаа нь хэдхэн цент байсан хувьцааны үнэ 285 канад долларт хүрч, нэг жилийн дотор компанийн зах зээлийн үнэлгээ нь зургаан тэрбум доллар болжээ. 1997 онд тус компанийн алтны нөөц 6000 орчим тонн байгааг тооцоолж, дэлхийн томоохон компаниуд үнэ хаян худалдаж авахаар хөөцөлдөж эхэлж. Ингээд дэлхийн зэс, алтны том компаниудын нэг Freerport –Mc Moran ихэнх хувьцааг нь худалдаж авахаар Due Diligence буюу нарийвчилсан судалгаа хийсэн. Судалгааны үр дүн зарлахаас долоо хоногийн өмнө Bre-X компанийн ерөнхий геологич нь нисдэг тэргэнээс унаж нас баржээ. Харин судлаачид тус ордыг 6000 тонн алтны нөөцгүйг мэдээлсэн юм. Мөн хөндлөнгийн шинжээчид хайгуулын өрөмдлөгийн дээжинд шороон ордын алтны үүрмэг хольсныг баталжээ. Шороон орд нь түлхүү голын усанд угаагддаг бөгөөд мөлгөр гадаргуутай, үндсэн орд буюу газрын гүн дэх алт чулуунд барьцалдаж, ▶▶

▶ ялтсан ширхэгтэй байдгаараа эрс ялгаатай. Дээрх сэдвээр олон жил үргэлжилсэн шүүхийн маргаан олигтой үр дүнд хүрээгүй, харин хөрөнгө оруулсан Канадын том тэтгэврийн сангууд зуу зуун саяаар мөнгөө алдсан гашуун түүхтэй. Энэ явдлаас хойш хайгуулын ажлын тайланг бичих NI43-101, JORC гэх мэт олон улсын хайгуулын ажлын тайлан бэлтгэх стандартууд батлагдаж, бүгд дагаж мөрдөх болсон юм. Бие даасан хөндлөнгийн тайлан бичих зөвшөөрөлтэй мэргэжилтэн нэг удаа хайнга хандах юмуу, хэн нэгний хүсэлтээр дэгсдүүлэн бичиж гарын үсгээ зурсан нь тогтоогдвол энэ салбарт дахин ажиллах эрхгүй болно. Иймд мэргэжилтнүүд маш нухацтай ханддаг болж иржээ.

Миний ажилладаг “Garrison Capital” Австралийн компани дэлхийн олон оронд ашигт малтмал, газрын тосны эрэл хайгуулын чиглэлээр хөрөнгө оруулах судалгаа хийдэг. Голдуу Австралийн хөрөнгийн бирж дээр хувьцаат компани байгуулан хөрөнгө босгож, төслүүдэд зарцуулснаараа хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийг өсгөж ашигтай ажиллах том хариуцлага үүрдэг. Одоогийн байдлаар хөрөнгийн биржийн 12, хувийн хязгаарлагдмал 10 компанийн үйл ажиллагааг удирдан явуулж байна. Монгол оронд 2009 оноос хойш дөрвөн компанийг Австралийн хөрөнгийн бирж дээр байгуулж, нийт 190 сая долларын хөрөнгө оруулалтыг Монголд татжээ. Одоо ажиллаж буй компаниудынхаа түвшинд жилд 30 гаруй оюутныг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулж, өнчин хүүхдийн асрах газарт жилдээ 200 мянган ам.доллар өгч, жилд нийт 1.2 тэрбум төгрөгийг төрөл бүрийн арга хэмжээнд зарцуулж байна. Манай газрын тосны хайгуулын “Wolf Petroleum” компани

Сүхбаатар аймгийн нутаг том хэмжээний судалгааны ажил хийж, 100 км үргэлжилсэн газрын тос байх магадлалтай талбайг илрүүлэн, одоо стратегийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах шатандаа явж буй.

Хөрөнгийн зах зээл

Уул уурхайн салбарт хөрөнгө оруулах хамгийн зохистой хэлбэр нь олон улсын хөрөнгийн зах зээл юм. Хичнээн сайхан эдийн засгийн үр ашигтай төсөлтэй байгаад хөрөнгө оруулагч нар өөрсдөө гүйгээд ирнэ гэж санаа амар хүлээж болохгүй. Түүний төлөө олон улсаар явж, хөрөнгийн зах зээлийг нь сайтар судалж, шаардлагуудыг нь ойлгож, итгэлийг нь олох түвшинд өөрсдийгөө аваачих хэрэгтэй.

Би 2009 онд “Хүннү Коал” компаниа байгуулаад эхний хөрөнгө оруулалтаа хайж банк, санхүүгийн байгууллагуудтай уулзахаар Хонгконгод очих цагаас хөрөнгийн зах зээл дээр мөнгө босгох ажил их нарийн байдгийг бага сагаар ойлгож эхэлсэн. Уул уурхайн төсөл хэрэгжүүлэх компаниудад үндсэндээ гурван сонголт бий. **Нэгдүгээрт**, хэрэв хангалттай өөрийн хөрөнгөтэй бол төслөө 100 хувь эзэмшээд бүх зардлаа хариуцаж, тэр хэмжээгээрээ эрсдлээ үүрч, харин ирээдүйд олсон ашгаа бүгдийг нь өөрөө авна. Энэ бол нэн ховор тохиолдол. **Хоёрдугаарт**, тодорхой хөрөнгөө барьцаанд тавьж, зээл авч санхүүжүүлнэ. Тухайн компани орд газраа илрүүлж чадаагүй, эсвэл төсөл нь бүтэлгүйтвэл барьцаа хөрөнгөө алдана. **Гуравдугаарт**, Хөрөнгийн бирж дээр хувьцаагаа тодорхой үнээр үнэлж, олон нийтэд худалдаж хөрөнгө босгох, эрсдэлээ хуваалцах арга. Энэ нь хамгийн түгээмэл сайн арга бөгөөд төсөл амжилттай бол

хувьцааны үнэлгээ байнга өсч, ирээдүйд ногдол ашиг хүртэх боломж үүснэ.

Хөрөнгийн зах зээл нь илүү шударгаар, нээлттэй ажиллаж хүнээс авсан хөрөнгөө юунд зарцуулснаа тайлагнадаг, олон хүний итгэлийг хариуцлагатайгаар дааж явах шаардлага гардаг, хөл хальтирвал хянаж зохицуулдаг, хяналттайгаар явагддаг үйл ажиллагаатай газар. Сүүлийн хэдэн жил Австралийн бирж дээр бүртгэлтэй хэд хэдэн компаниудын үйл ажиллагаанд оролцож ирсний хувьд энэ талаар анзаарч, мэдэж авсан зарим зүйлсээ та бүхэнтэй хуваалцъя. Дэлхийн зарим нэг биржийн товч мэдээллийг хүргэе.

АНУ-д дэлхийн хамгийн том хөрөнгийн биржүүд бий. Нью Йоркийн Хөрөнгийн бирж нь бүртгэлтэй компаниудынхаа нийт зах зээлийн үнэлгээгээр хамгийн том нь яахын аргагүй мөн. 2013 оны байдлаар энэ бирж дээр нэг өдөрт 170 орчим тэрбум долларын арилжаа явагддаг. 200 орчим жилийн түүхтэй тус бирж саяхан болтол хувьцааны үнийг брокерүүд дунд нээлттэй дуудлага худалдаа хэлбэрээр явуулдаг байгаад, одоо ихэнхдээ компьютерийн сүлжээгээр арилжаа хийж байгаа. Өөр нэг том хэмжээний бирж бол NASDAQ. Уг бирж дээр хувьцаа гаргахад тавих шаардлага хамгийн өндөр, хатуу нөхцөлтэй. Тэр хэмжээгээрээ дэлхийн хамгийн том тэргүүлэх компаниуд голдуу хувьцаа гаргаж, тэдний хувьцааг “Blue-Chip” буюу алдах магадлал хамгийн багатай хувьцаа гэж тооцдог.

Лондонгийн хөрөнгийн биржийг манайхан Монголын хөрөнгийн биржтэй хамтран ажилладгаар нь мэднэ. Сүүлийн жилүүдэд Лондонгийн хөрөнгийн бирж дэлхийн хөгжиж буй том гүрнүүд, ялангуяа Орос, Хятад, Энэтхэгийн компаниудыг онилж, бирж дээрээ үйл ажиллагаа явуулах боломжийг олгож байгаа. Хэдийгээр тавигдах шаардлага нь өндөр ч АНУ дахь өндөр өртөгтэй зарим нэг шаардлага байхгүй тул олон улсын компаниуд хувьцаагаа гаргахад дөхөмтэй гэж үздэг. Арай бага хэмжээний хөрөнгө босгох компаниудад зориулагдсан AIM буюу “Alternative Investment Market” бирж бий. Тэнд уул уурхай, хайгуулын олон компани хувьцаагаа худалддаг. Монголоос “Петро Матад” компани энэ бирж дээр хувьцаагаа гаргаад нэлээд хэдэн жил болж байна.

Хонгконгийн хөрөнгийн бирж бас л АНУ-ыг бодвол арай хөнгөн шаардлагуудтай, гэхдээ миний бодлоор өндөр өртөгтэйгээр бүртгүүлдэг бирж. Хятадын төрийн өмчит том компаниуд, хэд хэдэн банк энэ бирж дээр их хэмжээгээр хөрөнгө босгож чадсан. Ер нь ихэнхдээ банк санхүү, аж үйлдвэр, өндөр ▶

ГАР УТАС БҮРТ АШИГЛАГДДАГ БАЙГАЛИЙН БАЯЛАГ

Арсенопирит
Зэс
Галий
Алт
Магнийн нэгдлүүд
Палладин
Цагаан алт
Мөнгө
Вольфрам



АНУ-д жилд дунджаар 130 сая гар утас ашиглалтаас гардаг ба эдгээр утсанд:
2,100 тонн зэс
46 тонн мөнгө
3,9 тонн алт
2 тонн палладин
0,04 тонн цагаан алт
ашиглагддаг байна.

▶ технологийн чиглэлээр компаниуд хөрөнгө босгож хувьцаа худалддаг тул уул уурхай, хайгуулын компаниуд амжилттай ажиллахад хүндрэлтэй. Учир нь худалдан авагчдын уул уурхайн талаарх ойлголт маш бага багтдаг.

Сүүлийн үед Шанхайн хөрөнгийн бирж дүрэм журмаа шинэчилснээрээ Хятадын компаниудын анхаарлыг татаж, Хонгконгийн биржид том өрсөлдөгч болж хувирч байна. Австрали болон Канад дахь хөрөнгийн биржүүд нь уул уурхайн хайгуулын компаниудад хамгийн тохиромжтой, харьцангуй бага зардлаар хөрөнгө босгох боломжтой зах зээлүүд. Австралын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргахын тулд эхлээд дор хаяж 400 хувьцаа эзэмшигчидтэй байх ёстой бөгөөд удирдлагын баг нь эхний хоёр жилд хувьцаагаа зарах эрхгүй, ингэснээрээ бусдын өмнө хүлээх хариуцлага илүү өндөр байдаг. Хөрөнгийн бирж дээр нэг бол шинээр хувьцаа үнэлэн зарж мөнгө босгох буюу IPO зарчмаар эсвэл хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй боловч үйл ажиллагаа нь амжилтгүй болж, зогсонги байдалд орсноос үнэлгээ нь буурсан идэвхгүй компаниудыг хямд үнээр худалдан авч шинэ чиглэлээр үйл ажиллагааг нь идэвхжүүлэх гарц бий. Аль ч тохиолдолд банкинд хайгуулын, ашиглалтын тусгай зөвшөөрлөө барьцаалж зээл авдагтай огт адилгүй бөгөөд зөвхөн компани бизнес төлөвлөгөө буюу Prospectus, мөн техник шинжээчдийн хөндлөнгийн тайлан, хуулийн шинжээчдийн хөндлөнгийн тайлан гэх мэт бичиг баримтууд шаардагддаг. Иймээс хөрөнгийн бирж дээр хөрөнгөө барьцаанд тавьсан гэж ярьдаг ойлголт огт үндэсгүй зүйл.

Австралийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй нийт компаниудын 60-70 хувь нь жижиг, дунд хэмжээний буюу 100 сая ам.доллараас бага үнэлгээтэй компаниуд байдаг. Нэгж компанийн нийт хувьцааны нэлээд хувь нь чөлөөтэй арилжаалагддаг тул ямар мэдээлэл гаргаж байгаагаас шалтгаалан үнэлгээ нь өсч буурах нь хэлбэлзэлтэй. Жишээ нь хайгуулын нэг компани өрөмдлөгийн ажлаа эхэллээ гэсэн мэдээлэлээр сайн үр дүн гарна гэж итгэж байгаа хүмүүс тасралтгүй хувьцаа худалдан авч 10 цент байсан хувьцааны эрэлт өсч, сарын дотор 15 цент болж мэднэ. Гэтэл үр дүнгээ зарлахгүй удах юм уу, эсвэл хайгуулын үр дүн амжилтгүй болсноо зарлавал бүгд хувьцаагаа хурдтайгаар зарснаас үүдэн хэдхэн хоногийн дотор таван цент юм уу түүнээс доош унах ч эрсдэл бий.

Хувьцаат компанийн гол онцлог нийт хувьцаа эзэмшигчиддээ санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа тогтмол нээлттэй тавих шаардлагатай. Тиймээс амжилтаа зарлаж хувьцааныхаа үнийг өсөхийг харах

сайхан ч, дутагдалтай ажиллагаа, алдагдлаа бас нууж болохгүй учир үйл ажиллагаа, алхам бүртээ хариуцлагатай хандах шаардлага гардаг. Гол нь гаргасан алдаагаа хэрхэн арилгах төлөвлөгөөгөй сайтар танилцуулж чадвал хувьцаа эзэмшигчид сандралд орох нь бага байх магадлалтай. Зөвхөн цаасаар зарлах бус, гол хувьцаа эзэмшигчидтэйгээ байнга уулзаж, ажлаа танилцуулах, хөрөнгө оруулагч нарт компаниа зохион байгуулалттайгаар сайн сурталчлах нь чухал. Хөрөнгийн биржийн бас нэг чухал онцлог зөвхөн компанидаа хөрөнгө босгох, хувьцаагаа арилжаалах боломж бүрдүүлээд зогсохгүй, хувьцаа эзэмшигчдийн нийтлэг эрх ашгийг дээд зэргээр хамгаалахад оршдог. Том, жижиг ч бай хувьцаа эзэмшигчид компанийн тайлан мэдээлэлтэй танилцах боломжоор хангагдсан байх ёстой. Мөн удирдлагуудад асуулт явуулж үйл ажиллагаа, санхүүгийн талаар мэдээлэл хүсэх эрхтэй.

Хайгуулын хувьцаат компанийн өсөлт хөгжлийн сонгодог загварыг графикаар харуулъя. Бүх ажил нь амжилттай явах тохиолдолд хайгуулын үр дүнгээс уурхайн ашиглалтын оргил хүртлээ иймэрхүү замыг туулдаг зарчимтай.

Дүгнэлт

Миний бэлтгэсэн танилцуулга дотроос та бүхэнд мэдлэг олгох, санаа авах зүйлс байсан болов уу. Ярьсан зүйлсээ базаад цөөн үгээр илэрхийлвэл:

- Боловсролыг эзэмшихдээ ирээдүйгээ харж ухамсартай хандаж, болж өгвөл өөрийн үндсэн мэргэжлээрээ ажлыг гололгүй, доороос нь эхэлж том зорилго тавиад тууштай хөдөлмөрлөвөл

амжилтад хүрнэ. Шургуу хөдөлмөрийн үр дүнд гаргасан амжилт эх орныхоо хөгжилд оруулж байгаа хувь нэмэр юм шүү.

- Уул уурхайн салбар шинжлэх ухаан учраас эрүүл саруул ухаанаар хандаж, эрсдэлийг нь зөв үнэлж, ирээдүйг нь дэлхийн тэргүүлэх хөгжилд хөл нийлүүлэх хэмжээнд сэтгэж сурах хэрэгтэй байна. Нэг талаас төр нь бодлогоо зөв тодорхойлж, нөгөө талаас бизнес эрхэлж байгаа компаниуд нь засаглалаа сайжруулж, хариуцлагатай хандан ажиллаж, харин ард түмэн уул уурхай бол зүгээр нэг газар ухаж эрдэнэсийг нь зөөж байгаа асуудал бус, баялаг бүтээж, хүний амьдралд үр шим хүртээх том хэмжээний бүтээн байгуулалт гэдгийг ойлгож хандах нь зүйтэй.
- Хөрөнгө оруулалт татахын тулд үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг ул суурьтай сайн бэлтгэж техник, эдийн засгийн тооцоогоо нийгэм, байгаль орчинд нөлөөлөх хүчин зүйлстэй нь уялдуулан тууштай судалж тооцоолсны үндсэн дээр эргэж буцалгүй зүтгэсэний хүчинд амжилтад хүрэх боломжтой.
- Олон улсын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа санал болгож хөрөнгө босгохын тулд компаниуд төслийн судалгаа тайлангаа өндөр түвшинд бэлдэж, үйл ажиллагаандаа тохирсон зах зээлээ сонгож оролцоходоо, компанийн засаглал, удирдлагын багийн ур чадвар, түншүүдийн туршлага зэргийг нарийн тооцоо хэрэгтэй юм. Хөрөнгийн бирж дээр аливаа эрсдэлийг шантралгүй туулж байж бусдыг амжилтаараа далалсан том тоглогч болох цаг ирнэ гэдэгт итгэж байна. ■

Анхаарал тавьсанд баярлалаа.

2014.09.27 Төрийн Ордон



УЛС ТӨР

ОРЧИН ҮЕИЙН УЛС ТӨРИЙН
НАМУУДЫН ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА

С.ЗУЛЬФИКАР

Удирдлагын академийн Улс төр судлал,
нийгмийн удирдлагын тэнхимийн эрхлэгч
доктор, дэд профессор/

Үргэлжлэл. Түүрүүч нь №15 (073) дугаарт

2008 он хүртэл УИХ-ын сонгууль мажоритар тогтолцоогоор явагдсан нь хоёр нам давамгайлсан улс төрийн намын тогтолцоо төлөвших нөхцөл болсон. Өөрөөр хэлбэл үндэсний түвшинд зохион байгуулагдан сонгуульд оролцох чадавхтай хоёр нам бий болсон юм. Сонгуулийн үр дүн ч мөн адил үүнийг баталж байна. Харин 2012 оны сонгуулийг холимог хэлбэрээр явуулсан нь УИХ-д улс төрийн гурав дахь хүчин өргөн төлөөлөлтэй болох нөхцөл болсон. Гэхдээ 2012 оны хавар өрнөсөн улс төрийн үйл явц улс төрийн гурав дахь нам улс төрд хүчтэй орж ирэхэд нөлөөлөх хүчин зүйл болсон байх ч талтай. Үүнийг цаашид өрнөх улс төрийн үйл явцад нарийн шинжилгээ хийсний үндсэн дээр тодорхойлох боломжтой.

Монголын улс төрийн гол хоёр нам хатуу гишүүнчлэлтэй, төрийн бус (сонирхлын бүлгүүд)-ийг өөртөө нэгтгэх, дэргэдээ байгуулах зохион байгуулалт хэрэгжүүлж байгаа нь тэднийг Скандиновын олон түмний намын хөгжлийн хэв шинжтэй

адилтгаж болохоор болгож байна. Үүний зэрэгцээ улс төрийн гол намуудад газар нутгийн тархалтын хэв шинж ажиглагдаж байна. Тухайлбал, улс төрийн намын тухай хуульд намуудын үйл ажиллагааны зарчмыг тодорхойлохдоо “Нам үйл ажиллагаагаа нутаг дэвсгэрийн зарчмаар явуулна”, 13.6-т “нам энэ хуульд нийцүүлэн өөрийн онцлогт тохирсон зохион байгуулалтын бүтцийг төв, орон нутгийн түвшинд байгуулан ажиллуулна” гэж газар нутгийн тархалтыг шалгуур болгох зохион байгуулалтыг хатуу зааж өгчээ.

Нөгөө талаар 2008 оноос хойш явагдсан сонгуулийн үйл явц, түүний үр дүнд байгуулагдсан засгийн газрын хэв шинж улс төрийн намуудын өвөрмөц харилцааг дэлгэн тавьсан. Улс төрийн намууд нийгмийн бүхий л хүрээнд хүрч, тэдний дэмжлэгийг өөртөө татахыг зорилго болгож байсан нь намууд өргөн хүрээний намын хэв шинжтэй болж байгааг харуулж байна. Үүгээр зогсохгүй өргөн хүрээний, хөтөлбөрт суурилсан, сонгогчдоод үйлчлэх (client) намын хэв шинж зарим тохиолдолд ажиглагдаж байв.

2008 онд улс төрийн гол хоёр хүчин

сонгуулийн үр дүнгээс үл хамааран эвслийн Засгийн газар байгуулсан. Энэ байдал нь бодлогоор нэгдэх картел намын шинжийг илэрхийлж байв. Гагцхүү түүнээс хойш өрнөсөн улс төрийн үйл явц нь намууд бодлогын картел бус ашиг сонирхлын картел үүсгэж байсан болов уу гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Учир нь бодлогын картелд улс төрийн намууд Засгийн газрыг аль болох тогтвортой байлгахыг эрмэлздэг бол ашиг сонирхлын картелд улс төрийн хүчнүүд өөрт ашигтай улс төрийн нөхцөл байдал үүсэхэд эвслээс шууд гардаг. 2012 оны сонгуулийн өмнө ардчилсан нам эвслийн засгийн газраас гарсан үйлдэл нь үүний нэр илрэл болов уу.

Монголд сонгуулийн өмнөх жил, нэг бол сонгуулийн үр дүнгээс шалтгаалан шинээр нам байгуулах практик түгээмэл ажиглагдаж байна. Сонгуулийн өмнө шинээр байгуулагдаж байгаа намууд гол төлөв тодорхой элитүүдийг дагасан, нэг бол тэдний байгуулсан намууд байдаг тул элит намын хэв шинж улс төрийн гурав дахь хүчний дунд ажиглагдаж байна. Тухайн элит (лидер) улс төрийн үйл явцад идэвхтэй оролцохоо больсон нөхцөлд нам нь улс төрийн хувьд ▶



а ч холбогдолгүй болох хандлага ажиглагддаг. Үүнийг гол нь улс төрийн намууд бүрэн төлөвшиж чадахгүй байгаатай холбож үзэх нь зүйтэй.

“Улс төрийн намууд өнөө хэр сайтар төлөвшин цэгцэрч амжаагүй, үүнээс болж намуудыг үнэлэх олон түмний үнэлэмж буурч, намууд ч засаглалын харилцаанд хууль ёсны байр сууриа бүрэн олж авч чадахгүй байгаа нь намын системийн төлөвшлийн үйл явцад тодорхой байдлаар нөлөөлж байна” гэж манай нам судлаачид үзжээ. Иймд манай улс төрийн намууд үзэл санаа, хүний нөөц, үйл ажиллагааны чадавхаа дээшлүүлж, олон нийтийн дэмжлэгийг бодлого, хөтөлбөр үйл ажиллагаагаараа дамжуулан татаж чаддаг байх нь улс төрийн нам төдийгүй улс төрийн үйл ажиллагааны төлөвшилтэд онцгой ач холбогдолтой байхаар байна.

Ямартай ч тус өгүүлэлд хэлэлцэгдэж байгаа орнуудын улс төрийн намуудын хөгжлийн хандлагын нэг

хийх чадавхийг нэмэгдүүлэх бодит хэрэгцээг аяндаа төрүүлнэ. Зарим талаар улс төрийн намууд мэргэшсэн (professional party) байхын тулд судлаачид, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компаниудын дэмжлэгийг авах хандлага түгээмэл болжээ. Нийгэм, эдийн засгийн бодлого тодорхойлж, боловсруулах, олон нийтийн санал бодол, хүсэл сонирхлыг агрегаци хийхийн тулд улс төрийн намууд мэргэшсэн бүтэц, хүний нөөцийн чадавхтай байх эсвэл бэлэн нөөцийг ашиглах шаардлага тавигдаж байгаа юм. Улс төрийн намууд дэргэдээ тинк танк ажиллуулах (заавал улс төрийн намын гишүүн байх шаардлагагүй) замаар мэргэшсэн улс төрийн хүчин байх сорилтыг даван туулж байна.

Улс төрийн үйл явцад намуудын ач холбогдол буурч байна гэж үздэг судлаачид их байдаг. Гэтэл бодит байдал дээр улс төрийн намын үүрэг, ач холбогдол өргөжиж байгааг олон судлаач тэмдэглэж байна. Улс төрийн намууд үйл ажиллагаагаа өргөжүүлэх

чиглэлээр мэргэшсэн чадварлаг бүтэц, хүний нөөцтэй болох нөхцөл болсон. Үүнийг сүүлийн жилүүдийн сонгуулийн үйл явцаас тодорхой харж болно.

Намын чадавхийг дээшлүүлэх үйл ажиллагааг намын төв аппарат төдийгүй орон нутгийн намын байгууллагууд идэвхтэй өрнүүлж байна. Учир нь улс төрийн намууд орон нутагт дэмжлэг авч чадсанаар үндэсний болон орон нутгийн сонгуульд амжилттай оролцох бололцоо бүрдэж байсныг өнгөрсөн хугацааны туршлага, улс төрийн үйл явц харуулсан. Иймд орон нутгийн намын байгууллагыг бэхжүүлэх, хүний нөөцийн сургаж хөгжүүлэх зорилт намуудын хувьд онцгой ач холбогдолтой болсон.

Намууд нийгмийн сууриа өргөжүүлэхэд тухайлан ач холбогдол өгч байна. Үүнтэй уялдан сонирхлын бүлгүүдтэй холбогдсон нийгмийн сүлжээ үүсгэж, түүнийгээ өргөжүүлж чадсан намууд сонгуульд амжилттай оролцон, засгийн эрхийг авч улмаар мөрийн

2008 онд улс төрийн гол хоёр хүчин сонгуулийн үр дүнгээс үл хамааран эвслийн Засгийн газар байгуулсан. Энэ байдал нь бодлогоор нэгдэх картел намын шинжийг илэрхийлж байв. Гагцхүү түүнээс хойш өрнөсөн улс төрийн үйл явц нь намууд бодлогын картел бус ашиг сонирхлын картел үүсгэж байсан болов уу гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Учир нь бодлогын картелд улс төрийн намууд Засгийн газрыг аль болох тогтвортой байлгахыг эрмэлздэг бол ашиг сонирхлын картелд улс төрийн хүчнүүд өөрт ашигтай улс төрийн нөхцөл байдал үүсэхэд эвслээс шууд гардаг.

ях аргагүй улс төрийн агрегаци хийх технологи юм. Үүнийг бодлого, үйл ажиллагааны зохион байгуулалтын орчил гэж ойлгож болно. Эх газрын хэв шинж бүхий намуудад бодлого, шийдвэр дээрээс гарч дунд болон анхан шатны нэгжүүдэд хүрч улмаар олон нийтэд түгдэг зохион байгуулалт тогтсон. Харин улс төрийн намууд өргөн хүрээний хэв шинжтэй болсноор бодлого доороос гарч дээш очих зохион байгуулалт нэвтэрч байна. Учир нь улс төрийн сонгуульд амжилттай оролцох үндэс нь яах аргагүй олон нийт хүсэн хүлээсэн бодлого, стратеги тодорхойлох явдал юм.

Гэхдээ энэ нь улс төрийн агрегаци

шаардлага ч тавигдаж байна. Учир нь нийгмийн сонирхлыг агрегаци хийхийн тулд мэргэшсэн чадварлаг бүтэц, хүний нөөц шаардлагатай болж байгаа юм. Энэ бүтэц нь зарим тохиолдолд байнгын байдаг бол зарим тохиолдолд түр зуурын, тодорхой зорилтыг хангах шинжтэй байна. Иймд намын улс төрийн ажилтнуудын тоог нэмэгдүүлэх, тэдний мэдлэг чадвар, туршлагыг дээшлүүлэх бодит хэрэгцээ урган гарчээ. Ийнхүү баруун Европ, Америк, Скандинов, Пост-коммунист орнуудын улс төрийн томоохон намууд бүхэлдээ энэ өөрчлөлтийг хүлээн авч, туршин хэрэгжүүлж байна. Тухайлбал, нам олон нийттэй харилцах шинэ технологи нэвтрүүлж байгаа нь тэр

хөтөлбөрөө үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой болж байна. Өөрөөр хэлбэл сонгуульд амжилттай оролцох, бодлого хөтөлбөрөө тодорхойлох, хэрэгжүүлэхэд нийгмийн бүхий л хүрээнээс дэмжлэг авах шаардлага тавигдаж байна. Иймд улс төрийн намуудад нийгмийн бүлэг, иргэний нийгмийн дэмжлэг яах аргагүй чухал болжээ. Эцэст нь дүгнэхэд орчин үеийн улс төрийн намууд өргөн хүрээний намын хэв шинжтэй болох хандлага давамгайлж байгаа хэдий ч тухайн орны улс төрийн соёл, нөхцөл байдал, сонгуулийн тогтолцоотой уялдан кадрын, хөтөлбөрийн, олон түмний намын тодорхой хэв шинжийг хадгалсаар байна. ■